

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2023 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1 Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт нийслэл, дүүрэг хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан заалтуудын хэрэгжилт;

Хан-Уул дүүргээс хариуцан хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2050” бодлогын баримт бичигтэй уялдуулан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжилтийг хангулсан.

Тогтоол шийдвэрийн хэрэгжилт:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 01 дүгээр улирлын байдлаар нийт 18 тогтоол шийдвэрийн холбогдох 30 заалтын биелэлтийг нэгтгэн, хяналт-шинжилгээ үнэлгээ хийлгэн, батлуулсан. /Биелэлт дундаж-56%/
Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 01 дүгээр улирлын 8 тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн, Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 04/454 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. /Биелэлт – 82.5%/
2023 оны эхний хагас жилийн байдлаар 30 тогтоол шийдвэрийн холбогдох 68 заалтын биелэлтийг нэгтгэн, хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэн, батлуулсан. /Биелэлт-79.5%/
Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар улирлын 6 тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгтгэн, Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 03/1496 дугаар албан бичгээр хүргүүлсэн. /Биелэлт – 93%/
2023 оны жилийн эцсийн байдлаар 37 тогтоол шийдвэрийн холбогдох 83 заалтыг хяналтад авч, жагсаалтыг Тамгын газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 03/1842 дугаар албан бичгээр Засаг даргын дэргэдэх 28 хэлтэс, албадад хүргүүлэн, биелэлтийг нэгтгэж, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийн тайлагнасан. /Биелэлт-91.9%/
Хүснэгтээр:

ТОГТООЛ, ШИЙДВЭР	ТОО	ЗААЛТ
2023 оны жилийн эцсийн байдлаар		
Монгол Улсын хууль	7	32
Улсын Их Хурлын тогтоол	3	3
Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол	1	1
Ерөнхийлөгчийн зарлиг	5	12
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	1	1
Засгийн газрын тогтоол	15	29
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	2	2

Засгийн газрын албан даалгавар	1	1
Ерөнхий сайдын албан даалгавар	1	1
Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол	1	1
НИЙТ	37	83

Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан:

- ❖ Монгол Улсын Архивын тухай хууль, Хөгжийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374, 2022 оны 470 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Засаг даргын Тамгын газрын 2023 оны Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлуулсан бөгөөд жилийн эцсийн байдааар 13 арга хэмжээний дундаж биелэлт 98,4 орчим хувьтай хэрэгжээд байна.

❖ Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан "Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам", 2020 оны 42 дугаар тогтоолоор өөрчилсөн "Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн програм хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам", Монгол Улсын Их Хурлын 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийн шинэчилсэн найруулгын дагуу албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем <http://erp.ulaanbaatar.mn> системийг Засаг даргын Тамгын газар болон дүүргийн хэмжээнд өнөөдрийн байдааар нийт 107 байгууллага өдөр тутмын үйл ажиллагаандaa хэвшил болгон ажиллаж байгаа бөгөөд уг программыг ашиглахад зөвлөгөө, мэдээлэл, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавин ажилласан.


❖ "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, суурь нөхцлийг бурдүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн дунд хугацааны зорилтот хөтөлбөр болох "Шинэ сэргэлтийн бодлого"-ын "Төрийн бүтээмжийн сэргэлт" зорилтын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 9 дүүргийн 20 хороонд Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015, Үйлчилгээний төгөлдөршлийн ISO 23592:2021 стандартыг нэвтрүүлэх төслийг 2023 оны 04 дүгээр сарын 01-нээс 07 дугаар сарын 01-ний хугацаанд зохион байгуулж "Монсертф" Тохирлын үнэлгээний байгууллагын баталгаажуулалтын зөвлөлийн хурлын 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн D-23/049 дүгээр тогтоолоор стандарт нэвтрүүлсэн анхдагч гэрчилгээ 22, 23 дугаар хороонд 1 жил, 25 дугаар хороонд 3 жилийн хугацаатайгаар олгогдсон.

❖ Засаг даргын Тамгын газар, хороо, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын захиалгыг холбогдох газарт хүргүүлсэн.

Тайлант хугацаанд нийт 11 удаагийн сонгон шалгаруулалтын захиалга хүргүүлсний дагуу 6 удаа тусгай шалгалт зохион байгуулгадж, нийт 73 иргэн шалгалтад тэнцсэн. Үүнээс төрийн захирагааны удирдах албан тушаалд 6, гүйцэтгэх албан тушаалд 34, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн албан тушаалд 33 иргэн тэнцэж Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн албан тушаалд томилох ажлыг зохион байгуулсан.

❖ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 онд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр Хан-Уул дүүрэгт 5 бүлгийн 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.

Зураг . Хан-Уул дүүргийн 14 хороо Айцын аманд байрлах ойн төгөл



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 01 дүгээр албан даалгаврын хүрээнд:

Дүүргийн нутаг дэвсгэрт стандартын шаардлага хангахгүй нүхэн жорлонг буулгах ажлыг зохион байгуулж, 14 дүгээр хороонд Айцын даваанаас Кувейтын ам хүртэлх авто зам дагуу, 8, 21 дүгээр хороонд Жаргалантын ам руу салдаг уулзвараас Айцын даваа хүртэл авто зам дагуу 9 ширхэг ил задгай нүхэн жорлонг буулгаж, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажилласан.

Дүүргийн хэмжээнд 2023 оны 11 дүгээр сарын байдлаар гэр хорооллын айл өрхийн стандартын шаардлага хангасан, хөрсөнд нэвчилтгүй 1523 ширхэг нүхэн жорлон байна

Зураг . Стандартын шаардлага хангахгүй, ил задгай нүхэн жорлон буулгах ажил



Худалдаа үйлчилгээний чиглэлээр:

Шинэчлэн батлагдсан “Зөвшөөрлийн тухай хууль”, “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийг танилцуулах сургалтыг нийт 4 удаа зохион байгуулж хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй давхардсан тоогоор 1050 аж ахуйн нэгжийг хамруулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдэд зориулсан хууль тогтоомж, стандарт шаардлагуудыг багтаасан хялбаршуулсан гарын авлагыг 500 ширхэгийг иргэн, аж ахуйн нэгжүүдэд тарааж сурталчлан ажилласан.

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлчилгээний газруудын үйлчилгээ эрхлэх болон согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг шинэчлэн тогтоохтой холбогдуулан цагийн хязгаарын төсөлд санал авах хэлэлцүүлгийг 2 удаа зохион байгуулж, 476 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан.

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх заалт 2023 оны 11 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр хүссэн жижиглэн худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний газарт тавигдах стандарт шаардлага хангаж буй 7 аж ахуйн нэгжийн хүсэлтийг дэмжин тусгай зөвшөөрлийг олгуулсан.



Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд:

Тамхи худалдах зөвшөөрөл хүссэн 118 иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг дүүргийн Засаг даргын дэргэдэх “Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн хурлаар хэлэлцэж, ерөнхий боловсролын сургуулиас 500 метрийн хол зайд байрлаж буй 59 иргэн, аж ахуйн нэгжид тамхи худалдах зөвшөөрөл олгож, хуулийн хугацаанд шийдвэрлэн, шийдвэрлэлтийг тухай бүр иргэн, аж ахуйн нэгжид мэдэгдэх хуудсаар өгч ажилласан.

Тамхи худалдах зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх талаар саналыг УБ хотын ЗАА-нд хүргүүлж, тамхи худалдах зөвшөөрөл авсан иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг <https://license.mn/> цахим хаягт бүртгэж оруулахаар бэлтгэл ажлыг ханган ажилласан.

Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

Дүүргийн хэмжээнд мал эмнэлгийн ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх гурвалсан гэрээг мал эмнэлгийн 3 нэгжтэй шинэчлэн байгуулж, мал эмнэлгийн ажил үйлчилгээнд 10 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, үйл ажиллагааны зардалд Засаг даргын нөөцөөс 36.8 сая төгрөгийг олгож, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан.

Дүүргийн 2022 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтны тооллогоор тоологдсон 11 аж ахуйн нэгжийн 602136, 73 иргэний 13612 тэжээвэр амьтан, 8 аж ахуйн нэгжийн 901 малын бүртгэлийг мал аж ахуйн салбарын нэгдсэн системд <https://livestock.mofa.gov.mn/login> бүртгэж, Мал эмнэлгийн тасгийн гарал үүслийн гэрчилгээ олголт болон шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан.

- Мал, амьтны гоц халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх 9 удаагийн дархлаажуулалтад 340708 мал, амьтан хамрагдаж, 97.2 хувь, халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх 8 удаагийн дархлаажуулалтад 105425 бог малыг тус тус хамруулж, гүйцэтгэл 98.9 хувь.

- Мал амьтны шимэгчлэх өвчинөөс эмчлэн сэргийлэх ажлын хүрээнд 17669 толгой малыг угаалга, 22559 толгой малыг туулгалтад хамруулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэл 99.8 хувьтай хэрэгжсэн.



Дүүргийн Засаг даргын 2023 оны А/286 дугаар захирамжийн дагуу мал, амьтны сэг зэм устгаж, ариутгал халдвартайжүүлэлт хийх ажлыг Мал эмнэлгийн тасаг, “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ-тай хамtran зохион байгуулж, 1100 гаруй сэг зэм устгаж, 20200м² талбайд ариутгал халдвартайжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



1.2 “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд нийслэл хариуцан хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал;

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс Хан-Уул дүүрэг хамtran хэрэгжүүлэх 2 бүлэг, 3 зорилт, 5 арга хэмжээ эхний улиралд 25 хувь, хагас жилд 52,5 хувь, гуравдугаар улиралд 75 хувь, жилийн эцэст 98 хувьтай тус тус хэрэгжсэн.

Таван жилийн үндсэн чиглэлийн 1 бүлэг, 2 зорилт 4 арга хэмжээ хагас жилээр 45 хувь, гуравдугаар улирлын байдлаар 77,5 хувь, жилийн эцэст 97,5 хувьтай.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 1 бүлэг, 1 зорилт, 3 арга хэмжээ эхний улиралд 50 хувь, хагас жилд 52 хувь, гуравдугаар улиралд 65 хувь, жилийн эцэст 92 хувь, хяналт шинжилгээ, үнэлгээний 5 шалгуур үзүүлэлт 90 хувь тодорхой үр дүнд хүрсэн. Биелэлтийг хяналт шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тайлангуудын хамт удирдлагад танилцуулан нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст сар бүр цахимаар илгээж, тайлагнасан.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ:

“Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг болон Өрхийн эрүүл мэндийн төвүүд коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөө, халдварын сэжиг илрэх үед авах арга хэмжээний алгоритм, коронавируст халдварын үед ажиллах 4 алхам, ариутгал халдвартайжүүлэлт хийх түр заавар, шуурхай хариу арга хэмжээний S76 багийн ажиллах журам, дуудагдах схем зэргийг шинээр боловсруулан тодотгосон.


“Ковид-19” халдварт өвчинеөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу бэлэн байдлын хүрээнд 200 эмнэлгийн ажилтны томилгоог хийж, эм, эмнэлгийн хэрэгслийн 3 сарын нөөц хангальт, хээрийн эмнэлгийн 2 асар, түр байранд 100 ор дэлгэх тооцоог гарган ажилласан.

Дүүргийн хэмжээнд 2023 онд “Ковид-19” халдварт өвчинеөс урьдчилан сэргийлэх вакцинд 1 1-р тунд 19, 2-р тунд 32, 3-р тунд 121, 4-р тунд 35, 5-р тунд 13 иргэн, нийт-220 иргэнийг хамруулсан. “Ковид-19” халдвараар 367 иргэн, SARS COV-2 вирусын “Омикрон” хувилбарын XBB.1.5 дэд хувилбар шинээр 304 тохиолдол бүртгэж, эмчилгээнд хамруулсан. Дархлаажуулалтын ажлын хүрээнд томуугийн вакцинд 21990 иргэн, улаан бурхан улаанууд вакцинд 16776 хүүхэд, сайн дураар иргэдэд гепатит В-ын эсрэг вакцинд 1825 иргэн хамрагдсан.

Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд:

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв нь "И-Клиник" ХХК-тай хамтарч, 2023 оны 1 дүгээр сард шинээр үйлчилгээнд нэвтрүүлэн 20 хоногийн хугацаанд эмнэлэгт үзүүлсэн эрүүл мэндийн хуудсыг цаг алдалгүй хэвлэх, үзлэгийн цаг захиалах, шинжилгээний хариу авах боломжоор хангасан. Программын хөгжүүлэлтийг нэвтрүүлж 19,146 иргэн 32,477 хуудас шинжилгээний хариу хэвлэгдсэн.

Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг нь дүрс оношилгоо факс сервер шинээр үйлчилгээнд нэвтрүүлж эхэлснээр рентген зураг, Эхо зураг хадгалах, эмчийн тэмдэглэл бичих E-health программ дээр шууд харах, төхөөрөмжүүдийн файлыг дижитал хэлбэрт шилжүүлж хадгалах боломж бүрдсэн. E-health программаар 522,368 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.



"Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

"Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээний хүрээнд нийслэлийн ерөнхий боловсролын 15, 18 дугаар сургуулийн 160 суррагчид эрүүл зөв хооллолт, хөдөлгөөн дасгал, сэтгэл зүйн онцлог сэдэвт сургалтыг БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тасаг, сэтгэл зүйч, өсвөрийн зохицуулагч эмч нарын бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, өсвөр үеийн 19 сургагч багшийг бэлтгэсэн.

Гэр оронгүй, архины хамааралтай иргэдийг түр хоноглох үйлчилгээнд хамруулдаг "Өлзийт асар" төрийн бус байгууллагад байрлаж буй иргэд болон дүүргийн нутаг дэвсгэрт орон гэргүй, тэнэмэл байдлаар амьдарч буй иргэдийг сүрьеэгийн эрт илрүүлэгт 5, 10 сард 2 удаагийн арга хэмжээг зохион байгуулж, 200 гаруй иргэнийг хамруулсан.



Нэгдсэн эмнэлгийн яармаг амбулаториод "Эрчүүдийн кабинет"-ийг шинээр байгуулж, дүүргийн төсвийн 22,0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлж, Эрүүл мэндийн төвийн "Эрэгтэйчүүдийн кабинет"-ийг байгуулах засварын ажил хийгдсэн. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээр дүүргийн Эрүүл мэндийн төвийн 1 эмчийг урологийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх 6 сарын сургалтад хамруулсан.

Эрэгтэйчүүд, урологийн эмч нар 11 сарын байдлаар 943 иргэнд үзлэг оношилгоо хийж, мэс засал хийлгэх шаардлагатай нийт 103 иргэнийг лавлагаа шатлалын эмнэлэгт шилжүүлэн ажилласан.

Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөөт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд сууринсан нээлттэй, уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлэх зорилтын хүрээнд:

Нийтийн биеийн тамирын чиглэлээр "Хамтдаа хэвшүүлье" 21 хоногийн аянд 7,879 иргэн, хороод болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ажилтан, албан хаагчдын дундах спортын 3 төрөлт тэмцээнд 253, Сургуулийн өмнөх байгууллагын багш нарын 3 төрөлт тэмцээнд 620 багш, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд 2 арга хэмжээнд 72 иргэн, "Цаг гаргая" аянд 1,537 иргэн, "Эрүүл мэндийн цахим гүйлт"-ийн тэмцээн 209 иргэн, Аж, ахуй нэгжүүдийн 3 төрөлт тэмцээнд 300 гаруй иргэн, "Улаанбаатар марафон-2023" олон улсын гүйлтэд 6,586 иргэн, "Хамтдаа алхаад эрүүлжье" аянд 400 гаруй иргэн, "Мөнгөн Хан-Уул" өвлийн биеийн тамир спортын арга хэмжээг 79 байгууллагын нийт 1,153 иргэн, Өвлийн спортын арга хэмжээнд нийт 28,935 иргэн, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дундах дүүргийн аварга шалгаруулах "Улаанбаатар лиг" сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөгийн төрлүүдэд 159 багийн 2,738 сургач, Бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох хаврын сорилд 18 байгууллагын 351 ажилтан, албан хаагч, дүүргийн залуучуудын сагсан бөмбөгийн Нисэх, яармаг, алсын бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 160 иргэн, Бүтээгч Хан-Уул өдөрлөгт 4820 иргэн, Нийслэлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 6 төрөлт тэмцээнд 72 иргэн, Хан-Уул дүүргийн иргэдийн спортын XI их наадамд спортын 9 төрлөөр (хороо, дүүрэг, нийслэл) гэсэн 3 ўе шаттайгаар 25 хорооны 4900 иргэн, Автомашингүй өдөр нэгдсэн арга хэмжээнд 300 иргэн, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нэрэмжит "Хүмүүнлэгийн од" волейболын тэмцээнд 224 иргэн, Биеийн тамир спортын хорооноос зохион байгуулсан 8 төрлийн сургалтад 62 байгууллагын 156 иргэн, нийт 81 томоохон арга хэмжээнд 78,643 иргэнийг хамруулсан.



"Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн үнэлэхийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд сууринсан тогтолцоонд шилжүүлэх зорилтын хүрээнд:

Боловсролын салбарт 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, удирдах ажилтнуудаас үндсэн сургалтад 651 багш, ерөнхий боловсролын 59 сургуулийн 2659 багш, 119 цэцэрлэгийн 1057 багш, нийт 4367 багш зорилтот болон графикт сургалтад хамрагдсан.

2023-2024 оны хичээлийн жилд багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих төлөвлөгөөний хүрээнд 1868 багш 5 удаагийн модуль сургалтад, цахимаар хамрагдах захиалгыг Боловсролын мэдээллийн системд бүртгүүлж, хуваарийн дагуу төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 61 сургуулийн 2952 багшийг сургалтад хамруулсан.

Эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байрыг байгуулж, хуульд заасны дагуу мэдээллээр хангах зорилтын хүрээнд:

Хан-Уул дүүргийн 7 дугаар хороонд байрлах гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвөөр 0-18 насны 91 хүүхэд, 3 насанд хүрэгч /эрэгтэй-37, эмэгтэй-57/ үйлчлүүлсэн.

Нэг цэгийн үйлчилгээний төв, Хүүхэд тусlamжийн 108 утсанд бүртгэгдсэн 1015 дуудлага мэдээлэл бүртгэгдэж, хороодын хамтарсан баг хяналт тавин ажилласнаар 646 дуудлагыг хааж, 369 дуудлага хяналтад байна.

Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон сэтгэл зүйн зөвлөгөө авах хүсэлт гаргасан 5987 иргэн /хүүхэд-1509, насанд хүрэгч-4478/-д сэтгэл зүйн ганцаарчилсан болон бүлгийн анхан шатны зөвлөгөө өгч ажилласан.

Дүүргийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд:

Хүнсний аюулгүй байдал, үнийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хүнсний дэлгүүр, худалдааны төвийн үйл ажиллагаа эрхлэгч 486 иргэн, аж ахуйн нэгжид хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүнийг худалдан борлуулахгүй, дотоод хяналтыг сайжруулах, үнийн мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгаж, иргэдийг үнэн зөв мэдээллээр ханганд ажиллах тухай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 08/119 дүгээр албан бичгийг хүргүүлэн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангуулах, иргэд, хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангах хүрээнд худалдаа, үйлчилгээний 140 гаруй газарт хяналт шалгалтыг зохион байгуулж, зөрчлийг арилгуулан, зөвлөн тусалсан.



орон нутгийн малчдын махыг дундын зуучлалгүйгээр хэрэглэгчдэд хүргэх зорилгоор “Өвлийн идэш-2023” өргөтгөсөн худалдааг 2 байршилд зохион байгуулж, хяналт тавин ажилласан.

Нөөцийн махны худалдааг хүнсний дэлгүүр, сүлжээ 33 дэлгүүрээр 52.9 тонн мах, өргөтгөсөн худалдааг 14 байршилд 141.9 тонн нийт 194.8 тонн махыг худалдаалах ажлыг зохион байгуулж, махны чанар аюулгүй байдалд хяналт тавьж, иргэдийн гомдол санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэсэн.



Төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа болон жижиглэн 9 байршилд зохион байгуулж, нийт 115 газар тариалан эрхлэгчийн 756тн төмс, хүнсний ногооны худалдан борлуулалтад дэмжлэг үзүүлсэн.



Хүн амын хоол хүнсний талаарх мэдлэг боловсролыг дээшилүүлэх, хоол үйлдвэрлэлд эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр:

Хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хангах, хоолны илчлэг шим тэжээллэг чанарыг сайжруулах, хүнсний эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, ажилтан албан хаагчдын ур чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран 8 удаагийн сургалтыг зохион байгуулж, хоол үйлдвэрлэл, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй давхардсан тоогоор 645 иргэн, аж ахуйн нэгжийн нийт 1075 ажилтан албан хаагчдыг хамруулсан. Үүнд:

- Худалдаа үйлчилгээний газрын шинэчлэн батлагдсан хотын стандарт танилцуулах 4 удаагийн сургалтад 596;
- Худалдаа үйлчилгээний газруудад хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, орчны цэвэрлэгээ үйлчилгээг хангуулах, зөвлөн туслах сургалтад 87;
- Зочлох үйлчилгээний салбарын ажилтан албан хаагчдыг чадавхжуулах, туршлага судлах үзүүлэх сургуулилтад 90;

Тохижилт ,нийтийн аж ахуйн чиглэлээр:

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр: Монгол улсын Засгийн газрын “Түүхий нүүрсийг хориглох тухай” 62, 223-р тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/1349, А/1357, дүүргийн Засаг даргын А/460, А/532 дугаар захирамжуудын хэрэгжилтийг ханган дүүргийн хэмжээнд 2023 оны галлагааны улиралд 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 23 дугаар хороодод сайжруулсан шахмал түлшний 50 борлуулалтын цэг ажиллаж, хэрэглэгчдийг 30,659.9 тн сайжруулсан түлшээр хангасан. Түлшний нийлүүлэлт, түгээлтэд тогтмол хяналт тавьж, нөөцийн мэдээллийг өдөр тутам гаргаж ажиллаж байна.

Зураг . Сайжруулсан шахмал түлшний борлуулалтын цэг




Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 9, 10, 12, 13, 21 дүгээр хорооны 9 агуулахад 17000 тн сайжруулсан түлш нөөцөлсөн.

Зураг . Сайжруулсан шахмал түлшний нөөцийн агуулах




Нийслэлийн Засаг даргын 2022 оны A/1561 дүгээр захирамжийн хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд утааны эх үүсвэрийн улсын тоо бүртгэлийг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр хүртэл хугацаанд явуулж, 3-15 кВт хүчин чадалтай зуухтай 16,228, 15-100 кВт хүчин чадалтай зуухтай 705 өрх, аж ахуйн нэгж, байгууллага, 100-4200 кВт хүчин чадалтай уурын халаалтын зуухны байгууламжийн 53 зуухыг тоолж, цахим мэдээллийн санд оруулсан.

Зураг . Агаар, бохирдуулагч эх үүсвэрийн зуухны төрлөөр гарсан тооллогын дүн



Ердийн галлагаатай 3-15 кВт хүчин чадалтай 16228 зуухтай айл өрх тоологсон нь 2022 оньхос 862 өрхөөр бага тоологсон байгаа ба үүнээс дахин төлөвлөлтөд хамрагдсан 452 айл өрх, 410 айл өрх нь цахилгаан халаалт, хийн халаагуур, эрчим хүчиний хэмнэлттэй халаагуурт холбогдсон байна.

Зураг 16. Агаар, бохирдуулагч эх үүсвэрийн сууцны төрлөөр гарсан тооллогын дүн



Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2022 оны А/576 дугаар захирамжаар угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, сайжруулсан түлшний хэрэглээнд хяналт тавих Шуурхай штабыг байгуулж, 2023 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд ажиллуулсан. Шуурхай штаб ажиллах хугацаанд 40 иргэн угаарын хийн хордлогод өртөж, эрүүл мэндийн байгууллагад хандаж, 31 иргэн нь тусlamж авч буцсан, 9 иргэн нь хэвтэн эмчлүүлсэн. Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, 324 иргэнийг хамруулж, 3 удаагийн давтамжтай 6 төрлийн зөвлөмжийг цахимаар, 17000 гаруй өрхөд 51000 гаруй гарын авлага, өгч зөвлөмжийг цаасаар хүргүүлсэн.

Цагдаагийн 2 дугаар хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Таван толгой түлш ХХК-тай хамтран 4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16 дугаар хорооны өндөр настан ганц бие, олон хүүхэдтэй зэрэг угаартах эрсдэл бүхий 948 өрхөд "Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, угаар мэдрэгчээ зөв ажиллуулах, зууханд дулаан баригч бортого суурилуулах талаар сургалтуудыг зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд угаарын хийн мэдрэгчийг зөв ажиллуулах, зуухны битүүмжлэлийг сайжруулах чиглэлээр зөвлөмж өгч, 16228 өрхөөс угаарын хийн мэдрэгчгүй байсан 1969 өрхийг 100 хувь угаар мэдрэгчтэй болгож, 9, 10, 12, 14 дүгээр хорооны өндөр настай 566 иргэний зууханд дулаан баригч бортого суурилуулсан.



Дүүргийн нутаг дэвсгэрт цахилгаан хийн халаалт, дулаалга үйлдвэрлэл импортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 13 аж ахуйн нэгж байгууллагатай хамтран 2023 оны 06 дугаар сарын 17-ны өдөр "Байгальд ээлтэй дэвшилтэт техник технологийн үзэсгэлэн худалдаа" арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд "Кореа Кабель" ХХК, "Мега хет" ХХК, "Мөнхийн амар дулаан" ХХК, "Бурханы гол" ХХК, "Цахилгаан халаалт үйлдвэрлэгчдийн холбоо", "Тасума" ХХК, дулаалгын материал үйлдвэрлэгч "Гэгээн өргөө" ХХК, "Голден блок" ХХК, сайжруулсан зуухны "Роял өүшн" ХХК, Хаан банкны ногоон зээл хариуцагч, "Янгир хайрхан" ХХК-ийн хүнсний худалдаа зэрэг 8 байгууллага, 12 хорооны 16,000 гаруй иргэд оролцсон.

Зураг . "Байгальд ээлтэй дэвшилтэт техник технологийн үзэсгэлэн худалдаа" арга хэмжээ



2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар, нийслэлийн Онцгой байдлын газартай хамтарч "Шалгавал эрсдэлгүй" өдөрлөг, "Эрсдэлгүй Улаанбаатар" аяныг тус тус зохион байгуулж, холбогдох байгууллагуудын төлөөллүүд болон гэр хорооллын 2980 гаруй иргэд оролцож, угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөмж өгч ажилласан.

Гэр хорооллын айл өрхүүдэд хороодоор дамжуулан нийслэлийн Агаар орчны бохирдолтой тэмцэх газраас ирүүлсэн "Зөв галлая", "Угаарын эрсдэлээс урьдчилан сэргийлье", "Яндангаа зөв хөөльье", "Пийшин зуухны зөв хэрэглээ" гэсэн 4 төрлийн 26000 ширхэг гарын авлагыг тарааж, зөвлөмж хүргүүлсэн.

1.3 Улс, нийслэл, дүүргийн төсөв, орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалт, зээл тусламж болон өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын төлөвлөлтийн оновчтой байдал, гүйцэтгэл, чанар, үр дүн;

Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжих 42,737.1 сая төгрөгийн 105 төсөл арга хэмжээ батлагдсан бөгөөд 36 төсөл арга хэмжээ хянагдаж, 20,035.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан. 31 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж гүйцэтгэгчид 9,417.2 сая төгрөг, 16 төсөл арга хэмжээнд 10,802.2 сая төгрөгийн явцын нийт 20,219.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022-2023 он дамжин хэрэгжих 1,710.1 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, 2023 онд хэрэгжих 1,962.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээ нийт 3,673.1 сая төгрөг батлагдсанаас 489.2 сая төгрөгийн гэрээ байгуулан бүрэн хэрэгжсэн 3 төсөл арга хэмжээнд 506.2 сая төгрөг, 1 төсөл арга хэмжээнд 276.5 сая төгрөг нийт 782.8 сая санхүүжилт олгосон.

Дүүргийн ИТХ-ын 2022 оны 12 сарын 16-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдаж, 2023 оны 02 дугаар сарын 14-ны 06 дугаар тогтоол, 3 дугаар сарын 02-ны 08 дугаар тогтоол, 8 дугаар сарын 19 дүгээр тогтоолоор тус тус тодотгол хийгдэж орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинээр 41, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр 2 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан. Үүнд:



Хүснэгтээр харуулбал:

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хороо	Төсөвт өртөг	2023 онд санхүүжүүлэх дүн	Ажлын явцын тайлбар
1	5	4			12
Хэрэгжиж дууссан					
1	Буянт-Ухаа 7-р сургуулийн спорт заалны засвар	16	374,000.0	374,000.0	Гүйцэтгэгч "Глобалгейтвэй" ХХК. Хэрэгжиж дууссан.
2	Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн шинэчлэл засварын ажил	23	375,000.0	375,000.0	"Гүйцэтгэгч Глобалгейтвэ Хэрэгжиж дууссан.
3	23 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвд жирэмсэн болон эх хүүхдийн үзлэгийн кабинет худалдан авах	23	160,000.0	160,000.0	Гүйцэтгэгч "Глобалгейтвэй" ХХК. Хэрэгжиж дууссан.

4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлэх нэг цэгийн барилгын дотор сантехник дулааны ажил	6	75,000.0	75,000.0	Гүйцэтгэгч "Глобалгейтвэй" ХХК. Хэрэгжиж дууссан.
5	Нийтийн зориулалттай орон сууцны дулаалга, фасад засвар /2, 3, 17-р хороо/	2, 3, 17	911,000.0	911,000.0	Гүйцэтгэгч "Глобалгейтвэй" ХХК. Хэрэгжиж дууссан.
6	Нийтийн зориулалттай орон сууцны дулаалга, фасад засвар /12, 13-р хороо/	12, 13	1,200,000.0	1,200,000.0	Гүйцэтгэгч "Глобалгейтвэй" ХХК. Хэрэгжиж дууссан.
7	Эрүүл мэндийн төвийн гадна фасад, гадна тохижилтын засварын ажил	20	962,700.0	962,700.0	Гүйцэтгэгч "Глобалгейтвэй" ХХК. Хэрэгжиж дууссан.
8	Хороодын хэсгийн ахлагч болон төрийн албан хаагчдын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж худалдан авах	-	300,000.0	300,000.0	Гүйцэтгэгч "Би Си Ти" ХХК. Хэрэгжиж дууссан.
9	Мод үржүүлгийн талбайд ашиглах трактор, механизм худалдан авах	-	215,000.0	215,000.0	Гүйцэтгэгч "Монтех дистрибуишн" ХХК. Хэрэгжиж дууссан.
10	Соёлын ордонд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	19	265,800.0	265,800.0	Гүйцэтгэгч "Эм И Си Ти Эс" ХХК. Хэрэгжиж дууссан.
11	Хог тээврийн машин худалдан авах /Багц-1/	-	800,000.0	800,000.0	Гүйцэтгэгч "Би Ти Эс Эм" ХХК. Хэрэгжиж дууссан.
12	Цагдаагийн хэлтэст шаардлагатай техник хэрэгсэл худалдан авах	20	99,400.0	99,400.0	Гүйцэтгэгч "Голден хоул" ХХК. Хэрэгжиж дууссан.
13	Хан-Уул дүүргийн татварын хэлтэст шаардлагатай компьютер тоног төхөөрөмж худалдан авах	-	100,000.0	100,000.0	Гүйцэтгэгч "Саммит компьютер технологи" ХХК. Хэрэгжиж дууссан.
14	Явган хүний зам талбайн засвар, шинэчлэл /1, 2, 3-р хороо/	1, 2, 3	708,500.0	708,500.0	Гүйцэтгэгч "Нутгийн баруун мод" ХХК. Хэрэгжиж дууссан.
15	29, 73-р цэцэрлэгийн гадна талбайн тохижилтын ажил /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг/	5, 7	536,000.0	536,000.0	Гүйцэтгэгч Гарден сити ХХК. Хэрэгжиж дууссан.
16	Дэнжийн цэцэрлэгт хүрээлэнгийн засвар, тохижилтын ажил/8-р хороо/	8	500,000.0	500,000.0	Гүйцэтгэгч "Прогресс Интер Медиши" ХХК. Хэрэгжиж дууссан.
17	15, 16, 20, 21 дүгээр хороодын шилэн кабель татах ажил	-	120,000.0	120,000.0	Гүйцэтгэгч "Виртуал" линк ХХК. Хэрэгжиж дууссан.
18	Борооны ус зайлцуулах шугам сүлжээний ажил	16	672,900.0	672,900.0	Гүйцэтгэгч "Нүнжиг" ХХК. Хэрэгжиж дууссан.

ХЭРЭГЖИЖ БҮЙ-19

19	Гадна талбайн тохижилтын ажил /10-р хороо 60/2 дугаар байр, 13-р хороо 144-р цэцэрлэг, 14-р хороо 59-р сургууль/	10, 13, 14	935,000.0	935,000.0	Гүйцэтгэгчээр "Велко Инк" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 90 хувь.
20	Явган хүний зам талбайн засвар, шинэчлэл /23, 24-р хороо/	23, 24	690,000.0	690,000.0	Гүйцэтгэгч: "Жаргалант дулаан" ХХК гэрээ байгуулсан. Ажлын явц 80 хувь.
21	Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажил	20	1,212,400.0	1,212,400.0	Гүйцэтгэгчээр "Рокгранд" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Дотор засварын ажил хийгдэж байна. Ажлын явц 70 хувь.

22	34 дүгээр сургуулийн хүзүүвч барих	4	616,500.0	616,500.0	Гүйцэтгэгчээр "Зорь бүтээз" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 70 хувь.
23	10 дугаар сургуулийн хучин барилгын дээвэр, фасад засварын ажил	12	244,000.0	244,000.0	Гүйцэтгэгчээр "Лантмон" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 70 хувь.
24	Ажилчны алдар талбайн тохижилт /2-р хороо/	2	903,700.0	903,700.0	Гүйцэтгэгчээр "Ханбилүү" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 70 хувь.
25	Нийтийн зориулалттай орон сууцны дулаалга фасад засвар /нисэхийн бүс/	Нисэхийн бүс	2,800,000.0	2,800,000.0	Гүйцэтгэгчээр "Гегатера тех" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Фасад засварын ажил хийгдэж байна. Ажлын явц 50 хувь.
26	Камерын нэгдсэн хяналтын төв рүү шилэн кабел татах, засвар тохижилт	16	75,000.0	75,000.0	Гүйцэтгэгчээр "Инносольюшин" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 50 хувь.
27	Цахилгааны хүчдэл сайжруулах /12-р хороо/	12	146,000.0	146,000.0	Гүйцэтгэгчээр "Холбоо трейд" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 50 хувь.
28	2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилт, засварын ажлын зураг төсөв /Багц-1/	Нисэх, алслагдсан бүс	100,000.0	100,000.0	Гүйцэтгэгчээр "Эм Ай Эл" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 50 хувь.
29	Тайлан гарын авлага, брошюр хэвлэх төхөөрөмж худалдан авах	-	350,000.0	350,000.0	Гүйцэтгэгчээр "Санкомаркетинг монголия" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Нийлүүлэлх шатанд
30	Еренхий боловсролын сургууль, цэцэрлэгт компьютер, тоног төхөөрөмж худалдан авах	-	80,000.0	80,000.0	Гүйцэтгэгчээр "Дижитал сервис" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Нийлүүлэлх шатанд
31	Дүүргийн төрийн байгууллагын болон нэг цэгийн үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	-	400,000.0	400,000.0	Багц 1 "Саммит компьютер технологи" ХХК Багц 2" Спайд-Аксон" гэрээ байгуулсан. Тоног төхөөрөмж нийлүүлэх шатанд байна.
32	Сагсан бөмбөгийн 3x3 талбай байгуулах (нисэх, ярмагийн бүс)	нисэх, ярмагийн бүс	350,000.0	350,000.0	Гүйцэтгэгчээр "Нано Бриллиант Констракши" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 30 хувь.
33	Наадамчдын авто замаас нутг чиглэлийн авто замын гэрэлтүүлийн ажил (23 дугаар хороо)	23	90,000.0	90,000.0	Гүйцэтгэгчээр "Ингүүмэл эрчим" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 10 хувь.
34	Наран хотхон, 8, 18-р байрны гадна талбайн тохижилт, засвар шинэчлэлтийн ажил /1-р хороо/	1	270,000.0	270,000.0	Гүйцэтгэгчээр "Хөх бугат" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 5 хувь.
35	Гарааш буулгасан байршуудад тохижилтын ажил хийх	-	500,000.0	500,000.0	Гүйцэтгэгчээр "Гарден Сити" ХХК ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажлын явц 30 хувь.

36	Цэцэрлэгийн барилга	Нисэхийн бус	2,200,000.0	1,000,000.0	Гүйцэтгэгчээр "Инерци" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Газар чөлөөлөх ажил хийгдэж байна.
37	Явган хүний зам талбайн засвар, шинэчлэл /11, 19, 20-р хороо/	11, 19, 20	856,000.0	856,000.0	Гүйцэтгэгчээр "Ээко эвсэг" зам ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажил эхлээгүй.

ГЭРЭЗ БАЙГУУЛАХ ШАТАНД-4

38	2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилт, засварын ажлын зураг төсөв	Яармагийн бус	100,000.0	100,000.0	Гүйцэтгэгчээр "Скайлайн Дизайн" ХХК шалгарсан. Гэрээ байгуулах шатанд.
39	Автобусны буудал, зам талбайн тохижилтын ажлын зураг төсөв (13, 16 дугаар хороо)	13, 16	60,000.0	60,000.0	Гүйцэтгэгчээр "Ихэр менх" ХХК шалгарсан. Гэрээ байгуулах шатанд.
40	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга зураг, төсөв (Нисэх)	-	60,000.0	60,000.0	Гүйцэтгэгчээр "Нью товер" ХХК шалгарсан. Гэрээ байгуулах шатанд.
41	Хүүхдийн тоглоомын талбай, спорт талбайн засварын ажлын зураг, төсөв	-	70,000.0	70,000.0	Гүйцэтгэгчээр "Нью товер" ХХК шалгарсан. Гэрээ байгуулах шатанд.

ҮНЭЛГЭЭ ХИЙГДЭЖ БАЙГАА-13

42	Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга барих (23 дугаар хороо)	23	597,000.0	597,000.0	1 ААНБ материал ирүүлсэн
43	Ашиглалтын шаардлага хангахгүй 7 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгыг буулгах	-	200,000.0	200,000.0	Хураангуй 7 ААНБ материал ирүүлсэн
44	Нийтийн эзэмшилийн зам, талбайд өрзөлтүүлэг хийх (13 дугаар хороо)	13	500,000.0	500,000.0	"Спэйшлтим Ап" ХХК шалгарсан. Гомдол гарсан. Дахин төндер зарлах шатанд байна.
45	Чингисийн хүрээний авто замаас эко ахмадын сувилал хүртэлх авто замын ажил	8	3,526,600.0	1,063,300.0	3 ААНБ материал ирүүлсэн
46	2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилт, засварын ажлын зураг төсөв	Төвийн бус	150,000.0	150,000.0	
47	480 хүүхдийн суудалтай сургуулийн холболтын зураг, төсөв	16	130,000.0	130,000.0	Хураангуй 4 ААНБ материал ирүүлсэн
48	Био комбинатын авто замын зураг, төсөв	12	50,000.0	50,000.0	Хураангуй 2 аж ахуй нэгж материал ирүүлсэн
49	25 дугаар хороо, авто замын зураг, төсөв	25	80,000.0	80,000.0	Дэлгэрэнгүй 1 ААНБ материал ирүүлсэн
50	Хороолол дундах авто зам засвар, шинэчлэлтийн зураг, төсөв (1, 2-р хороо)	1, 2	70,000.0	70,000.0	Дэлгэрэнгүй 6 ААНБ материал ирүүлсэн
51	Хороолол дундах авто зам засвар, шинэчлэлтийн зураг, төсөв (15, 17-р хороо)	15, 17	70,000.0	70,000.0	Дэлгэрэнгүй 6 ААНБ материал ирүүлсэн
52	Хороолол дундах авто зам засвар, шинэчлэлтийн зураг, төсөв (19, 20-р хороо)	19, 20	70,000.0	70,000.0	Дэлгэрэнгүй 6 ААНБ материал ирүүлсэн
53	Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд автомашин худалдан авах	-	80,000.0	80,000.0	2 ААНБ материал ирүүлсэн.
54	Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэгт шаардлагатай	23	400,000.0	400,000.0	Ай Эм Эс инженеринг ХХК гомдол гарсан

	тоног төхөөрөмж худалдан авах				гомдол үндэслэлтэй дахин үнэлгээ хийж байгаа
55	Камерын хяналтын нэгдсэн төв, камержуулалтын ажил	-	1,000,000.0	1,000,000.0	4 ААНБ материал ирүүлсан
ТЕНДЕР ЗАРЛАСАН-4					
56	Нийтийн зориулалттай орон сууцны засвар	-	2,000,000.0	2,000,000.0	
-	2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилт, засварын ажлын зураг төсөв /Багц-2/	Нисэх, алслагдсан бус	50,000.0	50,000.0	
57	Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын зураг, төсөв	-	460,000.0	460,000.0	
-	Хог тээврийн машин худалдан авах /Багц-2/	-	1,200,000.0	1,200,000.0	
ТЕНДЕР ДАХИН ЗАРЛАХ ШАТАНД-4					
58	Дүүргийн спорт хорооны барилгын спорт заал, дотор их засварын ажил	20	870,000.0	870,000.0	
59	20 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвд жирэмсэн болон эх хүүхдийн үзлэгийн байр худалдан авах	20	414,400.0	414,400.0	
60	Хяналтын камерын нэгдсэн төв, нисэх, алслагдсан бусийн камержуулалтын зураг, төсвийн ажил	-	70,000.0	70,000.0	Хураангуйд 1 аж ахуй нэгж материал ирүүлсан. Хураангуй 2023.11.22-ны өдөр татгалзах мэдэгдэл хүргүүлсэн
61	120 мяангат 20, 21-р байр орчмын зам талбайн засвар шинэчлэлт, тохижилтын ажил /1-р хороо/	1	448,152.8	448,152.8	
БЭЛТГЭЛ АЖИЛ ХАНГАГДАЖ БАЙГАА-2					
62	Эко ахмадын сувилал руу 400 кВА цахилгааны шугам татах ажил (8 дугаар хороо)	8	315,000.0	315,000.0	Техникийн нөхцөл авсан.
63	Цахилгааны хучдэл сайжруулах ажил (13 дугаар хороо)	13	800,000.0	800,000.0	Оргилт од ХХК зураг төсөв боловсруулж байна.
БУСАД-2					
64	Хог тээврийн авто машинуудын авто бааз байгуулах (10 дугаар хороо)	10	1,950,000.0	1,950,000.0	
65	Зураг төсөв /Магадалшүй ажил/	-	300,000.0	300,000.0	Дүүргийн Засаг даргын А/71 захирамжаар задарсан
ХЭРЭГЖҮҮЛЭХГҮЙ БАЙХААР ШИЙДВЭРЛЭСЭН-2					
66	75 дугаар сургуулийн гадна спорт талбайн тохижилт /2-р хороо/	2	761,000.0	761,000.0	Гэрээ цуцалсан. Хэрэгжихгүй
67	Нисэхийн тойргийг олон түвшингт уулзвар болгох зураг, төсөв	8,21, 25	190,000.0	190,000.0	

Гудамж, зам, талбайн тохижилтын чиглэлээр:

Дүүргийн төсвийн 5.2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 1, 2, 5, 7, 8, 10, 13, 14, 16 дугаар хороодын 11 байршилд 2023 онд тохижилтын чиглэлээр шинээр хэрэгжих 8 төсөл арга

хэмжээнээс 4 төсөл арга хэмжээ дуусаж, 2 төсөл арга хэмжээ гүйцэтгэлийн шатанд он дамжих, 1 төсөл арга хэмжээ гүйцэтгэгч шалгаруулах шатанд хэрэгжиж байна.

Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 10, 24 дүгээр хорооны 2 байршилд иргэд, олон нийтэд зориулсан тоглоомын талбай, амралтын талбайн тохижилтын ажил хэрэгжиж ашиглалтад орсон.

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 309.2 сая төгрөгийн хөрөнгөөр 19 дүгээр хороонд 27/1 байрны гадна тоглоомын талбайн засвар шинэчлэлт, 18 дугаар хороонд 29, 30 дугаар байрны гадна талбайн тохижилт, 22 дугаар хороонд Зайсангийн автобусны буудлын тохижилт, 12 дугаар хороонд Био салбар эмнэлгийн гадна талбайг тохижуулж, ашиглалтад оруулсан, 19 дүгээр хорооны 70, 85 дугаар байрны голын талбайн тохижилтын ажил гүйцэтгэгч шалгаруулах худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Хан-Уул дүүргийн 5 дугаар хороонд 41 дүгээр сургуулийн баруун талд цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар суурийн ажил бүрэн хийгдэж, 700 м.кв авто зогсоол, 300 м.кв налууд эко хавтангийн хучилтын ажил, 130 м.кв талбайд явган хүний зам тавих ажил, 5x5 сагсан бөмбөгийн талбайн цутгалтын ажил бүрэн дуусаж, сагсан бөмбөгийн талбайн хашаа барих ажил үргэлжилж байна.

Зураг. 12-р хороо, Амралт хэсэг



Зураг.12-р хороо, Сонгино хэсэг



Зураг .14-р хороо, 2 дугаар хэсэг



Нийтийн зориулалттай орон сууцны дулаалга, фасад засварын ажлын хүрээнд:

Дүүргийн төсвийн 6,911.0 сая төгрөгийн хөрөнгөөр оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжих 4 төсөл арга хэмжээний хүрээнд 2, 3, 10, 12, 13, 17 дугаар хорооны 15 байрны фасад засвар,

дулаалга, 1, 2, 19, 25 дугаар хорооны 15 байрны дээвэр засварын ажлын гүйцэтгэхээр төлөвлөгдсөн. Үүнд:

- Нийтийн зориулалттай орон сууцны дулаалга, фасад засвар /2 дугаар хороо 9 дүгээр байр, 3 дугаар хороо, 1а байр, 17 дугаар хороо, 8-1-2 дугаар байрууд/-ын ажлыг "Зост өргөө ХХК" гүйцэтгэж дууссан.
- Нийтийн зориулалттай орон сууцны дулаалга, фасад засвар /12 дугаар хороо, 38, 52, 53 дугаар байр, 13 дугаар хороо, 2, 5, 6 дугаар байрууд/-ын ажлыг "Юу Би Жи ХХК" 85 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж, 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр байнгын ашиглалтад хүлээж авах комисс ажиллана.
- Нийтийн зориулалттай орон сууцны дулаалга, фасад засвар /10 дугаар хороо 1, 7, 62, 63, 64 дүгээр байр/-ын ажлын гүйцэтгэгчээр Гегатера ХХК шалгарч, 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон.
- Нийтийн зориулалттай орон сууцны засварын ажлын гүйцэтгэгч шалгаруулах тендер үнэлгээ хийгдэж байна.

Зураг. 12-р хороо, 53-р байр



Зураг . 3-р хороо 1а байр



Явган хүний зам талбайн засвар шинэчлэлтийн ажлын хүрээнд:

Дүүргийн төсвийн хөрөнгө, дүүргийн орон нутгийн хөгжлийн сан, тохижилт, засвар шинэчлэлтийн зардлын 4,632.7 сая төгрөгийн хөрөнгөөр явган хүний замыг засварлаж шинэчлэх чиглэлээр 11 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн.

Үүнээс 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар 1, 2, 3, 11, 16, 22 дугаар хорооны 14 байршлын 9054.2 м.кв (4.97 км) явган хүний замыг засварлаж шинэчлэх 5 төсөл арга хэмжээ дуусаж, 11, 19, 20, 22, 23, 24 дүгээр хорооны 10 байршлын 16833.09 м.кв (5.2 км) явган хүний шинэчлэх 3 төсөл арга хэмжээ гүйцэтгэлийн шатанд он дамжин хэрэгжих, 1, 2, 3, 6, 9, 15, 16, 19, 20 дугаар хорооны 10 байршлын 3805 м.кв (2.1 км) явган хүний замыг засварлаж шинэчлэх 3 төсөл арга хэмжээ худалдан авах ажиллагааны шатанд тус тус хэрэгжиж байна.


Зураг. 1,2,3-р хороо, дунд голын авто замын хойд талын явган хүний замын засвар,шинэчлэлт



Зураг. 2-р хороо, 12а 12б 12в байр орчимд /684 м.кв/



Зураг . Хан-Уул дүүрэг, явган замын тохижилт, засвар, шинэчлэлтийн ажил



БАЙРШИЛ: 1 дүгээр хороо

- 36, 41, 42 дугаар байр орчим-120 м урт
- 6, 7 дугаар байр орчим – 220м урт
- Жаргалант ўйчилгээний төвөөс 67 дугваар цэцэрлэг хүртэлх-400м

БАЙРШИЛ: 2А, 12Б, 12В байр орчмын явган хүний замын засвар, шинэчлэлт

ХҮЧИН ЧАДАЛ: 115 м урт, 1.5м өргөн

БАЙРШИЛ: -3, -4 дүгээр байр орчмын явган хүний замын засвар, шинэчлэлт /2-р хороо/-1А байрнаас 50 дугаар байр хүртэл явган хүний замын засвар, шинэчлэлт

ХҮЧИН ЧАДАЛ: 500м урт, 1.5м өргөн

Дүүргийн төсвийн хөрөнгөөр Наадамчдын зам дагуу 41 дүгээр сургуулийн харалдаа явган хүний гарцаас далан руу гарах явган шат, гүүрэн байгууламжийн ажлыг хэрэгжүүлж, ашиглалтад оруулсан.

Зураг 22. Хан-Уул дүүрэг, 5 дугаар хороо, Наадамчдын зам дагуу явган шат хийх ажлын явц



Авто зам, замын байгууламжийн чиглэлээр: Гадаадын зээл тусламж, улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр дүүргийн 3, 8, 9, 11, 16, 17, 19, 21, 23, 25 хорооны 19 байршилд 14.5 км хатуу хучилттай авто зам, засвар, шинэчлэлийн ажил хэрэгжиж байгаа байгаа бөгөөд 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар 9.4 км авто замын ажил дуусаж, 5.1 км авто замын ажил гүйцэтгэлийн шатанд хэрэгжиж байна.

Зураг. 19, 20 дугаар хороонд 27 дугаар цэцэрлэгийн хойд уулзвараас
Монгол нэхмэл ХХК хүртэлх авто зам



Зураг. Гэр хорооллын хороодод шинээр хийгдэж буй замын ажлын явц



Зураг. Авто замын нөхөөсний ажил



Зураг . Гэр хорооллын гудамж зам талбайг зохист найрлагат хайргаар засварлах ажил



Ус зайлцуулах хоолой, суваг байгуулах ажлын хүрээнд:

Дүүргийн төсвийн хөрөнгөөр 16 дугаар хороонд нисэхийн авто зам дагуу 762 урт метр “Борооны ус зайлцуулах шугам сүлжээний ажил”-ыг “Нүнжиг” ХХК гүйцэтгэж, шугамын угсралтын дараах авто зам, явган хүний замыг бүрэн нөхөн сэргээсэн.

“Геодези, усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ дүүргийн 2, 9, 10, 15 дугаар хороонд авто замын ус зайлцуулах шугамын 12 худгийн тагийг нөхөж шинэчилсэн.


Дүүргийн 3 дугаар хороонд Үйлдвэрийн гудамжинд 440 метр (ф400 мм-ын голчтой хуванцар хоолой 440 метр, ф500 мм-ын голчтой ган хоолой 70 метр угсарч, шүүрт худаг 24, үзлэгийн худаг 14 ширхгийг хийсэн), 21 дүгээр хороонд 468 метр (ф500 мм-ийн голчтой хуванцар хоолой 420 метр, ф600 мм-ийн голчтой ган хоолой 7 метр, ф300 мм-ийн голчтой хуванцар хоолой 48 метр, үзлэгийн худаг 15 ширхэг) борооны ус зайлцуулах шугам угсарч, авто зам, явган хүний замын нөхөн сэргээлтийг бүрэн хийсэн.

Нисэхийн замын ус зайлцуулах хуучин сувгийг далд шугам болгох ажлын хүрээнд 4 ширхэг шүүрт худаг гаргаж, ф300 мм-ийн голчтой 56 метр ган шугамыг угсарч, нөхөн сэргээлтийн ажлыг хийсэн.

Жаргалантын амны үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажлын үргэлжлэл 240 урт метр далангийн ажлыг гүйцэтгэж, ашиглалтад оруулсан.

Үерийн дараах эвдэrsэн зам талбайг нөхөн сэргээх ажлын хүрээнд Хан-Уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ дүүргийн Засаг даргын 2023 оны А/429 дүгээр захирамжийн дагуу 8.5 сая төгрөгийн хөрөнгөөр 144 м.кв талбайд авто зам, үерийн даланг хүчитгэх, дүүргийн Засаг даргын 2023 оны А/484 дүгээр захирамжийн дагуу 7 дугаар хорооны Жаргалантын 18 дугаар гудамжинд 43 урт метр ус зайлцуулах шуудуу хийж, гудамжийг зохист найрлагатай дайргаар засварласан.

Зураг . 16 дугаар хороо, авто замын ус зайлцуулах шугам хоолойн байршил



Гэрэлтүүлгийн чиглэлээр:

Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, технологийн дэвшил бүхий нэгдсэн хяналт удирдлагын системийг нэвтрүүлж эрчим хүчиний хэмнэлт бий болгох зорилгоор Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Солонгос улсын “Дасан лайтинг” ХХК, дүүргийн нутаг дэвсгэрийн гэрэлтүүлгийн ашиглалт хариуцсан “Новелнэтворк” ХХК-ийн хооронд хамтын ажиллагааны гурван талт санамж бичгийг 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан бөгөөд тус ажлын хүрээнд хуучин, тусгал муутай 3000 ширхэг гэрэлтүүлгийн толгойг 50 Вт лед гэрлээр солих хөрөнгө оруулалтын төсөл Бүгд Найрамдах Солонгос Улсын Аж үйлдвэрийн яамны 1, 2 дугаар шатанд тэнцэж, 2024 оны 04 дүгээр сараас хэрэгжихээр шийдвэрлэгдсэн.

Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 1.59 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 2, 5, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21, 23, 24 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн гудамж талбайд 526 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулах 3 төсөл арга хэмжээнээс 1 төсөл арга хэмжээ ажил гүйцэтгэх, 2 төсөл арга хэмжээ худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна. Үүнд:

1. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны 1.0 тэрбум хөрөнгөөр 2, 5, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21, 23, 24 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн гудамж талбайд 360 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулах ажлын тендер 2023 онд 4 удаа зарлаж амжилтгүй болсон. Дахин тендер зарлах шатанд хэрэгжиж байна.

2. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн ажил (13 дугаар хороо) гүйцэтгэгч шалгаруулах шатанд хэрэгжиж байна.

3. Наадамчдын авто замаас Нуух чиглэлийн авто замын гэрэлтүүлгийн ажил (23 дугаар хороо)-ын гүйцэтгэгчээр "Ингүүмэл эрчим" ХХК шалгарч, гэрээ байгуулж, ажил эхэлсэн.

Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 4, 5, 7, 8, 20 дугаар хороонд 138 ширхэг гэрэлтүүлэг шинээр суурилуулсан.

Зураг 27. Хан-Уул дүүрэг, шинээр гэрэлтүүлэг суурилуулах ажлын явц



Орон сууцны хороолол, гэр хорооллын гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээг сайжруулж, тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Тус ажлын хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 3975 метр кабель шугам, 712 ширхэг гэрэл, 641 ширхэг 50 вт прожектор, 163 ширхэг пускатель, 380 ширхэг 50 вт лед трансформатор, 68 ширхэг 70 вт лед трансформатор, 252 ширхэг гал хамгаалагч, 210 ширхэг цахилгааны самбарын хайрцгийг засварлаж, 95 ширхэг гэрэлтүүлгийн шонг сольж, шинэчилсэн.

Зураг 27. Хан-Уул дүүрэг, гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээний ажлын явц



Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд Ажилчны гудамж, Үйлдвэрийн гудамж дагуу таггүй 137, Наадамчдын зам дагуу 171 гэрэлтүүлгийн шонг тагжуулж, ил гарсан 17461 метр кабелийг цэгцэлж булж, орчны аюулгүй байдлыг хангасан.

Дунд голын гудамж дагуу 40 гэрэлтүүлгийн шонг шилжүүлж, явган хүний замын зорчих хэсгийг чөлөөлсөн. Гэрэлтүүлгийн асалт 99.1 хувьтай байна.

Камержуулалтын чиглэлээр: Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд нийтийн эзэмшлийн гудамж талбайг камержуулах, орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжих 7 төсөл арга хэмжээний хүрээнд нийт 380 ширхэг камер суурилуулахаар төлөвлөсөн. Дүүргийн төсвийн 75.0 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Камерын хяналтын нэгдсэн төв рүү шилэн кабель татах, дотор заслын ажил"-ын шилэн кабелийн ажил бүрэн дуусаж, барилгын дотор заслын ажил хийгдэж байна. Тус төв ашиглалтад орсноор камерын угсралтын ажил дууссан төсөл арга хэмжээнүүд ашиглалтад орохоор хүлээгдэж байна.

Зураг. Шинээр камер суурилуулах ажил



1.4 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал;

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан 5 бүлэг, 9 зорилт 47 арга хэмжээ эхний улиралд 38 хувь, хагас жилд 63,6 хувь, гуравдугаар улиралд 67 хувь, жилийн эцэст 94 хувь, хяналт шинжилгээ, үнэлгээний 3 бүлгийн 36 шалгуур үзүүлэлт өхний улиралд 47 хувь, хагас жилд 69 хувь, гуравдугаар улиралд 76 хувь, жилийн эцэст 91 хувьтай хэрэгжсэн.

Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлээс Хан-Уул хамтран хэрэгжүүлэх 3 арга хэмжээний хагас жилд 47 хувь, гуравдугаар улиралд 75 хувь, жилийн эцэст 90 хувь, хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн 3 арга хэмжээ хагас жилд 50 хувь, гуравдугаар улиралд 75 хувь, жилийн эцэст 90 хувьтай хэрэгжсэн.

Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнөөс Хан-Уул хамтран хэрэгжүүлэх 81 арга хэмжээний хагас жилийн биелэлт 63,6%, жилийн эцэст 90%, тодорхой үр дүнд хүрсэн. Улирал тутам нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, тайлагнасан.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС:

Нийтийн эзэмшилийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр: Нийтийн эзэмшилийн гудамж, талбайн ногоон байгууламжийн арчлалт хамгаалалтын ажлын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай гэрээт 8 байгууллага 9350 ширхэг, 726 урт метр ургамлан хашлага, 13930 м.кв талбайд зүлэг, дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 3, 5, 7, 12, 14, 20 дугаар хорооны 7 байршилд 2199,8 м.кв сул шороон хөрс бүхий талбайг зүлэгжүүлсэн.

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/77 дугаар захирамжаар нийтийн эзэмшилийн гудамж, талбайн тохижилт, цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 100.4 сая төгрөгийн хөрөнгөөр нэг наст гоёл чимэглэлийн цэцгийг үрслүүлж, 1, 2, 6, 8, 11, 12, 13, 14, 15, 16, 19, 20, 22 дугаар хорооны 28 байршлын 3993 м.кв талбайд 332,370 ширхэг цэцэг тарьж, усалгаа, арчлалт хамгаалалтыг тогтмол гүйцэтгэж байна.

Зураг . Нийтийн эзэмшилийн гудамж талбайд цэцгийн мандал байгуулах ажлын явц



Тохижилт

үйлчилгээний төв ОНӨААТҮГ-тай хамтарч нийтийн эзэмшилийн гудамж, талбайн модыг хэлбэржүүлэх, тайралт хийсэн хэсгийг будах арга хэмжээг 2023 оны 02 дугаар сарын 28-ны

өдрөөс эхлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд 04 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 1, 2, 3, 5, 11, 20, 21 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 592 улиас, 15 хайлаасыг стандартын дагуу хэлбэржүүлсэн.

Зураг. Хан-Уул дүүрэг, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн модны хэлбэржүүлэлт



Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр:

Дүүргийн хог хаягдлын менежментийг сайжруулах “Хоггүй Хан-Уул” дэд хөтөлбөрийн хүрээнд Япон Улсын “SEC” компанийн удирдлагууд дүүргийн хог хаягдлын менежментийн чиглэлээр хамтран ажиллах санал солилцох, дүүргийн хог хаягдлын менежментийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа “Хоггүй Хан-Уул” дэд хөтөлбөрийг танилцуулах уулзалтыг 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан.

Зураг . Дүүргийн Засаг даргын Тамгын газрын холбогдо мэргэжилтнүүд, Япон Улсын “SEC” ХХК-ийн төлөөлөгчдийн уулзалт



Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах талаар мэдээлэл өгөх, дахивар хог хаягдал авах сургалт, дахивар авах өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж, нийт 500 гаруй иргэн, 20 гаруй сууц өмчлөгчдийн холбоод, аж ахуй нэгж, байгууллага оролцож, дахин ашиглах боломжтой 13 төрлийн нийт 4974 кг хог хаягдлыг тушааж, дахин боловсруулах үйлдвэрүүдэд хүргэсэн.

Зураг . Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахивар авах өдөрлөг



Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Өгөөмөр өдөр” арга хэмжээг батлагдсан удирдамжийн дагуу 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл дүүргийн хэмжээнд зохион байгуулж, нийт 50 аж ахуй нэгж байгууллагын 441 иргэн оролцож хүнс, ном, дэвтэр, тоглоом, гутал хувцас,

цахилгаан бараа, спортын хэрэгсэл гэх мэт нийт 30 гаруй нэр төрлийн 907 ширхэг (5 тонн) эд зүйлс цуглаж дахин ашиглах боломжтой болж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулсан.

Зураг . Хороодоор дамжуулан “Өгөөмөр өдөр” арга хэмжээнд оролцон эд зүйл хүлээлгэн өгсөн иргэн, байгууллагууд



Хандиваар цугларсан эд зүйлийг хүлээн авах, солилцох “Өгөөмөр өдөр” нэгдсэн өдөрлөгийг Ажилчны алдар талбайд 2023 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 11.00-16.00 цагийн хооронд зохион байгуулсан.

Зураг . “Өгөөмөр өдөр” нэгдсэн арга хэмжээ



Нийт цугларсан эд зүйлийг 2023 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрүүдэд дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран хэрэгцээт газруудад тараах, хандивлах арга хэмжээг зохион байгуулж, дүүргийн 3, 4, 5, 6, 7, 12, 13, 14, 22 дугаар хороодын Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг болон нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 54 өрхөд тараан өгсөн.

Зураг 4. Өгөөмөр өдөр өдөрлөгийн хурээнд цугларсан эд зүйлийг хэрэгцээт газар хандивласан байдал



Хог тээвэрлэлт, цуглувалт, парк шинэчлэлт:

Дүүргийн Засаг даргын 2022 оны 12 сарын 30-ны өдрийн А/647 дугаар Захирамжаар хог тээврийн гэрээ байгуулахыг хороодын Засаг дарга нарт шилжүүлж, “Хог хаягдал, цуглувалах, тээвэрлэх гэрээ”-ний загварыг шинэчлэн боловсруулсан.


Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн №2 дугаар шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу “Хог хаягдал, цуглувалах, тээвэрлэх гэрээ”-ний хавсралтаар аж ахуй нэгж, байгууллагын тохижилт, цэвэрлэгээг хариуцах орчны 50 метр хүртэлх

нийтийн эдэлбэр газрын зураглал хавсаргаж эхэлсэн. Тус ажлын хүрээнд орчны 50 метрийн зураглалыг дүүргийн хэмжээнд Arc GIS программд нэгтгэн бүртгэж, мэдээллийн сан үүсгэх ажлыг тогтмол хэрэгжүүлж байна.

Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх гэрээний загварыг шинэчлэн дүүргийн нийт 537 аж ахуйн нэгж байгууллагатай шинээр гэрээ байгуулсан.

Дүүргийн хэмжээнд хүнс, худалдаа үйлчилгээ явуулж байгаа 898 аж ахуйн нэгж, байгууллагын тохижилт, цэвэрлэгээг хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын зураглалыг гэрээний хавсралтаар баталгаажуулж, Газар зүйн мэдээллийн системд (ArcGIS) бүртгэсэн.

Зураг . Аж ахуйн нэгж, байгууллагын тохижилт, цэвэрлэгээг хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын зураглал



Дүүргийн нутаг дэвсгэрт хог хаягдал цуглуулах, тээвэрлэх гэрээний загварыг шинэчлэн нийт 861 аж ахуйн нэгж байгууллагатай шинээр гэрээ байгуулсан. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор дүүргийн Засаг даргын Тамгын газар, Татварын хэлтэс, хог тээврийн байгууллагууд, хороодын дундын мэдээллийн санг /Google sheet/ үүсгэн 7 хоног бүр мэдээллийг шинэчилж байгаа бөгөөд 861 байгууллагын мэдээлэл бүртгэгдсэн.

Зураг . Google sheet мэдээллийн санд оруулсан мэдээллийн статистик үзүүлэлт.



“Хоггүй Хан-Уул” дэд хөтөлбөрийн хүрээнд хог тээврийн машины парк шинэчлэлт хийх он дамжин хэрэгжсэн төсөл арга хэмжээний хүрээнд хог шахаж ачих зориулалтын Хьюндай HD78, HD 170 маркийн 11 автомашиныг 2023 онд хог тээврийн байгууллагуудад хүлээлгэж өгсөн. Дүүргийн төсвийн 800.0 сая төгрөгийн хөрөнгөөр 5 ширхэг задгай тэвштэй хог тээврийн машин худалдан авч, хог тээврийн байгууллагуудад хүлээлгэж өгсөн. Дүүргийн төсвийн 1.2 тэрбум

төгрөгөөр шахах төхөөрөмжтэй 6 м.куб 5 машин худалдаж авах ажил тендерийн баримт бичигт боловсруулах шатанд хэрэгжиж байна.

Зураг. Хог тээврийн байгууллагуудад хог тээврийн шинэ авто машин хүлээлгэн өгөр арга хэмжээ



Хүснэгт . Дүүргийн хэмжээнд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 19-ний өдрийг хүртэл хог тээврийн 4 байгууллагын цуглуулж, тээвэрлэсэн хог хаягдлын тоон мэдээлэл

Байгууллага	Машины тоо	Рейс	Тээвэрлэсэн хог, тн	Хариуцсан хороо
“Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ	13	8,416	31,924	9, 10, 12, 13, 14, 16, 21, 25
“Хан-Уул Агро” ОНӨААТҮГ	9	4,504	20,078	11, 15, 17, 18, 22
“Хан-Эко тээвэр” ААТҮГ	11	6,431	27,777	4, 5, 6, 7, 8, 24
“Эко хотын тээвэр” ААТҮГ	11	5,877	18,536	1, 2, 3, 19, 20, 23
Нийт	45	25,228	98,315	25 хороо

Зураг. Хог хаягдлын шөнийн тээвэрлэлт



Зураг. Хан-Уул дүүрэг, Хяналт шалгалтын явц



Байгаль орчныг хамгаалах, хөрсний нөхөн сэргээлтийн чиглэлээр:

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн эзэмшлийн талбайд хөрсний бохирдол, доройтлыг саармагжуулах ажлын хүрээнд 2, 5, 6, 7, 8, 12, 13, 20-р хороонд Нийслэлийн Байгаль орчны газраас мэргэжлийн байгууллага болох "Саблайм" ХХК-ийн хөрсний бохирдолтой 14 цэгийг тогтоож, талбайн судалгаа хийгдсэн. Үүнээс хүнд металлын бохирдолтой 3 байршлын 10 га талбайг буюу 20-р хороо УСУГ харьяа Харгияа урьдчилан цэвэрлэх байгууламжийн орчмын 3,9 га талбай, 12-р хороо Биокомбинат, 326-р цэргийн ангийн урд талбай 0,4 га талбай, 13-р хорооны нутагт байрлах Шувуун фабрик, хогийн цэгийн талбайд 5,7 га талбайд нөхөн сэргээлт хийсэн.


Хүснэгт . Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн

Дээж №, байршил	Гүн, см	Хөрсөн дэх хүнд металлын агууламж, %						
		Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/	As /Хүнцэл/
1	0-20	23.8	ND	31.5	52.4	74.7	46.5	ND
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/		60.0	1.0	50.0	60.0	100.0	60.0	10.0

Зураг. Биокомбинат, 326-р цэргийн ангийн урд хэсэг байдал /2023.10.02-ы байдлаар/ /БАЙРШИЛ 1/



Зураг . Шувуун фабрик, хог хаягдал хаядаг цэг /БАЙРШИЛ 2/



Хүснэгт . Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн

Дээж №, байршил	Гүн, см	Хөрсөн дэх хүнд металлын агууламж, %						
		Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/	As /Хүнцэл/
1	0-20	34.2	ND	37.1	44.7	89.6	63.1	2.4
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/		60.0	1.0	50.0	60.0	100.0	60.0	10.0

Зураг. Шувуун фабрик, хог хаягдал хаядаг цэгт олон наст ургамлаар хүнд металлын хорыг саармагжуулж, олон наст ургамлаар нөхөн сэргээлт хийсэн байдал /2023.10.2-ы байдаар/



Зураг. Хан-Уул дүүрэг, Харгяа цэвэрлэх байгууламж /БАЙРШИЛ 3/



Хүснэгт . Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн

Дээж №, байршил	Гүн, см	Хөрсөн дэх хүнд металлын агууламж, %						
		Hg /Мөнгөн ус/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/	Co /Кобаль/
Хашаан дотроос	0-20	1.9	0.9	28.7	29.2	86.3	95.4	11.4
Станцын урдаас	0-30	<0.005	<0.005	18.1	28.4	632.5	237.1	-
Тунгаагуур орчмоос	0-30	<0.005	<0.005	18.7	32.2	212.5	1205.4	-
Хүлцэх агууламж	2	1.0	50.0	60.0	100.0	60.0	30.0	600.0

/MNS 5850:2019/

Зураг. Харгия цэвэрлэх байгууламжийн ойролцоо газрыг ургамлаар нөхөн сэргээсэн байдал /Ургамал ургалтын явц 2023.9.10-ы байдлаар/ /БАЙРШИЛ 3/



Хөрс, орчны бохирдлыг бууруулах бүх нийтийн их цэвэрлэгээ, ариутгал, халдвартгүйжүүлэлтийн чиглэлээр: Дүүргийн Засаг даргын 2023 оны А/54 дүгээр захирамжийн дагуу дүүргийн хэмжээнд 12 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албад болон дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийт 8125 аж ахуй нэгж байгууллага, 309 сууц өмчлөгчдийн холбоодын 15,600 хүн оролцож, 215,311 м.кв талбайгаас 451,8 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн.

“Хаврын их цэвэрлэгээ” сарын аяны хүрээнд 115 автобусны буудал, 2,850 урт метр хайс хашлага, 205 авто замын тэмдэг тэмдэглэгээ, 26 хөшөө дурсгал, 455 спорт болон тоглоомын талбай, 226 хогийн сав, 210 сандлыг тус тус угааж цэвэрлэсэн.

Зураг 39. Цэвэрлэгээний үйл явцаас:



Зураг . “Хоггүй Хан-Уул 2023” аяны хүрээнд зохион байгуулсан бүх нийтийн их цэвэрлэгээний ажлын явц



Дүүргийн Засаг даргын 2023 оны А/286 дугаар захирамжийн дагуу 8, 10, 12, 13, 14, 21 дүгээр хороодын нутаг дэвсгэрт үхсэн мал амьтны сэг зэм, өтөг бууцыг цэвэрлэж, ариутгаж халдвартгүйжүүлсэн. Дүүргийн 5, 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт бохир хальсан болон хогийн цэгийн 15,000 м.кв талбайг ариутгаж, халдвартгүйжүүлсэн.

Зураг. Дүүргийн 5-р хороо, нийтийн байрны цэвэрлэгээ, ариутгал халдвартайжүүлэлтийн ажлын явц



Зураг. Ухсэн мал, амьтны сэг зэм, хур хог хаягдлыг ачиж, ариутгасан байдал



Дүүргийн Засаг даргын 2023 оны А/196 дугаар захирамжийн хүрээнд гэр хорооллын 12099 нүхэн жорлон, 5732 бохирын цооногийг ариутгаж, халдвартайжүүлсэн.

Нийслэлд орсон их хэмжээний борооны дараа үерийн уснаас халдварт өвчин тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд үерийн усанд автсан нийтийн эзэмшилийн гудамж, талбай, орон сууц, сургууль, цэцэрлэгийн барилгуудын нийт 300,700 м.кв талбайг ариутгаж халдвартайжүүлсэн.

Зураг . Нүхэн жорлон, бохирын цооногийг ариутгаж, халдвартайжүүлсэн байдал



Нийслэлийн хэмжээнд үргэлжлэн орсон борооны улмаас Хан-Уул дүүрэгт 6 байршилд ус их хэмжээгээр тогтох, Дунд гол дагуу үерийн ус халих эрсдэл бүхий 9 байршил бий болж, нийслэл, дүүргийн Онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу үерийн уснаас урьдчилан сэргийлэх, иргэдийн амь нас, эд хөрөнгийг хамгаалах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, хяналт тавьж ажилласан.

Дунд гол дагуу 3 метрийн өндөр, 160 урт метр хамгаалалтын далан босгож, иргэдийн амь нас, эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авч ажилласан. Нийслэлийн Засаг даргаас өгсөн чиглэлийн дагуу дүүргийн Засаг даргын 2023 оны А/478 дугаар захирамжийн дагуу 3 дугаар хороонд дунд голын хүчитгэх түр даланг буулгаж, ариутгаж халдвартайжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажилласан. Тус ажлыг "Эко хотын тээвэр" ААТҮГ –аар хийж гүйцэтгүүлж, 83 хово машин шороог зөөвөрлөхөд шаардлагатай төсвийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шийдвэрлэсэн. Тус байршилд зам талбайн 3 ажилтан, Техних машин механиктай ажиллах 5, аюулгүй байдал хангуулах туслах 3 ажилтан нийт 11 хүн, 1 хово, эсковатор 2, 2 ковш ажилласан. Нийт 7500 м² талбайн ариутгал халдвартайжүүлэлт хийж, орчны зам талбайн ханаас хана цэвэрлэгээ хийж гүйцэтгэн хяналт тавьж ажиллаа.

Дүүргийн хэмжээнд нийт 25 хорооос 19 хороонд үерийн эрсдэлээс хамгаалан шороо, элсээр хамгаалалт хийсэн нийт 101 аж ахуй нэгж байгууллага, 137 сууц өмчлөгчдийн холбоод заасан хугацаанд элс, шороог зөөврөлөн цэвэрлэсэн.

Зураг . Үерийн уснаас хамгаалах түр далан



Нийтийн эзэмшилийн зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээний чиглэлээр:

Дүүргийн авто зам, явган замын цэвэрлэгээ, үйлчилгээг шинээр хариуцаж буй 9 байгууллага болох Хот тохижилтын газар ОНӨААТҮГ, "Чингэлтэй TYK" ХХК "Охь мандал" ХХК, "Эко эрин тохижилт" ХХК, "Экспресс зам" ХХК, "ТЖН Форестри" ХХК, "Гранд зевс" ХХК-ийн хариуцсан 18 байршлын 2,332,290 м.кв талбай бүхий авто зам, явган зам, "Тохижилт үйлчилгээний төв" ОНӨААТҮГ-ын хариуцсан 126 байршлын 1,043,793 м.кв талбай бүхий туслах замын цэвэрлэгээ үйлчилгээнд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Тус ажлын хүрээнд халтиргаа гулгааг арилгах чиглэлээр 4 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, нийт 26.5 тонн цас мөсийг цэвэрлэн, халтиргаа гулгаанаас сэргийлэн ажилласан.

Зураг. Авто зам, явган замын цас, мөс цэвэрлэгээний ажлын явц



Зураг 45. Авто зам, явган замын хог цэвэрлэгээний ажлын явц



2022-2023 оны өвлийн улиралд замын цас мөсийг цэвэрлэх, халтиргаа гулгааг арилгах зорилгоор 2023 онд 510.5 тн давс, 43 тн бодис цацсан. Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу дүүргийн 25 хороодын нутаг дэвсгэрт халтиргаа гулгаа ихээр үүсдэг, өгсүүр байршуудад 68 ширхэг давс, бодисын нөөцийн сав байршуулж, давс, бодисоор дүүргэж, яаралтай үед ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажилласан.

Зураг . Давс, бодисны нөөцийн сав байршуулсан байдал



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулсан байдал;

Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко-Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 бүлэг, 23 зорилго, 108 зорилт, 151 арга хэмжээ эхний улирлын байдлаар 31%, хагас жилд 54 хувь, гуравдугаар улиралд 72 хувь, жилийн эцэст 91 хувь тодорхой үр дүнд хүрсэн.

Дүүргийн "Дэд хөтөлбөр"-ийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлж буй "Эко-эрүүл дүүрэг" үйл ажиллагааны 10 дэд хөтөлбөр дээр дүүргийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн A/430 дугаар захирамжаар "Иргэдээ сонсъё", "Бүтээгч Хан-Уулчууд" дэд хөтөлбөрүүд шинээр хэрэгжиж эхлэхээр батлагдсан.

Дүүргийн хэмжээнд нийт 12 дэд хөтөлбөр хэрэгжиж байгаагаас:

- "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийн хүрээнд 22 төсөл, арга хэмжээ;
- "Ахмадаа дээдэлье" дэд хөтөлбөрийн хүрээнд 9 төсөл, арга хэмжээ;
- "Багш" дэд хөтөлбөрийн хүрээнд 9 төсөл, арга хэмжээ;
- "Эрүүл дүүрэг" дэд хөтөлбөрийн хүрээнд 5 төсөл, арга хэмжээ;
- "Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөрийн хүрээнд 15 төсөл, арга хэмжээ;
- "Бүтээгч Хан-Уулчууд" дэд хөтөлбөрийн хүрээнд 2 төсөл, арга хэмжээ;
- "Иргэдээ сонсъё" дэд хөтөлбөрийн хүрээнд 12 төсөл, арга хэмжээ;
- "Хорооны хөгжил" дэд хөтөлбөрийн хүрээнд 3 төсөл, арга хэмжээ амжилттай хэрэгжсэн байна.

"Архигүй орчин", "Эко ногоон дүүрэг", "Хогтуй Хан-Уул", "Жендерийн эрх тэгш байдлыг хангах" дэд хөтөлбөрүүдийн хүрээнд өмнөх төсөл, арга хэмжээнүүд үргэлжлэн хэрэгжиж байна

Гэр хорооллыг шинэ үзэл баримтлалын дагуу хөгжүүлж, иргэдэд боломжийн өртөгтэй орон сууцтай болох "Зөв шийдэлтэй" дахин төлөвлөлтийг Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хороодод нийт 10 хэсэг 314.75 га талбай буюу 5781 нэгж талбарт 9 төсөл хэрэгжүүлэгч үе шаттайгаар гүйцэтгэж байна. Ерөнхий төлөвлөлтөөр 359 блок 26,787 айлын орон сууц, 8860 хүүхдийн сургууль, 3830 хүүхдийн цэцэрлэг төлөвлөгдсөн. Жилийн эцсийн байдлаар 464 нэгж талбар чөлөөлж, 4 блок 480 айлын орон сууц ашиглалтад оруулж, 152 нэгж талбартай турвалсан гэрээ байгуулсан.

Орон сууц бодлогын газартай хамтран 2023 оны 03 дугаар сарын 09, 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр тус тус дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хорооны 600 гаруй оршин суугч иргэдийг хамруулан гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн явцын талаарх мэдээлэл өгөх, санал хүсэлтийг сонсох, хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулсан.

Мөн дүүргийн Засаг дарга Нийслэлийн орон сууц бодлогын газартай хамтран 2023 оны 09 дүгээр сарын 26, 10 дугаар сарын 08-ны өдрүүдэд яармагийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн

ажлын хүрээнд эрх нь хөндөгдж буй иргэдийн төлөөлөлтэй санал сонсох уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, тулгарч буй асуудал болон санал хүсэлтийг холбогдо газарт уламжилсан. Түүнчлэн 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан “Иргэдээ сонсъё” хөтөлбөрийн хүрээнд яармагийн 4, 5, 6, 7, 8 дугаар хорооны 360 (давтагдсан тоогоор) иргэнээс гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой санал хүсэлт ирснээс 48% нь дахин төлөвлөлтийг шуурхай хэрэгжүүлэх, 52% нь дэд бүтцэд холбогдож хашаандaa амьдрах хүсэлтэй байгаагаа уламжилсан.



Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд дүүргийн ашиглалтын шаардлага хангахгүй 34 барилгаас 33 барилгад төсөл хэрэгжүүлэгч шалгарч, журмын дагуу буулган шинээр барих үйл ажиллагаа явагдаж байна. Одоогийн байдлаар 2339 айлын 11 орон сууц ашиглалтад оруулж, 816 өрхийг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлөөр хангаад байна.



“Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах” төслийн явцын талаарх мэдээллийг сар бүр шинэчилж, Хот байгуулалт хөгжлийн газартай хамтран 2023 оны 04 дүгээр сарын 10, 05 дугаар сарын 09-ний өдөр тус тус “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах” ажлын явцын талаар мэдээлэл өгөх, санал солилцох уулзалт хэлэлцүүлгийг 1, 2, 3 дугаар хорооны 500 гаруй оршин суугч иргэдийг оролцуулан зохион байгуулсан. Түүнчлэн 2023 оны 08 дугаар сарын 04-нд дүүргийн Засаг даргаар батлагдсан “Иргэдээ сонсъё” хөтөлбөрийн хүрээнд 2 дугаар хорооны Нэхмэл 7, 11 дүгээр байр, 3 дугаар хорооны Элит 073 дугаар байр, 5 дугаар хорооны АШҮН-80 дугаар байр, 6 дугаар хорооны ТТБТ байр, 7 дугаар хорооны Говь 16 дугаар байр, 20 дугаар хорооны Дэвшил 36 дугаар байрны нийт 209 иргэнд тус тус хэсэгт хэрэгжиж буй АШХНЗОС-ны төслийн мэдээ, мэдээллийг хүргэх, эрх нь хөндөгдж байгаа иргэдийн санал хүсэлтийг сонсон холбогдох байгууллагад уламжлах ажлыг зохион байгуулаад байна.

НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 221 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн аварга фермерт 1, нийслэлийн тэргүүний тариаланчид 4, нийт 5 иргэнийг шагнуулахаар дэмжин тодорхойлсноос “Нийслэлийн тэргүүний тариаланч”-аар дүүргийн 13 дугаар хорооны тариаланч 3.Эрдэнэчулуун, Т.Ламчин нар шалгарсан.



Хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг баталж, хүлэмжийн аж ахуй эрхэлж буй 32 аж ахуйн нэгж, 155 иргэнийг газар тариалангийн нэгдсэн санд бүртгэж, тариалалт, арчлалт, ургац хураалтын явцад хяналт тавьж, дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.



Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагатай хамтран 6 удаагийн сургалт, туршлага судлах аялал зохион байгуулж, 150 тариалан эрхлэгчийг хамруулсан.



“Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам”-ыг хангуулах чиглэлээр:

- “Газар тариалангийн үйлдвэрлэлийн бүртгэл мэдээллийн plant.mofa.gov.mn цахим систем”-д 344.5га тариалангийн талбай бүхий 215 тариаланчийг тулган баталгаажуулсан.
- Төмс, хүнсний ногооны 38 цахим гарал үүслийн гэрчилгээг давхардсан тоогоор 13 иргэн, ААН-ийн 468.3тн хүнсний ногоонд олгож, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавин ажиллаж байна.
- Дүүргийн нутаг дэвсгэрт хүлэмжийн аж ахуй эрхэлж буй 89 иргэн, аж ахуйн нэгжийн тариалалт, хүлэмжийн ашиглалт, ургалтын байдалд хяналт тавьж, заавар зөвлөгөө өгч, газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийн технологийн нэгдсэн судалгааг нарийвчлан гаргах ажлыг зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.
- Дүүргийн хэмжээнд 2023 онд хүлэмжийн тариалалтын талбайг 0.7-оос доошгүй га-аар нэмэгдүүлэхээр төлөвлөж, 0.96 га талбайгаар тариалалтыг нэмэгдүүлсэн байна.



Хан-Уулд тариалав брэндинг бий болгох ажлын хүрээнд 13 дугаар хорооны газар тариалан эрхлэгч Ч.Долгорсүрэн нь хүлэмжид айсберг, шанцай, цэцэгт байцаа нутагшуулж, нэр төрлийг нэмэгдүүлж, Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамнаас “Хүлэмжийн шинэ соортын хүнсний ногоо тариалж нутагшуулсан ногоочноор” шалгарсан.

Мөн “Фор Ви Ар Грийн” ХХК-ийн гүнжийн навч, улаан лооль, “Стандарт барагшун” ХХК-ийн “Барагшун”, “Үлэмж органик” ХХК-ийн сүү, сүүн бүтээгдэхүүн, “Тинц” ХХК-ийн “Ногоодой” жимсний шүүс, “Тинц” ХХК-ийн “Ногоодой” жимсний шүүс, “Амаркатеринг” ХХК-ийн 8 төрлийн салатыг брэнд бий болгох зорилгоор нийслэл, дүүргээс зохион байгуулсан үзэсгэлэн худалдаанд оролцуулж, сурталчлах ажлыг зохион байгуулсан.



Мал аж ахуй эрхлэхийг хориглосон хороодын нутаг дэвсгэрт мал оруулахгүй байх, хяналт тавих чиглэлээр:

Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал оруулахгүй байх, орж ирсэн малыг зөвшөөрсөн бүсэд нүүлгэн шилжүүлэх чиглэлээр 6 удаагийн арга хамжээ зохион байгуулж, 17.8 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан. Үүнд:

“Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрсэн мал, амьтныг гаргах, түр саатуулах журам”-ын төслийн хэлэлцүүлгийг болон холбогдох хууль, тогтоомжийг танилцуулж зөвлөгөө мэдээлэл өгөх уулзалтыг 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 150 гаруй иргэнийг хамруулж, Богд Хан-Уулын дархан цаазат хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч настай хамтран ажиллаж байна. Хяналт тавих байнгын эргүүл жижүүрээр 3 ажилтныг ажиллуулан ажлын цаг ашиглалт, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.



Дүүргийн Засаг даргын мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал оруулахыг хориглох тухай Засаг даргын 2023 оны 03/1614 дугаар албан мэдэгдэл, Богд Хан-Уул дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны албаны даргын 02/1241 албан бичгийг давхардсан тоогоор 410 гаруй малчин мал бүхий иргэдэд хүргүүлсэн.



Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд хариулгагүйгээр бэлчээсэн нийт давхардсан тоогоор 141 иргэний 3127 малыг хориглосон бүсээс тууж гарган, 10 иргэний 29 тооны үхэр, 60 гаруй тооны адууг хашаалан, 11 иргэнд Цагдаагийн газраас Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 1.050 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан.



Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих ажлын хүрээнд: Төр, хувийн хэвшилийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах, борлуулалтыг дэмжих замаар дотоодын эдийн засгийг нэмэгдүүлэх зорилгоор "Бүтээгч Хан-Уулчууд" дэд хөтөлбөрийг боловсруулсан.

Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих, бүтээгдэхүүн үйлчилгээг нь олон нийтэд сурталчлах зорилгоор 20 удаагийн арга хэмжээнд нийт давхардсан тоогоор 187 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг түрээсийн төлбөргүйгээр хамруулж, нийлбэр дүнгээр 433.0 сая төгрөгийн борлуулалт хийхэд нь дэмжлэг үзүүлэн ажилласан.

Хөтөлбөрийн хүрээнд "Бүтээгч Хан-Уулчууд 2023" 5 удаагийн арга хэмжээнд худалдаа, хоол үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбарын 250 иргэн, аж ахуйн нэгжүүдийг оролцуулж, бүтээгдэхүүн үйлчилгээг иргэдэд сурталчлан, бараа бүтээгдэхүүнийг борлуулж, дэмжин ажилласан.



Өрхийн үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой иргэдэд мэргэжлийн ур чадвар олгох, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллага, сургалтын төвүүдтэй хамтран онол дадлага хосолсон 6 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 202 иргэнийг хамруулсан. Үүнд:

- Хүлэмжийн суулгац бэлтгэх талаар 19;
- Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүлэх чиглэлээр 31;
- Органик саван, лаа хийх талаар 50;
- Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн гаргах чиглэлээр 52;

Хүнсний ногоо нөөшлөх, хадгалах талаар сургалтад 50 иргэнийг тус тус хамруулсан.



Гэр бүлийн хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагааг талуудтай хамтран зохион байгуулах хүрээнд:

"Олон улсын гэр бүлийн өдөр"-ийг буюу 2023 оны 05 дугаар сарын 15-нд шинээр гэр бүл болж байгаа залуу хосуудад "Гэрлэлтийн гэрчилгээ"-г гардуулах ёслолын арга хэмжээг зохион байгуулж, дүүргийн онцлох, оюунлаг, соортлог 8 гэр бүлийг шалгаруулж, цахим мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажилласан.



Хотын соёлыг төлөөшүүлж түгээн дэлгэрүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулах хүрээнд:

"Хотын соёл-Хорт зуршил" сургалтад дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 6 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Коллежийн нийт 1045 оюутан хамруулан, "Хотын соёлд-Бидний

"Үйлдэл" сэдэвт илтгэлийн уралдааныг зохион байгуулж 1, 2 дугаар дамжааны 15 багийн 75 оюутан, 6 удирдагч багш оролцсон.

Соёлыг түгээн дэлгэрүүлэх, бусдад зөргээр нөлөөлөх, соёлтой харилцааг дэмжихэд чиглэгдсэн "Биеэ зөв авч явах соёл" сэдэвт сургалтаар төр, хувийн хэвшлийн нийт 7 байгууллагад 7 удаагийн сургалтаар 206 иргэнийг хамруулсан.

Хотын соёлыг түгээх 3 бичлэг, 16 постерьг төрийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн пэйж хуудас болон иргэд, байгууллагын албан хаагчдын группт байршуулснаар 2478 иргэн хандаж, 327 лайк дарж, 154 шэйр хийгдсэн байна.

Сурагчдын өвийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор "Өвийн жим" клубээс "Өв бидний баархал" самбарын үзүүлэн, өв соёлоо танин мэдье аялал зохион байгуулж, "Дэлхийн өв ба түүний ач холбогдол", "Дэлхийн өв ба хүрээлэн буй орчин", "Өвийн боловсрол зэрэг сэдвээр 8 удаагийн сургалтад 165 иргэнд хамруулсан.

Ердийн сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурх орчныг бүрдүүлэх хүрээнд:

Тэгш суралцах орчин бүрдсэн хичээлийн байртай ерөнхий боловсролын сургууль 17, тусгай тоноглол бүхий ариун цэврийн өрөөтэй 10, налуу замтай 38 сургууль байна. "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй"-н 2 удаагийн сургалтад ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын 158 багш хамрагдлаа.

2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 520, сургуулийн өмнөх боловсролд 160, нийт 680 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна.

"Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах өдөр"-ийг угтан тэгш хүртээмжийг бий болгох сургалтын өрөөг ерөнхий боловсролын 163 дугаар сургууль дээр тохижуулах төслийг дүүргийн Засаг даргын Тамгын газраас хэрэгжүүлж ажилласан.

Төслийн хүрээнд тус сургууль дээр нисэх алсын бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан хөгжлийн төвийг шинээр байгуулж байгаа бөгөөд тохижилтын ажил 60 хувьтай байна.

1.5 Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт;

- 2023 оны 1 дүгээр улиралд нийслэлийн Засаг даргын 7 захирамжийн 12 заалт, нийслэлийн Засаг даргын 5 Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн холбогдох 7 заалтын биелэлтийг нэгтгэн, тайлагнасан. /Биелэлт – 64.2%/
- 2023 оны эхний хагас жилийн байдлаар 21 захирамжийн холбогдох 24 заалтын биелэлтийг нэгтгэн, тайлагнасан. /Биелэлт – 84.4%/
- 2023 оны 3 дугаар улиралд нийслэлийн Засаг даргын 17 захирамжийн 23 заалт, нийслэлийн Онцгой комиссын 1 албан даалгаврын 5 заалт, нийслэлийн Засаг даргын 1 Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн холбогдох 2 заалтын биелэлтийг нэгтгэн, тайлагнасан. /Биелэлт – 96.4%/
- 2023 оны жилийн эцсийн байдлаар нийслэлийн Засаг даргын 19 захирамжийн 41 заалт, нийслэлийн Засаг даргын 2 Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн 7 заалтын биелэлтийг нэгтгэн, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийн тайлагнасан. /Биелэлт-93%/

Дүүргийн хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны "Дүүргийн мал аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах ажлын удирдамж" болон "Бэлтгэл ажлыг хангуулах 14 заалт бүхий ажлын төлөвлөгөө"-г батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан.



Дүүргийн Засаг даргын 2023 оны "Малчин, мал бүхий иргэдэд дэмжлэг үзүүлэх тухай" А/50 дугаар захирамжаар өвөлжилт хүндэрсэн мал бүхий 12, 13, 14 дүгээр хорооны 336 өрхөд өвс 22тн өвсний дэмжлэг үзүүлсэн.

Хамтарсан хяналт шалгалтын чиглэлээр:

Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Хяналт шалгалт зохион байгуулах тухай" А/1267, А/1292 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2023 оны "Хяналт, шалгалт зохион байгуулах тухай" А/626 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 11 байгууллагын хамтарсан ажлын хэсэг баталсан бүсчлэлийн нэгдүгээр эгнээнд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжид хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэж, дүүргийн 1,2,3,15 дугаар хорооны нутаг дэвсгэрт авто үйлчилгээ, барилгын материалын худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 19 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан. Үүнд:

- Авто үйлчилгээ-17
- Барилгын материалын худалдаа- 2

Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтаар 6 иргэн, аж ахуйн нэгжид нийт 2,450,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 8 иргэн, аж ахуйн нэгжид зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, хугацаатай мэдэгдэл, албан шаардлага хүргүүлсэн.



Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай" А/1240 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2023 оны "Хяналт, шалгалт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай" А/625 дугаар захирамжийн захирамжаар дэд ажлын хэсгийг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн байрны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 34 байрны барилга байгууламжид удирдамжид тусгагдсан 5 чиглэлээр хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.


Toхижилт, нийтийн аж ахуйн чиглэлээр:



Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд хяналт тавих ажлын хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/90, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/53 дугаар захирамжийн хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн түгээмэл тархацтай ашигт малтмалын тээвэрлэлтэд хяналт тавьж, 2023 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 11123 тээврийн хэрэгсэл шалгаж, зөрчил гаргасан 9834 тээврийн хэрэгслийн жолоочид 206,125,000 төгрөгийн тортогууль ноогдуулж, зөрчил арилгах арга хэмжээ авч ажилласан.

Зураг . Түгээмэл тархацтай ашигт малтмал тээвэрлэлтэд хяналт тавьсан байдал



Дүүргийн Засаг даргын 2023 оны А/151 дүгээр захирамжийн дагуу 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар Төв аймгийн Алтанбулаг сум болон Хан-Уул дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг 26 байгууллагын 536 тээврийн хэрэгслийн хариуцагчтай “Тээвэрлэлтийн хариуцлагын гэрээ”-г байгуулж, хяналт тавин ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд хяналтын 3 пост ажиллаж байна.

Зураг . Хариуцлагын гэрээ байгуулах явц



Дүүргийн 12, 13 дугаар хорооны иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу тус хороодод үйл ажиллагаа эрхэлдэг түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалтыг 8 удаа зохион байгуулж, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан “Очир шүр” ХХК, “Баян сүмбэр богд” ХХК, “Батадар” ХХК гэсэн 3 аж ахуйн нэгжийн олборлолтын ажиллагааг зогсоох арга хэмжээ авсан.

Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 17 аж ахуйн нэгж, байгууллагад батлагдсан удирдамжийн дагуу Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Татварын хэлтэс, Газар зохион байгуулалтын алба, харьяа хороодын Засаг дарга нартай хамтарч 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 26-ны өдрийн хооронд хяналт, шалгалт явуулж, илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгч, 6 байгууллага 2023 оны уулын ажлын төлөвлөгөө болон менежментийн төлөвлөгөөгөө Нийслэлийн байгаль орчны газраар батлуулж зөрчлөө арилгасан.

Зураг . Хяналт, шалгалтын ажлын явц



Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/437 дугаар захирамжаар "Улаанбаатар марафон-2023" олон улсын гүйлтийн арга хэмжээ, 2023 оны А/1109 дүгээр захирамжаар "Автомашингүй өдөр-2023" нэгдсэн арга хэмжээг 2023 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр тус тус зохион байгуулж, дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын 1895 ажилтан, албан хаагч, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж, ахуйн нэгж байгууллагын 587 ажилтан, ерөнхий боловсролын 23 сургууль, 33 цэцэрлэгийн 2105 багш, сургачид, 25 хорооны 2299 иргэн оролцож, соёл урлаг болон спортын 4 төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулж ажилласан.



1.6 Нийслэл, дүүргийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт;

Засаг даргын зөвлөлийн хурал: Засаг даргын 2023 оны А/441 дүгээр захирамжаар Засаг даргын зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж нийт 11 гишүүнтэй болсон. Тус хурлаар хэлэлцүүлэх асуудлыг тухай бүр батлуулж, журмын дагуу 7 хоног бүр тогтмол зохион байгуулж ажилласан. 2023 онд нийт 53 удаа зөвлөлийн хурлыг зохион байгуулж, нийт 315 асуудал хэлэлцэгдэж, 155 үүрэг даалгавар өгөгдсөн байна. Хэрэгжилтийн явц 90%-тай байна. Зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэр хэрэгжилтийг тухай бүр холбогдох хэлтэс, нэгжүүдэд хүргүүлэн үүрэг даалгавар, хэрэгжилтийг хангулсан.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 2023 онд 31 удаа хуралдаж, дүүрэгт 265 үүрэг даалгавар өгөгдөн, 87%-тай хэрэгжсэн. Шуурхай зөвлөгөөнөөс



өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг холбогдох хэлтэс, албадаас авч нэгтгэн батлуулж, хугацаанд нь тайлагнасан.

Дүүргийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 2023 онд 37 удаа зохион байгуулан, нийт 115 үүрэг даалгавар 84.4%-тай хэрэгжсэн. Шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавар болон хороодод тулгамдаж буй асуудлын саналыг нэгтгэн 7 хоног бүр Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулсан.

Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнийг 2023 оны жилийн эцсийн байдлаар 11 удаа зохион байгуулж, 109 үүрэг даалгавар өгөгдсөнийг хэлтэс, албадад хүргүүлж хэрэгжилтийг тайлагнасан. Биелэлтийн дундаж 94.3 хувь.

Хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөнийг 2023 онд 21 удаа зохион байгуулж, 122 үүрэг даалгавар өгөгдөн, 93%-тай хэрэгжсэн. Хурлаас өгөгдсөн үүрэг даалгавар болон хороодод тулгамдаж буй асуудлын саналыг нэгтгэн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулсан.

“Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон хороодын төрийн албан хаагчийн хөгжил, нийгмийн баталгаа, ёс зүй, сахилга хариуцлагын чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээний дагуу Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс алба, хороодын 350 албан хаагчдыг төрөөс баримталж буй бодлого, эрхэлж буй ажлын чиг үүргийн дагуу 15 удаагийн сургалтад хамруулж, арга зүйн дэмжлэг үзүүлсэн.



1.7 Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн;

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/987 дугаар захирамжаар нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжтэй хийх гэрээ, батламжийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн цахимжуулсан. Захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Худалдаа үйлчилгээ эрхлэх цахим бүртгэлийн системийг сурталчлах 2 удаагийн арга хэмжээ зохион байгуулж нийт 1700 гаруй иргэн, аж ахуйн нэгжид зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Худалдаа үйлчилгээ эрхлэх цахим бүртгэлийн системд 2023 онд ирсэн 1172 иргэн, аж ахуйн нэгж хүсэлтийг хүлээн авч, судлан, 99%-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Үүнд:

- Шийдвэрлэсэн-851
- Судалж буй- 11
- Татгалзсан-310

Худалдаа үйлчилгээ эрхлэх цахим бүртгэлийн системийг сурталчлах 2 удаагийн арга хэмжээ зохион байгуулж нийт 1700 гаруй иргэн, аж ахуйн нэгжид зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Тамхи худалдах зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлэх талаар саналыг УБ хотын ЗАА-нд хүргүүлж, тамхи худалдах зөвшөөрөл авсан иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг <https://license.mn/> цахим хаягт бүртгэж оруулахаар бэлтгэл ажлыг ханган ажилласан.



Засгийн газраас хэрэгжүүлж буй цахим шилжилтийн бодлого, зорилттой уялдуулан Сангийн яамны Төрийн сангийн газраас "Төрийн сангийн удирдлагын цахим систем" төслийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд төрийн сангийн төлбөр тооцооны үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, төсвийн байгууллагуудын зарлагын гүйлгээ болон мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны хяналтыг сайжруулах зорилгын хүрээнд, төрийн нууцад хамаарахаас бусад бүх төсвийн байгууллага, төслүүд, төсвийн байгууллагын харилцагчид буюу бэлтгэн нийлүүлэгчид хооронд цахим мэдээлэл солилцох, санхүүгийн гүйлгээ хийгддэг болсон.

Төрийн сангийн төлбөр тооцоог 2023 оны 04 сарын 12-ны өдрөөс эхлэн цахимжуулж, төсвийн хэрэгжилтийг түргэн шуурхай зохион байгуулан, төсөв, санхүүгийн ажилтны ажлын ачааллыг бууруулж, зайнас ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Дүүргийн харилцагч төсөвт байгууллагуудаас Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн 7100-1112 дугаарын дуудлагыг хүлээн авч зөвлөгөө өгч ажиллаж байна. Эрхийн бүртгэлийн сан болон payroll.gov.mn программууд дээр харилцагч төсөвт байгууллагуудад заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.

Дүүргийн лавлагаа, мэдээллийн 77771965 тусгай дугаарын дуудлагын мэдээ

Дүүргийн хэмжээнд 2023 оны жилийн эцсийн байдлаар 15913 үүнээс Засаг даргын Тамгын газарт 9278 дуудлага ирснийг холбогдох хэлтэс албад руу шилжүүлж, мэдээлэл зөвлөгөөг өгч ажилласан.

Иргэдээс ирсэн дуудлага:




1.8 Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн ажил, үр дүн;

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх "Эко – Эрүүл дүүрэг" үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд "Тэрбум мод" 2023 оны жилийн эцсийн тайлан

үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 онд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр Хан-Уул дүүргэгт 5 бүлгийн 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.

Зураг . Хан-Уул дүүргийн 14 хороо Айцын аманд байрлах ойн төгөл



Дүүргийн Засаг даргын 2023 оны A/147 дугаар захирамжийн дагуу “Ногоон хот – Иргэний оролцоо” мод тарих аяныг нийтийн эзэмшил, хязгаарлагдмал болон тусгай хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтээр мод тарих арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, дүүргийн хэмжээнд 2023 онд 60,709 ширхэг мод, бут сөөгийг шинээр тарьж, 965 ширхэг мод, сөөгийг нөхөн тарьсан.

Зураг . Хан-Уул дүүргийн 14 хороо Айцын аманд байрлах ойн төгөл



Нийтийн эзэмшлийн гудамж талбайн хэлбэржүүлэлтээс гарсан улиасны модожсон мөчрийг бэлтгэж, үржүүлэх ажлын хүрээнд 6500 ширхэг улиасны модожсон мөчрийг Агро паркийн талбайд тарьсан.

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны A/457 дугаар захирамжийн дагуу “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ 70.2 сая төгрөгийн хөрөнгөөр агропаркийн талбайн хүлэмжүүдийн

НИЙЛЭГ ХАЛЬСЫГ ШИНЭЧЛЭХ, ХҮЛЭМЖИД ДУСЛЫН СИСТЕМ СУУРИЛУУЛАХ, ЗАСВАРЛАХ АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ, 2023 ОНД ХҮЛЭМЖИД 332,370 ШИРХЭГ ЦЭЦЭГ, 1100 ГАРУЙ ШИРХЭГ ТАРЬЖ, УРГУУЛСАН.

Ногоон байгууламжийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн 215.0 сая төгрөгийн хөрөнгөөр 50 морины хүчтэй 1 трактор, олон үйлдэлт 1 техник худалдаж авч, парк шинэчлэлт хийсэн. Нийслэлийн төсвийн 89.6 сая төгрөгийн хөрөнгөөр 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Туул гол дагуу нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламжийн усалгааны эх үүсвэр, усжуулалтын системд шаардагдах 1 гүний худаг гаргах ажил хэрэгжсэн.

Зураг . Ногоон байгууламийн тоног төхөөрөмж




“Ногоон хот – Иргэний оролцоо” мод тарих аяны хүрээнд 14 дүгээр хорооны Айцын амны В хэсэгт 4.2 га талбайд шинээр ойн төгөл байгуулж 8328 ширхэг, 2022 онд байгуулсан А хэсгийн талбайд шинээр 1066, нөхөн тарилтаар 1003 ширхэг мод, сөөгийг тарьж, намрын цэнэг усалгаа, арчлалт хамгаалалтыг хийсэн.

Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ 185.7 сая төгрөгийн хөрөнгөөр шинээр 2 гүний худаг, 840 урт метр хашааг барьж, 10 тн багтаамжтай 2 усны нөөцийн сав суурилуулж, ойн төгөл байгуулсан талбайн усалгаа, арчлалт хамгаалалтыг хариуцан ажилласан.

Зураг . Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Айцын аманд хэрэгжүүлж буй ойн төглийн А хэсэг, “Ногоон хот – Иргэний оролцоо” мод тарих аяны нээлт



Зураг. Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Айцын ам, ойн төглийн талбайн В хэсэг



Тусгай хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн төсвийн хөрөнгөөр 13 дугаар хороонд Туул гол дагуу хамгаалалтын зурvas байгуулах “Төгсөгчдийн төгөл”-ийн 1.2 талбайд 1950 ширхэг суулгацыг тарьж, арчлалт хамгаалалтыг хийсэн.

Аж ахуйн нэгжийн гадна орчныг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, өөрсдийн эзэмшил болон нийтийн эдэлбэр газрын 50 метр хүртэлх талбайн хог хаягдал, угаалга цэвэрлэгээг тогтмол хийлгүүлж, өнгө үзэмжийг сайжруулах талаар зөвлөмж, уриалга, мэдэгдэл хүргүүлж, 15 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 6780 гаруй иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан.

Мөн 82 иргэн аж ахуйн нэгж 410 мод тарьж 0.3га-аар ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн.
Аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтарсан тохижилтын ажил:

Мөн худалдаа, үйлчилгээний газрын хаягийн байгууламжийг сайжруулах, тохижилт өнгө үзэмжийг сайжруулах чиглэлээр уриалга, зөвлөмж мэдэгдэл хүргүүлж, 107 аж ахуйн нэгж 735сая төгрөгийн тохижилтын ажил хийсэн.

Дүүргийн Засаг даргын 2023 оны А/56 дугаар захирамжаар баталсан “Хоггүй Хан-уул 2023 аян”-ыг эрчимжүүлэх ажлын хүрээнд дүүргийн ЗДТГ-ын даргын “Аян нэгдэх тухай” 08/508 дугаар албан бичгийг нийт 600 гаруй аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлсэн.

Мөн дээрх аяны хүрээнд аж ахуйн нэгжийг хамруулсан их цэвэрлэгээг 2023 оны 04 дүгээр сарын 08, 09-ний өдрүүдэд зохион байгуулсан. Аянд нийт 200 гаруй аж ахуйн нэгж оролцож 15,000M² орчим талбайг цэвэрлэн, 4 автобусны буудалд хөөстэй угаалга хийж орчны өнгө үзэмжийг сайжруулсан.



Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ, ахуйн үйлчилгээ, авто засвар үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй давхардсан тоогоор 2852 иргэн, аж ахуйн нэгжид хариуцах орчны 50 метр хүртэлх цас мөсний цэвэрлэгээ үйлчилгээнд 2023 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн албан хаагчид хяналт тавьж, цас мөсний цэвэрлэгээг хийлгэн, цэвэрлэгээний багаж хэрэглэлийн бэлэн байдлыг хангулан ажилласан



ХОЁРДУГААР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ҮР ДҮН

2.1 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн;

Засаг даргын Тамгын газрын Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах саналыг хэлтэс, тасгуудаас хүлээн авч нэгтгэн 5 бүлэг 69 зорилт, 180 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр батлуулсан.

2023 оны жилийн эцсийн байдлаар 69 зорилт 97 хувьтай, 180 арга хэмжээ 97.1 хувьтай тус тус хэрэгжсэн.

Хэрэгжилтийг бүлэг тус бүрээр нь ангилбал:

- Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 14 зорилт 96.4%, 22 арга хэмжээ 97.7%;
- Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааг хэрэгжүүлэх 18 зорилт 98%, 25 арга хэмжээ 98.8%;
- Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааг хэрэгжүүлэх 35 зорилт 97.7%, 56 арга хэмжээ 97.2%;
- Хууль тогтоомж, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх 1 зорилт 70 арга хэмжээ 97.8%;
- Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд 1 зорилт 7 арга хэмжээ 100%-тай тус тус хэрэгжсэн.

Гүйцэтгэлийн тайланг Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын -ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Гүйцэтгэлийн тайлангийн хэрэгжилтийн хураангуйг хүснэгтээр харуулбал:

№	БҮЛЭГ	Зорилт	Хувь	Арга хэмжээ	Хувь	ЧИГ ҮҮРХЭС (арга хэмжээ)				
						Бүрэг хувь 100% нэжүүдэх хувь	Хэрэгжүүлэх хувь 70%	Хэрэгжүүлэх хувь 30%	Хэрэгжилтийн хувь 0%	Хэрэгжилтийн хувь тооцух хувь
1	МУЗГУАХ	14	96,4	22	97,7	21	1	-	-	-
2	НЗДҮАХ	18	98	25	98,8	23	1	-	1	-
3	ДЗДҮАХ	35	97,7	56	97,2	53	2	-	1	-
4	ХТДХҮ	1	61	70	61	68	1	-	1	-
5	БХХТ	1	62.5	7	62.5	7	-	-	-	-

6	НИЙТ	69	97,8	180	97,1	69	5	-	3	-
---	------	----	------	-----	------	----	---	---	---	---

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт:

1. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын Б захирамж 95, Засаг даргын Тамгын газрын даргын Б тушаал 296, нийт 391 захирамж, тушаалын төслийг боловсруулж хянуулан батлуулсан.

2. ЗДТГ-ын даргын 2023 оны А/07 дугаар тушаалын хавсралтаар Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулсан бөгөөд ЗДТГ-ын даргын 2023 оны А/22 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг, 2 дугаар хавсралтаар Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг, 3 дугаар хавсралтаар Агаарын бохирдолтой тэмцэх тасгийн даргын албан тушаалын тодорхойлолтыг, 4 дүгээр хавсралтаар Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг тус тус батлуулсан.

3. Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1058 захирамжид нийцүүлэн “Дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, албан тушаалын жагсаалт батлах тухай” Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/104 дүгээр захирамжаар Засаг даргын Тамгын газрын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлуулсан. Батлагдсан бүтцийн дагуу төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтын харьцуулалтыг боловсруулан ЗДТГ-ын даргын 2023 оны 04/301 дугаартай албан бичгээр Төрийн албан зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн. Харьцуулалтын дагуу төрийн захиргааны 32 албан тушаалын тодорхойлолтын маягтыг боловсруулж холбогдох нэгжүүдээр хянуулан Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо” системээр хүсэлт илгээсэн.

4. Дүүргийн Засаг даргын 2023 оны А/20 дугаар захирамжийн хавсралтаар Дотоод аудитын албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг, А/237 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар еренхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалын тодорхойлолтыг, 2 дугаар хавсралтаар цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг, 2023 оны А/258 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар Албан бус-насан туршийн боловсролын төвийн захирлын албан тушаалын тодорхойлолтыг, 2 дугаар хавсралтаар Соёлын ордны даргын албан тушаалын тодорхойлолтыг, 2023 оны А/656 дугаар захирамжийн хавсралтаар Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хорооны даргын албан тушаалын тодорхойлолтыг тус тус батлуулсан.

5. Тайлант хугацаанд төрийн захиргааны удирдах 6, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 5, нийт 11 албан тушаалын тодорхойлолтыг батлуулсан бөгөөд Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны гүйцэтгэх 32 албан тушаалын тодорхойлолтыг батлуулахаар холбогдох маягтыг батлагдсан хяналтын хуудас болон ажлын байрны шинжилгээний хамт Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд цаасаар болон “Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо” системд цахимаар хүргүүлсэн.

6. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын албан хаагчдын төрийн жинхэнэ албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох саналыг боловсруулан Засаг даргын Тамгын газрын даргын 2023.02.20-ны өдрийн 04/279 дугаартай албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн. Саналд Засаг даргын Тамгын газрын 21, хорооны 18, дэргэдэх хэлтэс, албаны 5 албан хаагч, нийт 44 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгохоор тусгасан бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/511 дүгээр захирамжаар дээрх төрийн захиргааны 44 албан хаагчийн зэрэг дэв, түүний нэмэгдлийг шинэчлэн олгох ажлыг зохион байгуулсан.

7. Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолоор төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журмыг шинэчилсэн бөгөөд журмын дагуу Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо” системд нийт 123 албан хаагчийн ажил эрхлэлтийн түүхийг шинэчлэн бүртгэж, системд бүртгэгдсэн түүхийг үндэслэн нэмэгдлийг тооцож олгуулсан.

8. Тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 456 албан хаагчид илүү цагаар, долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдрүүдэд ажилласны нэмэгдэл хэлсийг олгуулсан.

9. Ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшил, тогтвортой суурьшилтай ажилласан байдал, амьдралын нөхцлийг харгалзан 34 албан хаагчийн нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлсэн.

Гадаад харилцаа хамтын ажиллагааны чиглэлээр:

Төрийн гадаад бодлого үйл ажиллагааны нэгдсэн байдлыг сайжруулах, байгууллага хоорондын гэрээ байгуулах чиглэлээр гарсан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 01/01, 2014 оны 46/26 дугаар зөвлөмж, Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”, Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-ыг гадаад харилцаатай холбоотой үйл ажиллагаандаа мөрдөж, гэрээ, хэлэлцээр болон санамж бичигт тусгаж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус дүүргийн гадаад харилцаа эрчимтэй хөгжиж, Бүгд найрамдах Солонгос Улсын Сөүл хотын Гванжин дүүрэг, Улсан хотын Намгу дүүрэг, Гёнсан аймгийн Хаман сум, Бүгд найрамдах Болгар Улсын Софи хотын Изгрев дүүрэг, Япон Улсын Мусашимураяама хот зэрэг газруудад хамтын ажиллагаа тогтоон төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэнд, соёл, спорт, эдийн засаг, хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуй, бизнесийн чиглэлээр үр ашигтай хамтран ажиллаж байгаа бөгөөд 2023 онд нийт 71 зочид төлөөлөгчдийг хүлээн авсан.



Хан-Уул дүүрэгтэй гадаад харилцаа хамтын ажиллагаатай улс орнуудын айлчлал болон дотоодын албан хаагчид, албан тушаалтуудын гадаад томилолтын асуудлын шийдвэрийн төслийг тухай бүр боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Уулзалт хэлэлцээр зохион байгуулсан талаар:

Бүгд найрамдах Турк улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Зафер Атеш Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан нар хамтын ажиллагааны чиглэлээр 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдөр уулзалт хийсэн. Тус уулзалтаар Элчин сайд Зафер Атеш хоёр орны хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд өргөжин хөгжих байгаа талаар дурдаж, Засаг дарга Ж.Алдаржавхлан хот нийтийн аж ахуй, тохижилтын чиглэлээр хамтарч ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлж, хоёр тал хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцсон.



Гэрээ санамж бичиг байгуулсан талаар:

❖ Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж технологийн дэвшил бүхий нэгдсэн хяналт удирдлагын системийг нэвтрүүлж эрчим хүчний хэмнэлт бий болгох зорилгоор Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Бүгд найрамдах Солонгос Улсын “Дасан Лайтинг” ХХК болон Монгол Улсын “Новелнэтворк” ХХК харилцан тохиролцсоны үндсэн дээр гурван талт хамтын ажиллагааны санамж бичигт 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр гарын үсэг сурсан.



Дээрх санамж бичиг хэрэгжсэнээр Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан “Эрчим хүчний ашиглалтын үр ашгийг өсгөж, дэд бүтцийг өргөжүүлэх, технологийн шинэчлэл хийж гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, нэгдсэн удирдлагын автомат системд холбох” зорилт хангажд, нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, тав тухтай орчинд зорчих зэрэг нөхцөл бүрдэх юм.

❖ Бүгд найрамдах Улсан хотын Нам дүүргийн зочид төлөөлөгчид 2023 оны 10 дугаар сарын 01-05-ны өдрүүдэд 34 хүний бүрэлдэхүүнтэй тус дүүрэгт дахин айлчилж, Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, Намгу дүүргийн Засаг дарга Со Дун Йк нар “Найрамдалт харилцаа байгуулах санамж бичиг”-т гарын үсэг зурсан.

Дээрх хамтын ажиллагааны хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр 14 дүгээр хорооны Айцын аманд хэрэгжүүлж буй ойн төгөл байгуулах төслийн талбайд 426 ширхэг шинэс тарих арга хэмжээг зохион байгуулсан.



❖ Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга С.Энхбаяр, Кённам их сургуулийн Гадаад харилцааны хэлтсийн дарга Хюн Сунёнг нар 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.

Тус санамж бичгийг байгуулснаар Хан-Уул дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудад Солонгос хэлний гүнзгий ангийг хичээллүүлэх, тухайн ангийг дижитал системээр хангах, багш сурагч солилцоог зохион байгуулах, мөн оюутнуудыг хөнгөлөлттэй нөхцөлөөр сургах чиглэлээр

харилцан тохиролцсон. Санамж бичгийн хүрээнд оюутан сургах хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна.

“Шагнал урамшууллын талаар:

Төрийн болон төрийн бус байгууллага боловсрол, эрчим хүч, хөнгөн үйлдвэрийн салбарт үр бүтээлтэй олон жил ажилласан 674 иргэнийг төрийн дээд одон медалиар шагнуулахаар нэр дэвшүүлсэн материалыг хянан шалгаж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 01, 10, 20 дугаар тогтоолоор хэлэлцүүлэн батлуулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.



Алдарт эхийн I, II дугаар одон авах 729 эхчүүдийн 35 боть архивын баримтыг НЗДТГ-т хүргүүлж, 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр гардуулах үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж ажилласан.

Боловсрол, эрчим хүч, хүнс хөдөө аж ахуй, эрүүл мэнд, спорт болон бусад салбарт үр бүтээлтэй олон жил ажилласан аж ахуйн нэгж, байгууллагуудын 230 ажилтан, албан хаагчдыг салбар яамдад уламжилсан.

Хан-Уул дүүргийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнагдах хүсэл гаргасан аж ахуй нэгж байгууллагын ажилтан, албан хаагчдын шагналыг материалыг хүлээн авч 180 иргэнийг “Хүндэт тэмдэг”-ээр шагнаж урамшуулсан.



Захиргааны актын эрх зүйн үндэслэлийг хянан, биелэлтийг тооцох чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд гаргасан Засаг даргын 748 захирамж, Засаг даргын Тамгын газрын даргын 368 тушаалын эрх зүйн үндэслэлийг хууль, тогтоомжид нийцүүлэн хянан зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Дүүргийн Засаг даргын 2023 онд батлан гаргасан **478** захирамжийн хэрэгжилтийг тооцон гаргасан, биелэлт **91.7%** буюу хангалттай хэрэгжсэн байна.

Гэрээний эрх зүйн үндэслэлийг хянах, бүртгэлжүүлэх:

Засаг дарга болон Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албанаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай байгуулсан **759** гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж, бүртгэлжүүлсэн байна.

№	Гэрээний индекс	Хэлтэс	Тоо
1	4/01	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	376
2	5/01	Санхүү, төрийн сангийн хэлтэс	40
3	6/01	Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс	25
4	9/01	Нийгмийн хөгжлийн хэлтэс	138
5	12/01	Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс	50
6	10/01	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	83
7	13/01	Цэргийн штаб	35
8	3/01	Хууль, эрх зүйн хэлтэс, Архивын хэлтэс	12
НИЙТ			759

Шүүхэд төлөөлөх, хууль хяналтын байгууллагатай харилцах чиглэлээр:

Иргэн, аж ахуй нэгж, байгууллагын нэхэмжлэлтэй 10 хэрэгт Захиргааны хэргийн шүүхэд, 3 хэрэгт иргэний хэргийн шүүхэд, цагдаагийн байгууллагад 3 нийт 16 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэлийн үндсэн дээр оролцож байна.

2023 онд анхан шатны шүүхийн хуралдаанд 26, давж заалдах шатны шүүхийн 8 нийт 34 хуралдаанд цахимаар болон танхимаар оролцож:

- Иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон 2,
- Актын биелэлтийг түдгэлзүүлсэн 1 хэрэг маргаан байна.

Хууль эрх, зүйн хэлтсээс зохион байгуулах сургалтын төлөвлөгөө"-г дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан Авлигатай тэмцэх газрын, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс, нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар, Хуульчдын холбоо, Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар, дүүргийн тойргийн нотариатчидын салбар, Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабтай хамтран сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, төлөвлөгөөний дагуу эрх зүйн 8 сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 1160 иргэн, албан хаагч;

Монголын Хуульчдын холбоотой хамтран "Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн танилцуулга" сэдэвт сургалтын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс болон аж ахуйн нэгж байгууллагуудын хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын гишүүдийг хамруулсан. Сургалтад нийт 180 албан хаагч, иргэн;

Хан-Уул дүүргийн тойргийн нотариатчидын салбартай хамтран “Өв залгамжлалын эрх зүйн харилцаанд Засаг дарга болон нотариатчийн хүлээх үүрэг” сэдэвт сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулж нутгийн захиргааны байгууллагын 70 албан хаагч;

Цэргийн штабтай хамтран Төрийн албаны тухай хууль, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль Тамгын газрын дотоод журмын талаарх мэдээлэл өгөх сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж 50 албан хаагч;

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан уг хуулийн онцлог өөрчлөлтийн талаарх сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс албадын албан хаагчдад зохион байгуулсан. Тус сургалтад нийт 95 албан хаагч;

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан уг хуулийн талаарх сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр дүүргийн дэргэдэх хэлтэс, албадын 130 албан хаагч;



Шүүхийн тухай хууль, шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, шүүх хуралдаанд оролцох ач холбогдлыг таниулах, тэдгээрийн идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор сонгогдсон иргэдэд 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр сургалт зохион байгуулж 109 иргэн;



НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд ерөнхий боловсролын 130 дугаар сургуулийн 25 сурагчид 5 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд, 52 дугаар сургуулийн 25 сурагчдад 9 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд “Хариуцлагатай сонгогч” сургалтыг тус тус зохион байгуулж хамрагдсан сурагчдад гэрчилгээ гардуулсан.

Монгол Улсын “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн 2024-2025 онд шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцох 10734 иргэний мэдээллийг хороодтой хамтран нягталж, эрх зүйн чадамжтай эсэх, 25-60 хүртэлх насны Монгол улсын иргэн, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин судаг эсэхийг болон иргэдийн оршин суух хаяг, утасны дугаарыг тодруулан нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар, Баянгол, Хан-Уул,

Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар, Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн.

Түргэн үйлчилгээний цэг, ил задгай худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын 2023 оны “Газрын зөрчил арилгаж, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах тухай” А/202, А/545 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийтийн эзэмшилийн зам талбай, автобусны буудалд явган хүний болон хөгжлийн бэрхшээлтэй хүний зам хааж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчимд зөвшөөрөлгүй байршуулсан 94 түргэн үйлчилгээний цэгийг дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлж ажилласан.



Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны “Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт ил задгай, зөвшөөрөлгүй, худалдаа, үйлчилгээ явуулж буй иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” удирдамжаар Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар, дүүрэг дэх Цагдаагийн газар, Мал эмнэлгийн тасаг, хороодтой хамтарсан ажлын хэсэг 6 удаагийн хяналт шалгалт хийж, зөрчлийг тухай бүр арилган, 2 иргэнд тус бүр 20 нэгжийн торгуулийн арга хэмжээ авч, хүнсний аюулгүй байдлыг хангуулан, зөвлөн тусалж ажилласан.



Явуулын үйлчилгээтэй хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд стандарт шаардлагыг мөрдүүлэх, дэмжин ашиглах чиглэлээр:

- Дүүргийн нутаг дэвсгэрт Зайсан туул гол дагуу явуулын үйлчилгээтэй түргэн хоолны үйлчилгээ эрхлэгчдэд эрүүл ахуйн стандарт шаардлагад хяналт шалгалт хийж, Богдхан уулын Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, дүүргийн Газар зохион байгуулалтын албатай хамтран газар чөлөөлөх албан мэдэгдэл хүргүүлсэн.

- Дүүргийн Засаг даргын 2023 оны “Газрын зөрчил арилгаж, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах тухай” А/202 дугаар захирамжаар эрүүл ахуйн стандарт шаардлага хангахгүй, зориулалтын бус зөөврийн байгууламжид түргэн хоолны үйлчилгээ явуулж буй нийт 15 түргэн хоолны цэгийг нүүлгэн шилжүүлсэн.

Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэгийн стандарт шаардлага хангаж буй 5 иргэнийг олон нийтийн арга хэмжээнд оролцуулан, үйл ажиллагааг дэмжин, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад хяналт тавин ажиллаж байна.



Аялал жуулчлалын чиглэлээр:

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн баталсан “Зочлох үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдтэй хамтран аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг иргэдэд таниулах арга хэмжээ зохион байгуулах тухай” ажлын удирдамж батлуулсан.

Дүүргийн байгаль, түүхийн дурсгалт газар болон бүтээн байгуулалтын ажлуудыг иргэдэд сурталчлан таниулах зорилгоор “Их түүхийн жимээр” аяллын маршрутын дагуу ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад З удаагийн аяллыг зохион байгуулж, хүүхэд залуучуудад аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдлэг олгосон. Мөн аяллын хугацаанд хоол хүнсний зохистой хэрэглээ, утаат болон электрон тамхины хор хөнөөлийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын 32 газарт зочид буудал, дэн буудал, амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага, хотын стандартыг танилцуулах, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр туршлага солилцох, танилцуулах сургалтыг зохион байгуулж 122 ажилтан, албан хаагчдыг хамруулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Зочлох үйлчилгээний салбарын онцлог, бүтээгдэхүүн үйлчилгээг иргэдэд сурталчлан, таниулах чиглэлээр олон нийтийн арга хэмжээнд аж ахуйн нэгжүүдийг хамруулан ажилласан.

Үүнд:

- Улс, үндэстний зан заншил, соёлыг иргэдэд сурталчлан таниулах зорилгоор “Бүргэдийн баяр”, “Тэнгэр” олон улсын бөө мөргөлийн фестиваль, үндэсний их баяр наадам, “Даншиг наадам-Хүрээ цам 2023” зэрэг 7 удаагийн арга хэмжээнд зочлох үйлчилгээний салбарын 13 аж ахуйн нэгжийг хамруулсан.
- Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, үндэсний хоолыг сурталчлах зорилгоор “Бүтээгч Хан-Уулчууд 2023” нийт 3 удаагийн арга хэмжээнд хоол үйлдвэрлэл, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч 42 иргэн, аж ахуйн нэгжийг оролцуулсан.
- “Улаанбаатар Травэл Экспо- 2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд салбарын 16 аж ахуйн нэгжийг оролцуулан, үйл ажиллагааг тус тус сурталчлан ажилласан.



НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**Эрүүл мэндийн чиглэлээр:**

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо” 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байна. Энэхүү ажлын хүрээнд:

0-5, 6-17 насны хүүхдүүд Өрхийн эрүүл мэндийн төвд, 18-30, 31-45, 46-60, 61-ээс дээш насны иргэд Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, “Гэгээн ар үр” эмнэлэг, Энхсаран сувилал, ЭНЭҮТ-2, Санмединикол эмнэлэг, Клинико эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүд эрт илрүүлгийн үзлэг шинжилгээ, оношилгоонд хамрагдаж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар 0-5 насны 21090, 6-17 насны 44028, 18-30 насны 7872, 31-45 насны 18334, 46-60 насны 15689, 61-ээс дээш насны 10367, нийт 117380 иргэн буюу 55.7% эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ оношилгоонд хамрагдаад байна.

Халдварт өвчний эрт илрүүлгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

Сүрьеэгийн эрсдэлт бүлгийн иргэдийн дунд сүрьеэ өвчнийг илрүүлэх үзлэг шинжилгээг Монголын Өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо, дүүргийн сүрьеэгийн диспансер, хороод, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс 7 дугаар сарын 06-ны өдрийг хүртэлх хугацаанд 4, 5, 6, 7, 8, 9, 10, 16, 21, 23, 24, 25 дугаар хорооны эрсдэлт бүлгийн 1205 иргэнийг үзлэг хамруулсан.

“Эерэг хандлага-Эрүүл оюутан” оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд харьяа их дээд сургууль, MCYT, коллежийн 253 оюутан сургалчад бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа зохион байгуулж, эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулсан.



Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх, идэвхтэй эрт илрүүлэг, оношилгоо, хяналтын чиглэлээр 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр хорооны 17 нийгмийн ажилтан, зохион байгуулагч нарт сургалт зохион байгуулсан.

“Тогтвортой хөгжлийн зорилт”-ыг хангах хүрээнд эмч, эмнэлгийн ажилтнуудыг дараах сургалтуудад хамруулсан Үүнд:

№	Сургалтын багц	Хамрагдсан эмнэлгийн ажилтны тоо
1	Хүүхдийн сэргийлж болох өвчлөл, эндэгдлийг бууруулах, 0-5 насны хүүхдийн үзлэг, хяналт, хүүхдийн өвчлөлийн цогц менежментийн хэрэгжилтийг сайжруулах, томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдлын сургалт	Төрийн өмчийн 32 цэцэрлэгийн эмч
2		Өрхийн эрүүл мэндийн 15 төвийн 23 залуу эмч

3	Сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулах, эрт илрүүлэлтийг нэмэгдүүлэх, мэдлэг арга зүйгээр хангах сургалт	Өрхийн эрүүл мэндийн 15 төвийн 40 эмч
4	6 настай хүүхдүүдийн бие бялдрын хөгжлийн үнэлгээ ба зүрхний эмгэгийн илрүүлэх сургалт	Өрхийн эрүүл мэндийн төв, ерөнхий боловсролын сургуулиудын 39 эмч
	Нийт	134

Бэлгийн замын халдвараас урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгаа явуулах, "Үе тэнгийн сургагч багш бэлтгэх" З удаагийн сургалтад ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллежийн оюутан, сургуулийн эмч, багш, нийт 500 гаруй хүнийг хамруулсан. Уг сургалтын хүрээнд 48 сургагч багшийг бэлтгэсэн.



Эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр:

Хан-Уул дүүргийн Эх, Хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг дүүргийн Засаг даргын 2023 оны А/380 дугаар захирамжаар баталсан. Орон тооны бус зөвлөл 5 зорилтын хүрээнд 34 төсөл арга хэмжээг төлөвлөн 70%-тай хэрэгжүүлсэн.

Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тасгаар хүүхдийн амны хөндийн үзлэг, оношилгоо, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэлт 30586 хүүхэд, "Амны хөндийн эрүүл ахуй", "Амны хөндийн эрүүл мэнд, шүд зөв угаах арга барил", "Амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох" сургалтуудыг зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл, зөвлөмжийг 17748 хүүхэд, 600 гаруй эцэг, эхчүүдийг хамруулсан. Тус ажлын хүрээнд нэн шаардлагатай 1785 хүүхдэд форт түрхлэгийг түрхсэн.



Биеийн тамир, спортын чиглэлээр: /Өвлийн спорт/

1. "Мөнгөн Хан-Уул" өвлийн биеийн тамир спортын арга хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн 79 байгууллагын 1153 албан хаагч,
2. Монголын хүүхдийн спортын өвлийн VII их наадмын 4 төрөлд 53 тамирчин алтан медаль 4, мөнгөн медаль 5, хүрэл медаль 2,
3. Монголын Бүх ард түмний өвлийн спортын XVI их наадмын шигшээ тэмцээнд 3 төрөлд 9 тамирчин алтан медаль 4, мөнгөн медаль 7, хүрэл медаль 6, өсвөрийн шигшээ багийн тамирчид улсын хэмжээнд спортын 11 төрлөөр 24 удаагийн тэмцээнд нийт 531 тамирчин оролцож алтан медаль 73, мөнгөн медаль 43 хүрэл медаль 74 нийт 176 багц медаль,
4. Казахстаны Алматы хотноо зохион байгуулагдсан Өсвөр үеийн Азийн цомын тэмцээнд 4 тамирчин оролцож алтан медаль 1, хүрэл медаль 1 тус тус хүртсэн.



/Зуны спорт/

1. Монголын хүүхдийн спортын зуны VII их наадмын шигшээ тэмцээнд 21 аймаг, 9 дүүргийн 43 мянган өсвөрийн тамирчдаас шалгарсан шилдэг 7000 тамирчид спортын 23 төрөлд өрсөлдсөнөөс Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн 200 тамирчин спортын 21 төрөлд өрсөлдөж, 26 алт, 22 мөнгө, 24 хүрэл, нийт 72 медаль хүртэж, улсад Тэргүүн байр эзэлсэн.

2. ОХУ-ын Красноярска хотноо зохион байгуулагдсан “Красноярская лига” жудо бөхийн олон улсын тэмцээнд 11 тамирчин оролцож алтан медаль 4, мөнгөн медаль 1, хүрэл медаль 4 хүртсэн.



3. Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит Залуучуудын сагсан бөмбөгийн тэмцээнийг 2023 оны 6 дугаар сарын 03-наас 17-ны өдрүүдэд “Ган спорт төв”-д “Нисэх, алсын бүс, яармаг бүс, төвийн бүс” гэсэн бүсчлэлээр, бүсээс шалгарсан шигшээ багуудын тогтолтыг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдөр зохион байгуулж, давхардсан тоогоор 48 багийн 600 гаруй тамирчин оролцсон.



4. Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит спортын 5 төрөлт тэмцээнийг нутгийн захиргааны байгууллагуудын дунд 2023 оны 6 дугаар сарын 13-18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тэмцээнд Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс албад нийт 27 байгууллагын 19 баг оролцсон бөгөөд давхардсан тоогоор 600 гаруй албан хаагчид хамрагдсан.

Байгууллагын нэгдсэн дүнгээр:

I байр: Татварын хэлтэс

II байр: Засаг даргын Тамгын газар

III байр: Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хамтарсан баг тус тус шалгарсан.



Дүүргийн Иргэдийн спортын XI их наадмыг 2023 оны 05 дугаар сараас 11 сарын хооронд 3 ўе шаттайгаар явган аялал, олс таталт, сагсан бөмбөг, волейбол, хийн дасгал, аеробик, софт волейбол, ширээний шагайн наадгай, дартс гэсэн спортын 9 төрлөөр зохион байгуулж 25 хорооны нийт 4900 иргэн хамруулсан.

Иргэдийн спортын XI их наадмын Нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд шалгарсан 150 баг тамирчид оролцож, алтан медаль-4 ширээний шагай /эм/, хийн дасгал, сагс бөмбөг /эр/, дартс, мөнгөн медаль-1 явган аялал, хүрэл медаль-3 олс таталт /эр, эм, сагсан бөмбөг /эм/ нийт 7 медаль 48 оноогоор Тэргүүн байр эзэлсэн амжилтыг



Боловсролын чиглэлээр:

1. Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Х.Кобаяши болон Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан нар 2023 оны 3 дугаар сарын 07-ны өдөр Япон Улсын Засгийн газрын “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламж”-ийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих Хан-Уул дүүргийн Ерөнхий боловсролын 60 дугаар сургуулийн засвар” төслийн гэрээнд гарын үсэг зурж, 401,0 сая төгрөгийн санхүүжилтээр засварын ажил хийгдсэн.



Дүүргийн Засаг даргын нэрэмжит хими, физик, математикийн хаврын олимпиадыг төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 33 сургуулийн 11, 12 дугаар ангийн сурагчдын дунд 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулж, 513 сурагч оролцсон.

Мөн Дүүргийн Засаг даргын нэрэмжит хими, физик, математикийн намрын олимпиадыг 2023 оны 11 дүгээр сард 2 ўе шаттайгаар зохион байгуулж, төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 46 сургуулийн 10, 11, 12 дугаар ангийн 10600 гаруй сургач оролцсон. Олимпиадад бусдыгаа манлайлан оролцож шилдгээр шалгарсан 102 сургач, 57 багшид дүүргийн Засаг даргын нэрэмжит шагналыг олгосон.



Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний мэдлэг дадлага олгох, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор “Замын хөдөлгөөний цагаан толгой-2023” тэмцээнийг 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж, төрийн өмчийн 19 цэцэрлэгийн 266 хүүхэд оролцсон.



Төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний шалгалт 2023 оны 5 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд явагдсантай холбогдуулан тус дүүргийн алсын бүсийн ерөнхий боловсролын 4 сургуулийн 10 бүлгийн 1 дүгээр ангид суралцаж буй 350 сургачид 2022-2023 оны хичээлийн жилд амжилттай суралцаж, үнэлгээний шалгалтад идэвхтэй хамрагдсанд дүүргийн Засаг даргын зүгээс баяр хүргэж, дэлхийн хүүхдийн шилмэл зохиолын түүврээс бэлэглэсэн.



Хан-Уул дүүргийн Боловсролын салбар дахь “Шинэ санаачилга-Шилдэг туршлага” анхдугаар зөвлөгөөнийг 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулж, дүүргийн төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, цэцэрлэгийн эрхлэгч, холбогдох мэргэжилтнүүд нийт 129 багш оролцож, боловсролын салбар дахь шинэ санаачилга, шилдэг туршлагыг харилцан судалж, санал хүсэлтээ илэрхийлсэн.



Хан-Уул дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын охид, хөвгүүдийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, 2023-2024 оны хичээлийн жилд зохион байгуулах арга хэмжээг танилцуулах, санал солилцох, дүүргийн хэмжээнд жишиг зөвлөл бий болгох идэвх санаачилгыг дэмжих зорилгоор “Хан-Уул дүүргийн охид, хөвгүүдийн зөвлөлийн нээлтийн үйл ажиллагаа”-г 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр дүүргийн Соёлын ордонд зохион байгуулсан. Үйл ажиллагаанд дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 23 сургуулийн ахлах ангийн 160 сургач оролцсон.



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сар шинийн баярын мэндчилгээ, гарын бэлгийг тус дүүргийн 100 ба түүнээс дээш настай 8 ахмад настанд хүлээлгэн өгсөн.

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Ахмадаа дээдэлье” дэд хөтөлбөрийн хүрээнд сар шинийн баярыг угтан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх төслийг хэрэгжүүлж, Хан-Уул дүүргийн Засаг даргын гарын бэлгийг 5500 ахмад настанд олгосон.



Хан-Уул дүүргийн Засаг даргын захирамжаар 3,4,5,6,9,10,12,13,14,22 дугаар хорооны зорилтот 25 өрхөд 5 ханатай иж бүрэн гэр, Бүгд найрамдах Турк улсын байгалийн гамшигт нэрвэгдсэн иргэдэд зориулсан хандивын аянд дүүргийн Засаг дарга, иргэдээс олгох хандивын 3 гэрийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгсөн.



“Эко ахмадын сувилал” ОНӨААТҮГ нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргатай 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдөр гэрээ байгуулж, ахмад настнуудад хөнгөлөлттэй үйлчлэх амралт, сувиллын эрхийг авч гэрээний дагуу 2023 оны 6-10 дугаар сарыг хүртэл 698 ахмад настныг хүлээн авч үйлчилгээ үзүүлсэн.



Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан 25 хорооны 1000 гаруй ахмад настнуудад 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр хүндэтгэл үзүүлсэн.



Соёл, урлагийн чиглэлээр:


Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Аварга ахлах сургууль, Хүнс, технологийн политехник коллеж, Монгол Солонгосын политехник коллеж, ШУТИС-ийн Механик, тээврийн сургуулийн MCYT, Герман Монголын MCYT, Хангай MCYT-ийн оюутнуудын дунд “Хотын соёлд-Бидний үйлдэл” илтгэлийн тэмцээнийг 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулж, 100 гаруй оюутныг хамруулсан.



Монголчуудын уламжлалт соёл, түүний дотор үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Дээлтэй Монгол наадам”-д 21_аймаг, 9 дүүргийн төлөөллөөс гадна БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Альшаа аймаг, БНХАУ-ын Шинжьян-Уйгурын Өөртөө Засах орон, мөн ОХУ-ын Тувагийн Бүгд Найрамдах Улсын төлөөлөл оролцсоноос Хан-Уул дүүрэг “ШИЛДЭГ ДҮҮРЭГ”-ээр шалгарсан.

“Даншиг наадам-Хүрээ цам 2023” шашин, соёлын наадам Хүй долоо худагт 8 дугаар сарын 5, 6-ны өдрүүдэд Монгол улсын соёлын биет бус өвийг таниулан сурталчлах зорилгоор дүүргийн онцлогийг харуулсан гэрийг иргэдэд зориулан тохижуулсан. Тус наадамд 25 хорооны 800 гаруй иргэд, 25 соёлын өв уламжлан тээгч, авьяастан уран бүтээлчид, албан хаагчид, 20 орчим гадаадын жуулчид, 150 орчим дотоодын зочид төлөөлөгч, 2 өдрийн турш монгол ардын уртын дуу, аман хуур, биелгээ, хуурын татлага, уран нугаралт, бүжиг, ерөөл магтаал тоглолтыг зохион байгуулсан.

“Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль”-д Соёлын өвийн орон зайд, бүтээлчүүдийн үйлдвэрлэл, уламжлал шинэчлэл, Соёлын биет бус өвийн олон төрөл зүйлийг түгээн дэлгэрүүлэх, илэрхийлэх хэлбэр, язгуур өв соёлоо дээдэлж, тус байгууллагаас зохион байгуулалттай оролцсон ба гадаад дотоодын жуулчид, Хан-Уул дүүргийн иргэдийг соёлын өвийн отгоор аялуулан, “Монгол түмний их цэнгэл наадаан” хүндэтгэлийн тоглолт, шилдэг өвлөн уламжлагчдын зан үлийн үзүүлбэр, гала тоглолт, аж ахуйн нэгжийн үзэсгэлэн худалдаа, орон орны 9 үндэстний уламжлалт хоол хүнс, идээ ундааны үзэсгэлэн худалдаагаар аялуулах ажлыг зохион байгуулсан.



Нийслэлийн Засаг даргын ивээл дор уламжлал болгон зохион байгуулагддаг Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Дагвуын Лувсаншараавын нэрэмжит Хүүхдийн найрал дууны шилдэг хамтлаг шалгаруулах 29 дэх удаагийн уралдааны 1 дүгээр шатыг 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 13 сургуулийн 750 гаруй сурагч оролцсон. Ерөнхий боловсролын 18 дугаар сургууль, Шинэ Монгол Харуматфуки сургууль 2 дахь шатны шалгаруулалтад оролцож, ерөнхий боловсролын 18 дугаар сургууль дэд байранд шалгарч амжилтаа ахиулсан. Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэр Богд Хан ууланд байрлах “Чингис хааны сэрэг дүр”-ийг сэргээн засварлалт, шинэчлэлтийн ажлыг 7,0 сая төсвөөр сэргээн засварасан.

Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хан-Уул дүүргийн 50 жилийн ойн өндөрлөг”-ийг Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн А/365 дугаар захирамжаар сэргээн засварлах ажлыг дүүргийн “Тохижилт үйлчилгээний төв” ОНӨААТҮГ гүйцэтгэсэн.



Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх “Ажилчны алдар” талбайг дүүргийн хөрөнгө оруулалтаар орчин үеийн стандартад нийцүүлэн шинэчлэл, тохижуулж байна. Талбайн тохижилт, засвар, шинэчлэлт хийхтэй холбогдуулан тус талбайд байрладаг 10 гаруй түргэн үйлчилгээний цэгүүдийг нүүлгэн



шилжүүлж, талбайг чөлөөлж, тохижилт, угсралтын ажлыг хийгдэж байна.

Хан-Уул дүүргийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлөөс дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/31 дүгээр тушаалаар өөрийн байртай 21 хорооны барилга байгууламжийн хүртээмжийн үнэлгээ хийх ажлын хэсгийг томилон 2023 оны 4 дүгээр сарын 15-21-ний өдрүүдэд “Түгээмэл хөгжил тев” төрийн бус байгууллагатай хамтран хороодын байранд үнэлгээ хийсэн.

2. Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны А/255 дугаар захирамжаар 25 хорооны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний зөвлөлийг байгуулж, “Хөгжлийн бэрхшээл ба хүний ялгаатай байдал” сургалтыг 25 хорооны 100 гаруй ажилтан, албан хаагч, иргэдийн дунд зохион байгуулсан.



3. Хөгжлийн бэрхшээлтэй буюу харааны бэрхшээлтэй иргэдийн дунд хонхтой бөмбөгийн тэмцээнд 70 иргэн, Оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийн дундараачи, тусгай бочи 2 насны ангилалд 60 хүүхэд, хараагүй насанд хүрэгчдийн дунд үндэсний бөхийн 32 бөхийн барилдаан, хөгжлийн бэрхшээлтэй буюу харааны бэрхшээлтэй иргэдийг нийслэл болон бусад дүүргүүдийн аварга шалгаруулах тэмцээн 82 иргэн, Нийслэлийн аварга шалгаруулах оюуны бэрхшээлтэй хүний спорт тусгай бочи 10, тулгуур эрхтний бэрхшээлтэй суугаа волейболын тэмцээнд 20 иргэн, “Хөл бөмбөгийн анхдугаар лиг” харааны бэрхшээлтэй хүний хөл бөмбөгийн тэмцээнд 6 иргэнийг тус тус оролцуулсан.



4. Хөгжлийн бэрхшээлтэй 240 иргэнд спорт хорооны заалаар үнэ төлбөргүй үйлчилсэн.

Монголын хүүхдийн зуны спортын VII наадмын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын наадмын хонхтой бөмбөгийн дүүргийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнийг 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир, спортын хороо, Нийслэлийн 116 дугаар сургууль, Монголын хонхтой бөмбөгийн холбоотой хамтран амжилттай зохион байгуулж, Улсын шигшээ тэмцээнд 8 төрлөөр оролцож 15 медаль хүртэж, байгууллагын нэгдсэн дүнгээр Гуравдугаар байр эзэлсэн амжилтыг үзүүлсэн.



Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын үйл ажиллагаа:

Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс 43 удаа хуралдаж 5291 иргэнд эмнэлэг хөдөлмөрийн магадалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Хөдөлмөрийн чадвар алдсан шинээр 565, хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгасан 4358 хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцалсан 368, өндөр насны тэтгэвэр тогтоосон 124, шилжин ирсэн, явсан 153, нас барсан 206.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаа:

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны А/481 дүгээр захирамжаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс”-ын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.

Тус комисс 16 удаа хуралдаж, 621 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг хэлэлцэж, байнгын асаргааг шинээр тогтоосон 221, асаргаа сунгасан 333, асаргааг цуцалсан 6 хүүхдийн асуудлыг шийдвэрлэсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл:

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг иргэдэд танилцуулах хөдөлмөрийн өдөрлөг яармагт 400 иргэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжийг сурталчлах, ажлын байран дахь эрсдэлийг бууруулахад салбар хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, харилцан сайн туршлага солилцох уулзалт өдөрлөгийг зохион байгуулж, барилгын болон боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулдаг 150 гаруй байгууллага, 380 аж ахуйн нэгж байгууллагаас 650 ажлын байрны захиалгыг хүлээн авч, 1557 иргэнийг ежов мэдээллийн санд бүртгэж, 140 ажил хайгч иргэдийг ажлын байранд зуучлан ажилласан.

Гэр бул, хүүхэд, залуучуудын чиглэлээр:

Барилга, хот байгуулалтын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан тушаалаар "Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" аяныг зохион байгуулах ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс хамтран "Ажил олгогчидтой" хийх уулзалт, зөвлөгөөнийг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан.

Тус уулзалт зөвлөгөөнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй 112 аж ахуй нэгж байгууллагын ажил олгогч буюу удирдлага, хүний нөөцийн мэргэжилтэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтнууд оролцсон.



Хөдөлмөрийн “Нэн тэргүүнд хөдөлмөрийн аюулгүй байдал” сургалтын барилгын үйл ажиллагаа явуулж буй 50 гаруй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүдэд зохион байгуулж, “Нутгийн буян” группийн “Хаппи резиденс” төслийн үйл ажиллагаатай танилцуулсан.



Нийслэлийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2017 оны 03 дугаар тогтоолоор жил бүрийн 5 дугаар сарын сүүлийн долоо хоногийн Лхагва гарагийг “Нийслэлийн хүүхдээ сонсох өдөр” болгосон. Тус ажлын хүрээнд 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр “Хүүхдээ сонсох өдөр”-ийг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, төрийн болон төрийн бус өмчийн 18 сургуулийн ахлах ангийн сурагчдын төлөөлөл 70 сургач оролцсон.

Хан-Уул дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт суралцаж буй хүүхэд багачуудын авьяас чадварыг нээн хөгжүүлэх, соёл урлагаар дамжуулан гоо зүйн боловсрол олгох, харилцан суралцах, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилготой Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит “Хүүхдийн урлагийн Их наадам”-ыг 2023 оны 5 дугаар сарын 15, 20, 21-ний өдрүүдэд дүүргийн Соёлын ордонд зохион байгуулсан.

Хүүхдийн урлагийн Их наадамд дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн 34 цэцэрлэгийн 374 хүүхэд, ерөнхий боловсролын 27 сургуулийн 638 сургач, нийт 1000 гаруй хүүхдүүд оролцож, урлагийн 3-4 төрөлд авьяас чадвараа сорин өрсөлдсөн.

Хүүхдийн урлагийн Их наадмын цэцэрлэгийн насны ангиллын “Шилдэг багш”-аар “Үнгэлжин ба 7 одой” цэцэрлэгийн багш В.Ухаанбилэг, “Шилдэг цэцэрлэг”-ээр 73 дугаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн “Шилдэг багш”-аар нийслэлийн ерөнхий боловсролын 18 дугаар сургуулийн багш О.Дорждэрэм, “Шилдэг сургууль”-иар Нийслэлийн ерөнхий боловсролын 18 дугаар сургууль тус тус шалгарсан.



Өсвөр үе, хүүхэд, залуучуудыг түүх, соёлоо дээдэлсэн, эх оронч үзэлтэй, үүрэг хариуцлагаа ухамсарласан иргэн болгон төлөвшүүлэх зорилгоор жил бүр уламжлан болгон зохион байгуулдаг “Монгол Улсын иргэний үнэмлэх гардуулах, андгай өргөх ёслолын үйл ажиллагаа”-г 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын 16 нас хүрсэн 70 гаруй сургачид оролцож, Монгол Улсын иргэний үнэмлэхээ гардан авч, андгай өргөсөн




◆ Жендерийн эрх тэгш байдлыг хангах, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Харилцан хүндэтгээ” сарын аяны хүрээнд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг нэгдэхийг уриалж, “Эмэгтэйчүүдийн манлайлал” уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулан 75 албан хаагчдад, “Жендерийн тухай ойлголт, Жендерт суурилсан хүчирхийллэл”, “Хөдөлмөрийн харилцааны ялгаварлан гадуурхалт” сургалтыг 6 байгууллагын 223 албан хаагчдад, “Жендерийн талаарх ойлголт, харилцаа хандлага” сургалтыг Жендерийн салбар хорооноос 8 сургуулийн 200 гаруй оюутан, сургачдад, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллежийн оюутнуудын дунд илтгэлийн тэмцээнд 50 гаруй оюутан хамрагдан, дээрх үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг www.khan-uul.mn, “Хан-Уул Эко дүүрэг” зэрэг албан ёсны цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчилсан.

 “Жендээрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ыг Монгол Улсад “Хүндлэл-хамгийн тод гэрэл” уриа дор тэмдэглэн өнгөрүүлсэн. Аяны хүрээнд Жендээрт суурилсан хүчирхийллийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, жендээрт суурилсан аливаа ялгаварлан гадуурхалт, хэвшмэл ойлголтыг өөрчлөх, энэ төрлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор Хан-Уул дүүрэг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан удирдамж, төлөвлөгөөний хүрээнд 9 төсөл арга хэмжээг 83,0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн.



Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв, Имонос, Индранил шүдний эмнэлэг, Синдура медтэй хамтран 2023 оны 11 дүгээр сарын 20-оос 12 дугаар сарын 8-ны өдрийн хооронд Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс, албадын 500 гаруй ажилтан, албан хаагчдыг “Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо”-нд хамруулсан.



“МАНАЙ ХОРОО- МИНИЙ ГУДАМЖ 2023” АЯНЫ ХҮРЭЭНД:

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны А/24 дүгээр тушаал, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/105 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт “Манай хороо – Миний гудамж” аяныг зохион байгуулж, ажлын тайлан мэдээг 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанад хүргүүлсэн.

Аяны нэгдсэн шалгаруулалтын дүнд шилдэг тохижилттой гэр хороо номинацийн нэгдүгээр байранд 13 дугаар хороо, тусгай байранд 6, 16 дугаар хороо, шилдэг тохижилттой орон сууц хороо номинацийн 3 дугаар байранд 3 дугаар хороо, шилдэг хог тээврийн байгууллага номинацийн 2 дугаар байранд “Эко хотын тээвэр” ОНӨААТҮГ, тусгай байранд “Хан-Уул Агро”

ОНӨААТҮГ, шилдэг зам цэвэрлэгээний байгууллага номинацийн нэгдүгээр байранд Охь мандал ХХК, шилдэг орон сууцны контор номинацийн нэгдүгээр байранд “Хайспийд” ХХК, тусгай байранд “Хүннү хотхон” ХХК, шилдэг сууц өмчлөгчдийн холбоо номинацийн тусгай байранд “Цэнгэлдэх өргөө” СӨХ тус тус шалгарсан.



Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байдал:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб нь Батлан хамгаалахын сайд, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээ, дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх Эко дүүрэг үйл ажиллагааны хөтөлбөр, Цэргийн штабын 2023 оны үйл ажиллагааны

төлөвлөгөөнд 54 арга хэмжээ төлөвлөснөөс 2023 оны жилийн эцсийн байдлаар 95 хувийн биелэлттэй байна.

Батлан хамгаалахын сайдын Нийслэлийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээнд 5 бүлэг 37 нэр төрлийн ажил, үйлчилгээ тусгагдсанаас гэрээний хэрэгжилт 94 хувтай байна.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 44 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/469 дүгээр захирамжийг үндэслэн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/295 дугаар захирамжаар цэргийн дүйцүүлэх албанад 6 иргэнийг элсүүлсэн.

№		2021	2022	2023
1	Алба хаасан	6	10	6
2	Алба хааж байгаа болон шинээр элссэн	6	6	6
3		Одоогоор 9 иргэн дүйцүүлэх албыг биеэр хааж байна.		

Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хааж байгаа байдал Цэргийн албаны тухай хуулийн 29.3-д заасны дагуу хугацаат цэргийн алба хаах насын дээд хязгаарт хүрсэн 1994-1997 онд төрсөн 192 иргэнээр 230,384,855 (хоёр зуун гучин сая гурван зуун наян дөрвөн мянга найман зуун тавин таван) төгрөгийг Нийслэлийн төрийн сангийн 100200000984 тоот дансанд төвлөрүүлэн хууль тогтоомжийн дагуу 27 иргэнийг мөнгөн төлбөрөөс чөлөөлөн тэмдэглэл хөтөлсөн.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны Цэргийн дүйцүүлэх албаны тусгай үүргийн бэлтгэл шатны сургалт зохион байгуулах тухай А/1046 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2023 оны А/546 дугаар захирамжийн дагуу БЗД-ийн дүүргийн Гал түймэр унтраах, аврах 63 дугаар ангийн байрлалд “Цэргийн дүйцүүлэх албаны тусгай үүргийн бэлтгэл шатны сургалт”-ыг бүсчилсэн хэлбэрээр цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчидтай 2023 оны 09 дүгээр сард зохион байгуулсан.

Дүүргийн Засаг даргын 2023 оны А/294 дүгээр захирамжаар цэргийн дүйцүүлэх албыг 2021-2023 онд биеэр хааж, хугацаа дууссан алба хаагчдыг халж, цэргийн үүрэгтний үнэмлэхэд тэмдэглэл хийж, хүлээлгэн өгсөн.

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/142 дугаар захирамжаар “Иргэн-цэргийн харилцааны өдөрлөг зохион байгуулах тухай” захирамжийг баталгаажуулж, шаардагдах зардлыг шийдвэрлүүлсэн.

Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Зэвсэгт хүчний анги байгууллага, дүүргийн Боловсролын хэлтэс, Монгол цэргийн музей, зэрэг байгууллагуудтай хамтран ойг тохиолдуулан зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулан Цэргийн штабын даргаар хянуулж, Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан бэлтгэл ажлыг хангасан.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын ахлах болон дунд ангийн сурагчдын дунд “Монгол цэрэг” сэдэвт зохион бичлэг, гар зургийн уралдааныг 2023 оны 3 дугаар сарын 01-13-ны өдрүүдэд зохион байгуулж, төрийн өмчтэй болон хувийн хэвшилийн 21 сургуулиас нийт 164 бүтээлийг ирүүлсэн.

Зохион бичлэгийн уралдааны тэргүүн байрт 163 дугаар сургуулийн 11А ангийн сургач Э.Амин-Эрдэнэ, дэд байрт 115 дугаар сургуулийн 126 ангийн сургач Э.Хүслэн, гутгаар байрт 18 дугаар сургуулийн 10а ангийн сургач Д.Яруу-алдар, Гар зургийн уралдаанд тэргүүн байрт 18 дугаар сургуулийн 7А ангийн сургач Д.Азжаргал, дэд байрт “Оном” сургуулийн 9б ангийн сургач Э.Эрмүүн гутгаар байрт 18 дугаар сургуулийн 10а ангийн сургач Э.Баяржавхлан нар тус тус шалгарсан.



Монгол цэргийн өдөр, Орчин цагийн Зэвсэгт хүчний 102 жилийн ойг тохиолдуулан хүүхэд залуучуудад Цэрэг-Эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгын хүрээнд “Монгол цэрэг-Дэлхийн цэрэг” нээлттэй хаалганы өдөрлөгийг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, Боловсролын хэлтэс, Зэвсэгт хүчний 011 дүгээр ангитай хамтран 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр ангийн байрлалд зохион байгуулсан. Тус өдөрлөгийн арга хэмжээнд Нийслэлийн Ерөнхий боловсролын 15, 18, 75 дугаар сургуулиудын ахлах ангийн 100 гаруй сургач, багш нар оролцож хөтөлбөрийн дагуу ангийн байрлалтай танилцуулж, зэвсэглэл, цэргийн техникийг үзэж сонирхуулсан.

Хүүхэд залуучуудад Цэрэг-Эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгын хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын 10, 118 дугаар сургуулийн ахлах ангийн 70 гаруй сургачдыг Монгол цэргийн музейг танилцуулах, үзмэр үзүүлэх ажлыг 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан.

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийн ой, Монгол Улс Энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны 21 жилийн ойг тохиолдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын дунд Дартс, Скат гар бууны буудлаын тэмцээнийг 2023 оны 3 дугаар сарын 12-ны өдөр дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “147 клуб”-т зохион байгуулсан.

Дартсын төрөлд тэргүүн байрт Л.Огтонбаяр ахлагчтай Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс, дэд байрт З.Баасандорж ахлагчтай Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, гутгаар байрт Б.Ариунаа Төрийн захиргааны удирдлагын хэлтэс 9мм-ийн ПМ гар бууны төрөлд тэргүүн байрт З.Баасандорж ахлагчтай Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс, дэд байрт Б.Очир ахлагчтай Хууль, эрх зүйн хэлтэс, гутгаар байрт Э.Баярбат ахлагчтай Нийгмийн хөгжлийн хэлтэс шалгарч шагналыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга С.Энхбаяр гардуулсан.



Дайнд оролцсон 3 ахмад дайчин болон Цэргийн штабаас чөлөөнд гарсан 5 ахмадад дүүргийн Засаг даргын мэндчилгээ, ахмад дайчдад 300 000 (гурван зуун мянга) төгрөг, чөлөөнд гарсан ахмадад 200 000 (хоёр зуун мянга) төгрөг нийт 1 900 000 (нэг сая есөн зуун мянга) төгрөгийг дансанд нь шилжүүлж, хүндэтгэл үзүүлсэн.

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийн ойн төлөвлөгөөт ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын нэрэмжит Цэрэг-спортын цогцолбор “Дөл” тэмцээнийг 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Зэвсэгт хүчний 013 дугаар материаллаг баазыг түшиглэн зохион байгуулсан. Тус тэмцээнийг “SBN”, “Mass” телевиз, Дуулга студи болон дүүргийн цахим хуудсуудаар

Нийслэлийн Засаг даргын тодотгол явуулах тухай 2023 оны н/04 дүгээр захирамжийг үндэслэн дүүргийн Засаг даргын тодотгол явуулах тухай захирамжийн төслийг боловсруулан батлуулж, н/02 дугаар захирамжаар цэргийн дайчилгааны тодотголыг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 04 дүгээр сарын 27, 11 дүгээр сарын 06-ны өдрөөс 11 дүгээр сарын 21-ний өдрүүдэд зохион байгуулсан.



Тус дүүрэгт 2023 оны цэргийн бүртгэлээр бүртгэгдсэн бэлтгэл офицер, ахлагч, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн болон 2023 оны тээврийн хэрэгслийн бүртгэлийн судалгааг үндэслэн бэлтгэл үүрэгтнийг 99,7 хувь, авто техникийг 97,6 хувьтай шинээр оногдуулан бүртгэж, батлагдсан хуваарийн дагуу 05 дугаар сард анги, байгууллага дээр очиж, 11 дүгээр сард анги, байгууллагууд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын байранд ирж тодотгосон.

Бэлтгэл үүрэгтнийг 99,7 хувь оногдуулан бүртгэснээс 2,8 хувийг хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнээр, авто техникийг 97,6 хувьтай оногдуулан бүртгэж, цэргийн дайчилгааны тодотголыг 100 хувь зохион байгуулж, акт үйлдэн Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабт хүргүүлсэн.

Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/376 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2023 оны А/145 дугаар захирамжийн дагуу “Оюутан-Цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутны бүртгэлийг 2023 оны 03 дугаар сарын 01-11-ний өдрийг үндэсний портал сайт E-Mongolia бүртгэлийг хүлээн авсан. 2023 онд дүүргийн хэмжээнд 9 их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 122 оюутан, суралцагчид бүртгэлд хамрагдсан. Бүртгэлд хамрагдсан оюутан, суралцагчаас 122 иргэнийг эрүүл мэндийн үзлэг болон бие бялдаржилтын шалгалтад оруулсан.

УБХИС дээр, 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр эрүүл мэндийн үзлэгт, 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр биеийн тамирын шалгалтад оюутнуудыг хамруулсан. Эрүүл мэндийн үзлэг, бие бялдаржилтын шалгалтад тэнцсэн 112 оюутныг Үндэсний батлан хамгаалах сургуульд хүлээлгэн өгч 2023 оны 08 дугаар сарын 19-ний өдөр 110 оюутныг хүлээж авч мэдээллийн санд оруулсан.

Цэргийн бүртгэлийг дүүргийн хүн амын тоо бүртгэлтэй нягт уялдуулан зохион байгуулж, байнгын оршин суугч, оюутнуудыг оршин суугаа хаягаар нь, дүүргийн цэргийн бүртгэлийн дүнг 2022 оны жилийн эцсийн хүн амын статистик суурин мэдээтэй харьцуулсан судалгаагаар гаргаж, Е-Монголия портал веб сайттай хамтран зохион байгуулж, 7379 иргэний хүсэлтийг баталгаажуулсан.

2023 оны цэргийн бүртгэлийг Засаг, захирагааны анхан шатны нэгж хороо болон үндэсний цахим портал сайт “E-Mongolia”-тай хамтран дүүргийн хэмжээнд 2022 оны жилийн эцсийн статистик суурин хүн амын тоотой харьцуулахад 95,3 хувийн хамралттай зохион байгуулсан нь өмнөх оноос 1.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2.2 Төсвийн орлогын төлөвлөгөө болон нийслэлийн төсөөт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, нийслэлийн төсвөөс дүүргийн төсөөт олгож буй санхүүгийн дэмжлэгийн зарцуулалт;

Дүүргийн төсвийн орлогын талаар:

“Улс, нийслэл, орон нутгийн төсвийн орлогыг жилийн эхнээс жигд ханган биелүүлэн ажиллах тухай” дүүргийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/21 дүгээр захирамжийн төслийг бэлтгэн батлуулж, холбогдох хэлтсүүдэд хүргүүлэн, төлөвлөгөөний дагуу хамтран ажиллаж байна. Үүнд 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Гадаадын Иргэн харъяатын газар, Татварын хэлтэстэй хамтран дүүргийн төсөвт төвлөрүүлж буй улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг хэрхэн нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар уулзалт зохион байгуулсан.

АТӨЯХАТ болон агаар бохирдуулсаны төлбөр, автозам ашигласны төлбөр хураах тухай захирамж гарган улс, нийслэлийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, биелүүлэх ажлуудыг хороодтой хамтран хэрэгжүүлсэн. Мөн “Татвар төлөгч Танд зөвлөө” өдөрлөгийг 05 дугаар сарын 16-ны өдөр Татварын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс болон Газар зохион байгуулалтын алба, Монгол улсын Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгтэй хамтран амжилттай зохион байгууллаа.

Орон нутгийн төсвийн орлого 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 266,207.2 сая төгрөгийн төлөвлөгөөтэй бөгөөд гүйцэтгэл 284,533.6 сая төгрөг орж, төлөвлөгөөний биелэлт 106.9 хувь биелсэн.

**Нийслэлд төвлөрүүлэх орлогын талаар:**

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Хан-Уул дүүргийн Засаг даргатай байгуулсан 2023 оны хариуцлагын гэрээний 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт дүүргийн төсвөөс 222,789.1 сая төгрөгийн орлогыг нийслэлийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан бөгөөд 11 дүгээр сарын байдлаар 183,035.6 сая төгрөгийг төвлөрүүлэн 82.2% биелсэн.

Улсын Тэмдэгтийн хураамж буцаан олгох талаар:

Орон нутгийн төсвийн орлогын биелэлтийг сар бүр Татварын хэлтсийн орлогын эдийн засагчтай замд яваа татварын орлого болон татварын нэр төрлийн буцаасан гүйлгээг тулган баталгаажуулж, тооцоо нийлэн сарын биелэлтийг дүгнэн ажилласан.

Улсын тэмдэгтийн хураамжийн буцаалтаар нийт 791.6 сая төгрөгийг 1,543 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад олгосон. Татварын хэлтсээс ирүүлсэн албан бичиг, жагсаалтыг тэмдэгтийн хураамжийн дансны хуулга, Шүүхийн захирамж, иргэн аж ахуйн нэгжийн өргөдөл, иргэний үнэмлэх, гэрчилгээний хуулбар, мөнгө тушаасан баримт, татварын тодорхойлолт зэрэг холбогдох баримтыг үндэслэн тулгаж, төлбөрийн хүсэлт бичиж хэлтсийн даргаар батлуулан орлого бууруулах гүйлгээ хийсэн.

Нэр данс зэрүү болон данс андуурсан, илүү төлсөн зэрэг залруулгын гүйлгээг татварын хэлтсээс ирүүлсэн албан бичиг, жагсаалт, дансны хуулга, татварын тодорхойлолт, аж ахуйн нэгж, иргэний хүсэлт, иргэний үнэмлэх, гэрчилгээний хуулбар зэрэг үндсэн баримтыг үндэслэн 88 иргэн, аж ахуйн нэгжид 435.1 сая төгрөг буцаан олгов.

2.3 Хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн санал, зөвлөмж, түүнийг хэрэгжүүлсэн байдал;

Төсвийн тухай хуулийн 54.2-т “ТӨЗ өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, төсөл, сан, төрийн болон орон нутгийн өмчт аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэсэн тайланд хамруулна” гэж заасны дагуу Засгийн Газрын санхүүгийн нэгтгэлийн Э-ТАЙЛАН системд Дүүргийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамрагддаг төсөвт 87 байгууллагын 2022 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилт, касс харилцахын нэгтгэл, нэмэлт санхүүжилтийн тооцоог тулган Сангийн Яамны нэгтгэлийн Э-тайландаа байгууллага бүрээр тулган шалгаж хүлээн авч дүүргийн нэгдсэн тайланд Нийслэл дэх төрийн Аудитын газраар шалгуулж стандарт дүгнэгдэв.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны үйл ажиллагааны үр дүнг үндэслэн нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгээс ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх 3 бүлэг 41 арга хэмжээний төлөвлөгөөг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргаар 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлуулан хагас жилийн байдлаар 60 хувь, жилийн эцэст 93%-тай хэрэгжсэн бөгөөд тайланд Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 03/1076, жилийн эцсийн тайланг 12 дугаар сарын 15-ны өдрийн 03/2097 дугаар албан бичгээр тус тус нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлж, тайлагнасан.

2.4 Төрийн захиргааны албан хаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэсэн байдал;

Засгийн газрын 2020 оны 217, 2023 оны 301 дүгээр тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах хүрээнд албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлж дүгнэх “Үнэлгээний баг”-ийн бүрэлдэхүүнийг ЗДТГ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/94 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан. Үнэлгээний баг нь Засаг даргын Тамгын газрын 10 хэлтэс, албадын Т3-44, TY-22, хороодын Зохион байгуулагч-28, нийгмийн ажилтан-12, нийт 106 албан хаагчийн 2023 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлсэн нэгжийн даргын үнэлгээг, тайлангийн хамт хүлээн авч баталгаажуулан, Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн Б/285 дугаар тушаалаар холбогдох урамшууллыг олгосон.

2.5 Үндсэн чиг үүргийн биелэлт, үрд дунд дотоод аудит, хяналт эсвэл шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэх, уг ажлын дүгнэлтийг үйл ажиллагаандaa авч хэрэгжүүлсэн байдал;

Дүүргийн төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, хэрэгжиж буй бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж 6 зөвлөмж гарган Засаг даргын Тамгын газрын 2023 оны 06/82, 06/382-388, 06/571, 03/1135 тоот албан бичгүүдээр давхардсан тоогоор 8 байгууллагад хүргүүлж, биелэлтийг тооцон ажиллаж байна. Тухайлбал; Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасны дагуу 2023 оны 1 дүгээр улиралд дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй нийт 18 тогтоол, шийдвэрийн 30 заалтын хэрэгжилтэд, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд 56 хувь, “Хэрэгжих шатанд” гэж үнэлэгдсэн. Хяналт шинжилгээ үнэлгээний ажлын 2023/04 дүгээр зөвлөмжийг Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 03/1135 дугаар албан бичгээр дэргэдэх 28 байгууллагад хүргүүлсэн.

Мөн дүүргийн Засаг даргын 2023 оны хариуцлагын гэрээний 2 бүлэг 43 зорилт, 73 арга хэмжээний 1 улирлын хэрэгжилт 36 хувь, хагас жилд 55,5 хувь, гуравдугаар улиралд 78 хувьтай хэрэгжсэн. Засаг даргын Тамгын газрын 2023 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлийн тайлангийн 5 бүлэг, 68 зорилт, 180 арга хэмжээний хэрэгжилтийг Засаг даргын Тамгын газрын хэлтэс тус бүрээр нэгтгэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 47.8 хувь, хагас жилд 56,2 хувь “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн. Хяналт шинжилгээ үнэлгээний ажлын 2023/06 дугаар зөвлөмжийг холбогдох хэлтсүүдэд хүргүүлсэн.

Хан-Уул дүүргийн 25 хороодод 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 30-ны өдөр хүртэл хяналт шалгалт хийж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэсэн.

Хотын хөгжлийн индексийн тухайн үеийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гаргасан бөгөөд дүгнэлтээр ХХИ тооцох арга зүй, мэдээллийн бодит байдал зөрүүтэй гарсан тул ногоон байгууламж, авто зам, явган замын хэмжээг онлайнаар google earth ашиглан хэмжих талаар сургалтыг хороодын индекс хариуцсан албан хаагчдад хийх шаардлагатай.

Мөн гадаад, дотоод орчны хяналтын камерын судалгаанд, сургууль цэцэрлэгийн камерын тоог орхигдуулах, ногоон байгууламж, авто зам, явган замын маягтын мэдээллийг бөглөхөд оронгийн алдаа, хэмжих нэгжийн алдаа гаргасан, статистикийн тоон мэдээлэл хүн ам, өрхийн тоо, худалдааны цэгийн судалгаатай уялддаг үзүүлэлтийг анхаарч ажиллах, сайжруулах зэрэг шаардлага гарсан тул зөвлөн туслах ажлын хүрээнд алдааг засуулж, индексийн маягтуудыг шинэчлэн программд оруулсан. Мэдээллийн анхан шатны бүртгэлийг зөв бүртгэж, хөтөлснөөр хороо, дүүрэг, нийслэлийн хөгжлийн индексийн мэдээлэл үнэн бодитой гарах чухал ач холбогдолтой. Жилийн эцсийн байдлаар Хан-Уул дүүргийн хотын хөгжлийн индекс 0,646 болж өссөн үзүүлэлттэй байна.


2.6 Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал

Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам” 2020 оны 246 дугаар тогтоолоор өөрчилсөн “Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, -ыг үндэслэн Засаг даргын Тамгын газрын албан бичиг боловсруулалтын үйл ажиллагаанд Стандартчилал Хэмжилзүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан MNS 5140-2021 стандартыг мөрдөн ажиллаж байна.

Хан-Уул дүүргийн хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар 20612 бичиг ирж шийдвэрлэлтийн хувь 98,26%, шийдвэрлэлтийн дундаж хоног 6.61 байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 35003 бичиг ирж шийдвэрлэлтийн хувь 98,91% хувь шийдвэрлэлтийн дундаж хоног 6,02 байна. Мөн 1874 албан бичгийг төлөвлөн явуулсан.


Тайлант хугацаанд Засаг даргын Тамгын газар нь нийт 5017 албан бичгийг цахим болон цаасан хэлбэрээр хүлээж авсан бол 2022 оны жилийн эцсийн байдлаар 4852 бичиг хүлээн авч энэ хугацаанд ирсэн бичгийн тоо 165-аар өссөн байна.

Нийт албан бичгийн шийдвэрлэлтийн хувь 2022 оны жилийн эцсийн байдлаар 95,56%, шийдвэрлэлтийн дундаж хоног 6.43 байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 96,13% шийдвэрлэлтийн дундаж хоног 6.61 байна.



Хан-Уул дүүргийн хэмжээнд ирсэн бичгийн мэдээ:

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дүүргийн хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем ашиглагч нийт 107 байгууллагын албан бичгийн шийдвэрлэлтийн мэдээг 14 хоног тутамд гаргаж Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулж ажилладаг бөгөөд тайлант хугацаанд нийт 8 мэдээг бэлтгэн танилцуулсан. Мөн дүүргийн хэмжээнд ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээг сар, улирал, хагас, бүтэн жилээр гаргаж дээд шатны байгууллагад танилцуулан ажилладаг. Энэ ажлын хүрээнд сар тутмын 6, улирал тутмын 2 мэдээг тус тус гаргаж Нийслэлийн Архивын газарт хүргүүлээд байна.



Хүснэгтээс харахад тус дүүргийн хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар 33482 албан бичгийг хүлээн авч шийдвэрлэсэн бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 35003 буюу 1521-ээр өсч, шийдвэрлэлт 2022 оны жилийн эцсийн байдлаар 98,47% байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 97,66% байна.

Зөрчлийн тоо 2022 оны жилийн эцсийн байдлаар 390 байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 164 буюу 226-аар буурсан үзүүлэлттэй байна.

Засаг даргын Тамгын газар болон дүүргийн хэмжээнд явуулсан бичгийн мэдээ:

Засаг даргын Тамгын газраас төлөвлөн явуулсан албан бичгийн тоо 2022 оны жилийн эцсийн байдлаар 1784 байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 1874 буюу явуулсан албан бичгийн тоо 90-ээр өссөн байна.

Дүүргийн хэмжээнд явуулсан албан бичгийн тоо 2022 оны жилийн эцсийн байдлаар 19630 байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 19607 буюу явуулсан албан бичгийн тоо 23-аар буурсан. Тус ажлын хүрээнд тайлант хугацаанд дүүргийн хэмжээнд нийт өссөн дүнгээр 9563 албан бичгийн шийдвэрлэлтийг хянаж үүнээс 9370 албан бичгийн шийдвэрлэлтийг хангалттай гэж үзэн баталгаажуулж, 193 албан бичгийн шийдвэрлэлтийг хангалтгүй гэж үзэн цуцалсан байна. Байгууллагын нууц баримт бичиг, мэдээлэлтэй ажиллахаа “Байгууллагын нууц”-ын журмыг мөрдлөг болгосон.

Архивын үйл ажиллагааны чиглэлээр:

Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/172 дугаар захирамж “Байгууллагын архивын үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага, хадгалалтын горимыг тогтоож мөрдүүлэх журам”, Нийслэлийн Засаг даргын А/177 дугаар захирамжаар батлагдсан “Архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийх журам”, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Төрийн архивын үйл ажиллагааны нийтлэг журам, Салбар архивын үйл ажиллагааны нийтлэг журам, Нийслэлийн 2023 оны жилийн эцсийн тайлан

Засаг даргын 2013 оны A/452 дугаар захирамжийг үйл ажиллагаанд даа мөрдлөг болгон хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Архивын үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан 6 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн биелэлт 94,1 хувьтай хэрэгжсэн.

Дүүргийн салбар архив байгуулах ажлын хүрээнд 2023 онд төрийн архивын хадгаламжийн санд 32,166,000 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг худалдан авч архивын байрны стандарт нөхцөлийг хангасан.

Худалдан авсан тоног төхөөрөмжүүд:



Дүүргийн салбар архив байгуулах ажлын хүрээнд 2023 онд төрийн архивын хадгаламжийн санд 32,166,000 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг худалдан авч архивын байрны стандарт нөхцөлийг ханган ажиллаж байна.

Дүүргийн Засаг даргын 2023 оны A/104 дүгээр Захирамжаар Архивын хэлтсийн бүтэц батлагдан Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах "Био-Асралт" өрхийн эмнэлгийн байрны 1 давхрын баруун жигүүрт салбар архивын байрыг тохижуулан 72 байгууллагын 8151 баримтыг нүүлгэн шилжүүлсэн.



Архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилтын хүрээнд байгууллагын архив болон төрийн архивын хадгаламжийн сангуудад ариутгал халдвартгүйтгэлийн ажлыг хийж баримтын хадгалах горимыг сайжруулсан.

Архивын Ерөнхий газрын даргын 2018 оны A/97 дугаар тушаалаар батлагдсан "Архивын баримтын улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журам"-ын дагуу дүүргийн архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх эх үүсвэрийн жагсаалтад орсон дүүргийн харьяа 98 байгууллагын архивын тоон тайланг <http://burtgel.archives.gov.mn/> системд цахим хэлбэрээр шивэх ажлыг хугацаанд нь хийж дүн мэдээг нийслэлийн Архивын газарт 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 11/68 дугаар албан бичгээр биелэлтийг хүргүүлсэн.



Нөхөн бүрдүүлэлт: /Төрийн архив/

Нөхөн бүрдүүлэлтийн 2023 оны төлөвлөгөө, хуваарийн дагуу 30 байгууллагын данс бүртгэлийг БНШАЗК -ын 6 удаагийн хурлаар хэлэлцэн баталж, данс бүртгэлийн дагуу 3405 баримтыг төрийн архивд хүлээн аваад байна. Хөмрөг үүсгэгч байгууллагын захирамжлалын баримт бичгийн цахим нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдан зохион байгуулах ажлын хүрээнд дүүргийн харьяа байгууллагуудын цахим нөхөн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан.



Төлөвлөгөөний дагуу харьяа 104 байгууллагын 2022 онд үүссэн захирамжлалын баримтыг төрийн архивын нэгдсэн системд 196 хадгаламжийн нэгжийн 12857 баримтын 18948 хуудсыг цахимжуулсаныг батлан шалгасан. Захирамжлалын баримтын цахим нөхөн бүрдүүлэлтийн биелэлтийг, батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж Нийслэлийн Архивын газарт тайлагнасан.

Байгууллагын архив: Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албадад 2022 оны үйл ажиллагааны явцад үүссэн цаасан суурьт баримтаар байгууллагын архивд нөхөн бүрдүүлэлт хийх хуваарийн дагуу хэлтэс, албадаас 717 баримтыг архивд хүлээн авч бүртгэлжүүлсэн.

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны явцад үүссэн 2022 оны 11 хадгаламжийн нэгжийн 1022 баримт бүхий 1977 хуудастай захирамжлалын баримтыг сканердаж www.Arch.ulaanbaatar.mn системд шивж цахим хэлбэрт шилжүүлсэн үүнд:

- Засаг даргын "А" захирамж нийт 648 баримт бүхий 1394 хуудастай /7 боть/
- Засаг даргын "Б" захирамж нийт 78 баримт бүхий 86 хуудастай /1 боть/
- Засаг дарын Тамгын газрын даргын "А" тушаал нийт 103 баримт бүхий 210 хуудастай /1 боть/
- Засаг дарын Тамгын газрын даргын "А" тушаал нийт 193 баримт бүхий 287 хуудастай /1 боть/
-

Нийт 11 хадгаламжийн нэгжийн 1022 захирамжлалын баримтын нягтлан шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Байгууллагын архивын 2022 оны үйл ажиллагааны явцад үүссэн 11 хадгаламжийн нэгжийн 1022 баримтын 1977 хуудас Захирамжлалын баримтыг цахимжуулж, Нийслэлийн Архивын газарт актаар хүлээлгэн өгсөн.

Сургалт, мэргэжил арга зүй:

Төрийн архивт хөмрөг үүсгэгч байгууллагууд болон Тамгын газрын албан хаагчдыг мэргэжил арга зүйгээр хангах ажлын хүрээнд архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр 6 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 283 албан хаагч хамрагдсан.

Төрийн архив:

Төрийн архивын 15 хөмрөгийн баримтаас 35 иргэнд 1994-2014 оны 27 хадгаламжийн нэгжийн 109 хуудас,

Малын "А" дансны 10 хөмрөгийн баримтаас 31 иргэнд 1995-2018 оны 173 хадгаламжийн нэгжийн 1203 хуудас архивын баримтаас лавлагаа, хуулбарыг олгосон.

Байгууллагын архивын 10 данс бүртгэлийн 1994-2023 оны 256 хадгаламжийн нэгжээс 1130 хуудас, Байгууллагын архиваас дотооддоо 1110 баримтыг түр ашиглуулсан ба 452 баримтаас лавлагаа хуулбарыг олгосон байна.

2.7 Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал;

Иргээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захирагааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтод түвшинд хүргэхээр зорин ажилласан.

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, албадад 2023 оны жилийн эцсийн байдлаар 5696 өргөдөл, гомдол ирснээс хугацаандаа шийдвэрлэсэн-5574, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн-38, судлагдаж байгаа-84 өргөдөл байна. Үүнээс:

- Бичгээр – 2074
- 1800-1200 – 414
- 11-11 – 2878
- Хороо бүртгэсэн – 180
- Цахимаар – 36
- Дижитал сити – 113
- Тусгай дугаар – 1

Засаг даргын Тамгын газарт 2023 оны 12 дугаар сарын байдлаар 910 өргөдөл, гомдол ирснээс хугацаандаа шийдвэрлэсэн-902, судлагдаж байгаа-6, Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн-2 өргөдөл байна. Үүнээс:

- Цаасаар - 221
- 1800-1200 - 152
- 11-11- 477
- Дижитал сити - 41
- Цахимаар – 19

Иргэдийн гаргасан өргөдөл, гомдлыг төрлөөр ангилж үзвэл:



Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдлаар авч үзвэл:

Дүүргийн хэмжээнд

- Иргэний талд шийдвэрлэж хариу өгсөн - 4632
- Боломжгүй тухай хариу өгч шийдвэрлэсэн - 944
- Бүрэн барагдуулж шийдвэрлээгүй- 36

Засаг даргын Тамгын газарт

- Иргэний талд шийдвэрлэж хариу өгсөн - 745
- Боломжгүй тухай хариу өгч шийдвэрлэсэн - 152
- бүрэн барагдуулж шийдвэрлээгүй – 7

Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хариу өгсөн хэлбэрийг авч үзвэл:




Утсаар	Мессежээр	Албан бичгээр	Иргэнтэй уулзсан
ДҮҮРЭГ 2846 буюу 50,7%	1017 буюу 18,1%	1073 буюу 19,1%	676 буюу 12%
ЗДТГ 563 буюу 62,2%	110 буюу 12,1%	116 буюу 12,8%	115 буюу 12,7%

Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Хан-Уул дүүрэг	Нийт өргөдөл		Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн		Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн		Шийдвэрлэлтийн дундаж хоног		Зөрчлийн тоон үзүүлэлт	
	2022 XI/24	2023 XI/24	2022 XI/24	2023 XI/24	2022 XI/24	2023 XI/24	2022 XI/24	2023 XI/24	2022 XI/24	2023 XI/24
ИТХ	9	3	6	1	1	2	18x 19ц 35м	32x 23ц 16м	62	68
ЗДТГ	856	910	853	902	2	2	06x 09ц 16м	08x 12ц 23м	63	67
Харьяа хэлтэс, алба, тасаг	3762	3497	3653	3413	42	22	08x 04ц 41м	08x 07ц 08м	1174	567
Дүүргийн өмчит үйлдвэрийн газрууд	50	70	47	68	2	1	06x 19ц 24м	08x 19ц 50м	158	49
Хороод	338	526	316	504	19	11	06x 09ц 20м	06x 16ц 20м	572	651
Эмнэлэг	523	659	514	655	7		05x 10ц 09м	02x 11ц 39м	265	125
Сургууль, цэцэрлэг	16	31	16	31			02x 10ц 09м	02x 05ц 57м	2	15
Дүүргийн хэмжээнд /нийт/	5554	5696	5405	5574	73	38	51x 62ц 11м	66x 99ц 42м	2296	1542

Хугацаа хэтэрсэн шийдвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:



Шийдвэрлэх явцад гаргасан зөрчлийн төрөл /байгууллагаар/

Зөрчлийн төрөл	Зөрчлийн тоо	Байгууллагаар	Зөрчлийн тоо
Бусад зөрчил	0	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	68
Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил	218	Засаг даргын Тамгын газар	67
Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил	213	Харьяа хэлтэс, алба, тасаг	567
Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил	1082	Дүүргийн өмчит үйлдвэрийн газрууд	49
Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй зөрчил	29	Хороод	651
Холбогдох файл хавсаргаагүй	0	Эмнэлэг	125
НИЙТ	1542	Сургууль, цэцэрлэг	15
		Дүүргийн хэмжээнд/нийт/	1542

Зөрчлийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулбал:



ХАМГИЙН ИХ ГОМДОЛ ИРСЭН ХЭЛТЭС

1. Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс -405 буюу 44,5 %
2. Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс – 185 буюу 20,3%
3. Төрийн захирагааны удирдлагын хэлтэс – 148 буюу 16,2 %
4. Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс - 53 буюу 5,8%

ГОМДЛЫН ТЭРГҮҮЛЭХ АГУУЛГА

1. Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааны тухай – 62 буюу 12,23%
2. Орон сууцны 1-р давхарт байрлах үйлчилгээний газруудын тухай – 46 буюу 9,07 %
3. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн болон ТҮЦ, павильон, ил задгай худалдаа, үйлчилгээний тухай – 39 буюу 7.69 %

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Иргэдээс дүүргийн Засаг даргын харьяа, дэргэдэх хэлтэс, албан хаагчдад гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг бэлтгэн Засаг даргын болон Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай хороодын шуурхай зөвлөгөөнд тус тус танилцуулан ажиллаж байна.

Өргөдөл, гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн болон шийдвэрлэх явцад зөрчил их гаргасан Засаг даргын харьяа, дэргэдэх 6 хэлтэс албад, 11 хороод руу хариуцлага тооцох болон мэдэгдэл хүргүүлэх албан бичгийг хүргүүлэн, зөрчлийг арилгаагүй 3 хорооны Засаг дарга, 4 хорооны зохион байгуулагчид “Нийслэлийн нутгийн захирагааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ын 13.4-т заасны дагуу арга хэмжээ авах саналыг хүргүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн үйлчилгээний шийдвэрлэлтийн хяналт хариуцсан ажилтанд дэргэдэх хэлтсүүдийн үйлчилгээний тоон мэдээг 7 хоног бүр, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтсүүдийн иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэн сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон Статистикийн хэлтсээс эрхлэн гаргадаг “Статистикийн мэдээлэл” гарын авлагад нийтлүүлсэн.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх чиглэлээр:

Иргэдээс дүүргийн Засаг даргын харьяа, дэргэдэх хэлтэс, албан хаагчдад гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг бэлтгэн Засаг даргын болон Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай хороодын шуурхай зөвлөгөөнд тус тус танилцуулан ажилласан.

Өргөдөл, гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн болон шийдвэрлэх явцад зөрчил их гаргасан Засаг даргын харьяа, дэргэдэх 6 хэлтэс албад, 11 хороод руу хариуцлага тооцох болон мэдэгдэл хүргүүлэх албан бичгийг хүргүүлэн, зөрчлийг арилгаагүй 3 хорооны Засаг дарга, 4 хорооны зохион байгуулагчид “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ын 13.4-т заасны дагуу арга хэмжээ авах саналыг хүргүүлсэн.

Засаг дарга иргэдэд мөнгөн тусlamж үзүүлсэн талаар:

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан “Хан-Уул дүүргийн иргэдэд нэг удаагийн буцалтгүй тусlamж үзүүлэх тухай журам”-ыг хангуулан ажилласан.

Мөнгөн тусlamж хүссэн иргэдийн гэрээр хөгжлийн нийгмийн ажилтан очиж, нөхцөл байдлын үнэлгээ хийн баталгаажиж ирсэн нийт 55 иргэнд 23,150,000 (хорин турван сая нэг зуун тавин мянга) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусlamж олгох захирамжийн төслийг боловсруулан ажилласан. Нийт 179 иргэнд 68,100,000 төгрөгийн буцалтгүй тусlamж олгосон.

Засаг даргын иргэдтэй хийсэн уулзалт:

Хан-Уул дүүргийн Засаг даргын иргэдтэй хийх уулзалтыг Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1212 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтуудын иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулах журам”-ын хүрээнд иргэдтэй хийх хуваарьт уулзалтыг 7 хоног тутам зохион байгуулсан. Дээрх уулзалтад Засаг дарга болон хэлтэс албадын дарга нарын хамт 128 иргэнтэй биечлэн уулзаж, тэдний санал, хүсэлтийг хүлээн авч шууд шийдвэрлэх боломжтой асуудлуудыг газар дээр нь шийдвэрлэн, эргэн хариу өгөх асуудлуудыг холбогдох хэлтэс албадын дарга нарт үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Уулзсан иргэд:



Уулзалтад оролцсон иргэдийн санал, хүсэлтийг агуулгаар нь авч үзвэл:



Иргэдтэй хийх хуваарьт уулзалтын хүрээнд хүсэлт гаргасан 2 иргэнд 2023 оны A/652 дугаар захирамжаар 2 сая төгрөгийн буцалтгүй мөнгөн тусlamжийн дэмжлэг үзүүлсэн.

Мөн “Иргэдээ сонсъё” дэд хөтөлбөрийг хүрээнд 25 хороодын дунд “Иргэдээ сонсъё” аяныг зохион байгуулж тус аянаас гарсан иргэдийн санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. Дээрх аяны хүрээнд буцалтгүй мөнгөн тусlamж хүссэн иргэдийн холбогдох материалыг хүлээн авч 9 иргэнд 3,6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Иргэдэд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхийн зэрэгцээ тэднээс гаргасан шинэ санал, санаачилгыг хүлээн авч дараах ажлуудыг хийсэн.

➤ Тус дүүргийн 16-р хорооны иргэн Ц.Уранчимэг, 1-р хорооны иргэн Б.Ганчимэг нарын хүсэлтийн дагуу гэр олгосон. 10-р хорооны иргэн М.Улаанд дүүргийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн A/426 дугаар захирамжаар, 13-р хорооны иргэн Э.Ганзоригт дүүргийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн A/368 дугаар захирамжаар тус тус газар олгосон.

➤ 10-р хорооны иргэн Д.Чулуун болон 4-р хорооны иргэн Б.Алтанзагас Д.Энхтуяа, 25-р хорооны иргэн Д.Цэдэв нарын хүсэлтийг дүүргийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 01/350, 01/308 дугаартай албан бичгээр тус тус Нийслэлийн орон сууц санхүүжилт ХК-д хүргүүлсэн.

➤ Хан-Уул дүүргийн 5 дугаар хороонд байрлалтай дахин төлөвлөлтөөр 2019 онд ашиглалтад орсон 40 айлын 937-р байрны хана, тааз нь цуурч борооны ус нэвчин мөөгөнцөртсөн тухай асуудлаар хандсан иргэний байранд очиж, нөхцөл байдалтай танилцан холбогдох дээд шатны байгууллагуудад албан бичгээр саналыг хүргүүлсэн.

➤ Олон Улсын тэмцээнд оролцох эрх авсан зорилтод бүлгийн хүүхдүүдэд санхүүгийн дэмжлэг олгохоор шийдвэрлэсэн.

➤ Хорт хавдартай 4,16-р хорооны 2 иргэнд Засаг даргын 2023 оны A/652 дугаар захирамжаар 2 сая төгрөгийн буцалтгүй мөнгөн тусlamж олгосон.

➤ Төрийн дээд одон медалиар шагнуулахаар хүсэлт гаргасан иргэдийн материалыг хүлээн авч Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 20 дугаар тогтоолоор дэмжин уламжилсан.

Уулзалтын зураг:



Нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагааны талаар:

“Нэг цэгийн үйлчилгээ”-ний өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж ажилласан. Тус төвөөр өдөрт 350-550 иргэн тогтмол үйлчилгээ авдаг бөгөөд өргөдөл гомдол хүлээн авах, эд хөрөнгийн бүртгэл, гэрчилгээ олгох, гадаад паспорт хүлээн авах, олгох, хуулийн этгээдийн бүртгэл, гэрчилгээ олгох, иргэний бүртгэл, олголт, нотариат, кадастр, канон(зурагчин) зэрэг 13 цонхоор 69 төрлийн үйлчилгээг хүргэдэг бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор 44320 иргэн үйлчлүүлсэн.

Төрийн үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор ТҮЦ машин, улсын бүртгэлийн хураамж, газар зохион байгуулалтын албаны хураамж, татвар, торгууль, шүүхийн тэмдэгтийн хураамж, вакцины бичиг, шинжилгээний хариу гэх мэт үйлчилгээг хялбар, шуурхай шийдэх боломжтой ГЭРЭГЭ киоск автомашин ажиллаж нийт 47300 иргэн үйлчлүүлсэн.

2.8 Байгууллагын үйл ажиллагааны зардал хямдруулах, төсөв хэмнэх чиглэлээр зохион байгуулж, үр дүнд хүрсэн бодитой ажил;

2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардлаас бусад зардлыг батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хэмнэлт гаргах гэсний төсвийн байгууллагудын батлагдсан төсөв түүний зарцуулалт, цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг сар бүрийн төсвийн хуваариар олгоход тогтмол хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд 11 дүгээр сарын байдлаар нийт 295,193.8 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 247,797.6 сая төгрөг гүйцэтгэл гаран 16.05%-ын хэмнэлт гарган ажиллаж байна.


ГУРАВДУГААР БҮЛЭГ: “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”

3.1 Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;

“Хан-Уул дүүрэг цахим дүүрэг” болох зорилтын хүрээнд дүүргийн албан ёсны /www.khanuul.mn/ цахим вэб сайтыг шинэчлэн иргэд, төрийн үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй

шуурхай авах нөхцөлийг бүрдүүлсэн. Тухайлбал дүүргийн khanuuul.mn цахим вэб сайтад E-mongolia, Ulaanbaatar.mn, Авиалгатай тэмцэх газар зэрэг дээд байгууллагуудын нийт 10 гаруй төрлийг албан ёсны цахим вэб сайтыг холбож, иргэд төрийн үйлчилгээтэй холбоотой санал хүсэлтээ цахимаар авах нөхцөлийг бүрдүүлсэн.

Засаг даргын дэргэдэх хэлтэс албадын цахим вэб сайтыг дүүргийн төв сайтад холбон, холбогдох мэдээ, мэдээллийг бүрэн шинэчилсэн.



Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр:

Хан-Уул дүүргээс зохион байгуулж буй үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэх, сурталчлан таниулах хүрээнд хэвлэл мэдээллийн **31** байгууллагатай хамтран **5463** мэдээ, мэдээ мэдээллийг иргэдэд хүргэсэн.



Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын нийт **615** мэдээг, **465** видео, **725** постер, **205** шторк, **98** рийл мэдээ, мэдээлэлд хяналт тавин **Хан-Уул Эко дүүрэг** болон бусад мэдээллийн цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээллийг шуурхай хүргэсэн.

“Эко дүүрэгт Энэ 7 хоногт” цахим хуудаст үйл ажиллагааны мэдээллийг тоймлон 7 хоног бүрийн бямба гараг бүр бэлтгэн гаргаж хэвшсэн. Тухайлбал 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 69 удаа тойм мэдээ, мэдээллийг тоймлон хүргэсэн.

Мөн “Хан-Уул Эко дүүрэгт” твиттер хаяг нээж, үйл ажиллагааны товч мэдээллийг тухай бүр нийтлэхийн зэрэгцээ цаг үеийн холбогдолтой нэлэөллийн “КОНТЕНТ”-ыг бэлтгүүлж, хяналт тавин ажиллаж байна.




ХЭВЛЭМЭЛ болон QR ЦАХИМ сэтгүүл:

Хан-Уул дүүрэгт 2021-2022 онд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн бүтээн байгуулалт, тохижилтын ажлыг багтаасан "Бүтээгч Хан-Уулчууд" фото мэдээллийн сэтгүүлийг эмхэтгэн хэвлүүлж иргэдэд хүргэсэн. Мөн тус сэтгүүлийг QR кодтой цахим хэлбэрт хувирган олон нийтийн сүлжээ, цахим вэб сайтад байршуулан сурталчилсан.




“Чатбот” үйлчилгээг нэвтрүүлсэн талаар:

“Цахим дүүрэг” зорилтын хүрээнд дүүргийн албан ёсны khanuul.mn цахим вэб сайтад “Чатбот” үйлчилгээг анхлан нэвтрүүлж, Хан-Уул Эко дүүрэг цахим хуудсыг холбосон. Чат бот үйлчилгээг нэвтрэгүүлснээр төрийн үйлчилгээтэй холбоотой лавлагаа, мэдээллийг иргэдэд цахимаар шуурхай хүргэн ажилласан. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт **35.914** иргэн www.khanuul.mn цахим вэб сайтад хандан, **10,145** иргэн чатбotoор асуулт асууж, **548** талархал, **205** гомдол санал тавьж, холбогдох чиг үүргийн байгууллагууд руу уламжилж, санал хүсэлтийг шийдвэрлэсэн.



“ХАН-УУЛ ЭКО ДҮҮРЭГ” цахим хуудаст нийт 1087 мэдээ, 365 видео,шторк, 516 постер мэдээ, мэдээлэл байршуулж, чатаар 1586 асуулт, комментоор 854 асуулт, 528 талархал, 367 санал, нийт 1,312,200 иргэн цахим хуудас руу хандсан байна. Өмнөх онтой харьцуулахад тус хуудасны дагачдын тоо 26,895 хүрч, өдөрт дунджаар 23 мянган хүн тус хуудаст хандан мэдээ, мэдээлэл тогтмол авч хэвшсэн.



“ТОВЧ МЭДЭЭ-ЭКО ДҮҮРЭГТ” цахим хуудаст 785 мэдээлэл, 95 рийл, 87 стори оруулж, чатаар 3456 коментоор 721 асуулт тус тус ирснийг тухай бүр нь шийдвэрлэсэн. “Товч мэдээ-Эко дүүрэгт” цахим хуудасны дагагчдын тоо 20,895.



“ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН БҮЛЭГ” цахим бүлгэмд нийт 1,685.602 мэдээ, видео, шторк, постер байршуулж, 29,900 (+3700) гишүүнтэй болсон байна. Өдөрт дунджаар +825,000 удаа иргэд хандаж, нийт 1,525 комент, чатаар ирсэнд тухай бүр хариулт өгч хэвшсэн.

Төрийн үйлчилгээтэй холбоотой мэдээ, мэдээлэл, зөвлөмж, видеог нөхөж болон ухраан үзэх боломжтой болсон. Тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төрийн үйлчилгээний мэдээлэл, дээд байгууллагын хууль, тогтоомж, мэдээллийн видео, шторкыг нөхөж үзэн, 24 цагаар тус цахим хуудаснаас тогтмол авах боломж нөхцөлийг хангаж, “Facebook, Youtube, Chatbot” зэрэг цахим хаягтай шууд холбогдож ажиллах технологийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн үйлчилгээг цахимжуулах тал дээр шинэчлэл хийх ажлыг чиг үүргийн дагуу үе шаттай хийсэн.


3.2 Төсөөв санхүүгийн ил тод байдлыг хангасан буюу шилэн дансны хөтлөлтийн байдал, үр дүн;

Санхүү, бүртгэлийн чиглэлээр:


Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн Олон улсын стандартын дагуу анхан шатны баримтын бурдлийг хангасан харилцахын гүйлгээнүүдийг хянаж баталгаажуулсан.

Засаг даргын Тамгын газрын үндсэн дансаар 3045 ширхэг баримтаар 13,240,868,029 төгрөгийн гүйлгээг хянан баталгаажуулсан байна.

Хүснэгтээр харуулбал:




Дүүргийн хөрөнгө оруулалтын харилцахын дансаар 97 компанийн 19,960,670,609 төгрөгийн ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг хянан баталгаажуулсан.




Нэмэлт санхүүжилтийн харилцахын дансны 28 ширхэг баримтаар 75,727,167 төгрөгийн гүйлгээг хянан баталсан.


Санхүүгийн анхан шатны баримтад тулгуурлан бараа материал, хангамжийн 1298 ширхэг баримтаар 1,702,251,188 төгрөгийн орлогын гүйлгээ хянасан.



Тамгын газрын албан хаагчдын ашиглаж буй 39,258,500 төгрөгийн хангамжийн материалыг хариуцсан албан хаагчдад шилжилт хөдөлгөөнийг хянасан.




ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭ



Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, НББОУС-ын дагуу анхан шатны баримт болон холбогдох тушаал шийдвэрийг үндэслэн 7,843,002,662.45 төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авсан. Үүнд:

- Нийслэлийн хөрөнгө оруулалтаар -4,501,986,554.45 төгрөг
- Дүүргийн төсвийн хөрөнгөөр -3,341,016,108 төгрөг

Үндсэн хөрөнгийн орлого /төгрөгөөр/




Ажлаас гарсан болон ажилд шинээр орсон албан хаагчдын эд хөрөнгийг хүлээлцэн, хяналт тавьж ажилласан.

657 ш баримтаар 876,552,797.7
төгрөгийн эд хөрөнгийн шилжилт
хөдөлгөөн хийсэн.


- ❖ Хөрөнгө оруулалтын барьцаа данснаас 2023 оны жилийн эцсийн байдлаар 12 аж ахуйн нэгж, байгууллагын 119,243,567 төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг чөлөөлөхөд хяналт тавьсан.
- ❖ Засаг даргын Тамгын газрын болон 25 хорооны нийт 137 төрийн албан хаагч, хороодын 234 хэсгийн ахлагчийн цалин, 124 ажилтны эзлжийн амралтыг тус тус хянан баталсан.

ЦАЛИН ХӨЛС, НЭМЭГДЭЛ УРАМШУУЛАЛ



Бараа материалын жилийн эцсийн байдлаар нийт 1924 ширхэг баримтаар 1,591,111,267 төгрөгийн зарлагын гүйлгээг шаардах хуудасны дагуу зарлагдаж холбогдох илтгэх хуудас, замын хуудсыг хавсарган баримт бичгийн бүрдлийг хянасан.

Бараа материалыг данс бүрээр харуулбал



2023 оны 1,2,3-р улирлын Хөрөнгө оруулалтын барьцаа сан, Орон нутгийн хөгжлийн сан, Хөрөнгө оруулалтын сан, Байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь Санхүү төрийн сангийн хэлтэст тушааж, баталгаажуулсан.



ШИЛЭН ДАНС

Төсвийн ерөнхийлөн захирагч: Хуулийн хугацаанд төсөв, гүйцэтгэлийн нийт 158 мэдээллийг <https://shilendans.gov.mn/> сайт болон <https://khanuul.mn/> сайтад тухай бүр шинэчлэн байршуулсан.

Төсвийн шууд захирагч: Шилэн дансны мэдээллийн <https://shilendans.gov.mn/> сайтад 2023 оны 12 дугаар байдлаар 110 мэдээг хуулийн хугацаанд нь шинэчлэн байршуулсан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ “Бусад мэдээлэл”

4.1 Холбогдох чиг үүргийн хүрээнд шинээр санаачлан хэрэгжүүлсэн болон онцлог ажил, арга хэмжээ;

“БҮТЭЭГЧ ХАН-УУЛЧУУД-2023” ӨДӨРЛӨГ:

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Баялаг бүтээгч” иргэн аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчлах, төр хувийн хэвшлийн

хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой “Бүтээгч Хан-Уулчууд” өдөрлөгийг 2023 оны 6 дугаар сарын 04-ний өдөр Улаанбаатар хотын хэмжээнд анх удаа зохион байгуулсан.

Өдөрлөгийн арга хэмжээнд төр, хувийн хэвшлийн 100 гаруй аж ахуйн нэгж байгууллагууд хамтран оролцож 6220 иргэнд үйлчилсэн.

Зураг. “Бүтээгч Хан-Уулчууд-2023” өдөрлөгийн үйл явц



ЯВУУЛЫН НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ-2023:

Төрийн үйлчилгээг иргэдэд ойр хүртээмжтэй хүргэх зорилгоор “Явуулын нэг цэгийн үйлчилгээ”-г яармаг, нисэх, алсын бусийн 8, 9,10,12,13,14,16,21,23,24,25 дугаар хороодод 2023 оны 10 дугаар сарын 28,29, 11 дүгээр сарын 04,05-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс, Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Газар зохион байгуулалтын алба зэрэг 6 хэлтэс, албадын 40 орчим албан хаагчид хамтран 30 гаруй нэр төрлийн үйлчилгээг давхардсан тоогоор 3600 гаруй иргэнд хүргэлээ.



“ШИЛДЭГ ХОРОО-ХЭСГИЙН АХЛАГЧ НАРЫН ШИЛДЭГ БАГ” БОЛЗОЛТ УРАЛДААН

“Шилдэг хороо-Хэсгийн ахлагч нарын шилдэг баг” шалгаруулах болзолт уралдааны хүрээнд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/49 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийслэлийн 8 дүүргийн 35 хороонд зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан.


Нийслэлийн Засаг даргын А/461 дүгээр захирамжаар батлагдсан “Шилдэг хороо-Хэсгийн ахлагч нарын шилдэг баг” шалгаруулах болзолт уралдааны нэгдүгээр шатанд дүүргийн 25 хороо оролцож дараах амжилтыг узуулсан. Уунд:

- ❖ 8-р хороо – “Шилдэг хороо”-оор **“ДЭД БАЙР**
 - ❖ 19-р хороо - ”Хэсгийн ахлагч нарын шилдэг баг”-аар **ТУСГАЙ БАЙР**
 - ❖ 6-р хороо - “Шилдэг хороо”-оор **ТУСГАЙ БАЙР**



“МАНАЙ ХОРОО – МИНИЙ ГУДАМЖ” АЯН

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны А/24 дүгээр тушаал, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2023 оны А/105 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт “Манай хороо – Миний гудамж” аяныг зохион байгуулах, шалгаруулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө удирдамжийг батлан, хэрэгжилтийг хангаж ажилласан. Аяныг сурталчлах ажлын хүрээнд УБЗААнаас хийсэн 15 постер, 4 богино хэмжээний контент, 1 рийлийг дүүрэг хорооны цахим хуудсуудаар сурталчилж, үр дүн мэдээллийг өдөр тутам нийслэлийн ажлын хэсэгт хүргүүлж ажилласан.



Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн тохижилт, бүтээн байгуулалт болон хот нийтийн аж ахуйн чиглэлээр зохион байгуулж байгаа ажлуудын мэдээллийг өдөр бүр дүүрэг, хороодын цахим хуудсуудад байршуулж, сурталчилж ажиллаж байна.

Хан-Уул дүүрэг, тохижилт бүтээн байгуулалтын ажлыг сурталчилж буй байдал



Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооноос аяны хүрээнд айл өрхүүдийг идэвхжүүлэх зорилгоор "Манай хороо миний

"гудамж" аяны шилдэг 3 өрхөөс туршлага судлах уулзалтыг зохион байгуулж, 20 гаруй иргэдийг хамруулж ажилласан.

Аяны үр дүн, шалгаруулалт

НОМИНАЦИЙН НЭР ТӨРӨЛ	ЭЗЭЛСЭН БАЙР	
Шилдэг тохижилттой орон сууц хороо	3-р байр	3-р хороо
Шилдэг тохижилттой гэр хороо	1-р байр, Тусгай байр	13-р хороо 6, 16-р хороо
Шилдэг хог тээврийн байгууллага	2-р байр, Тусгай байр	Эко хотын тээвэр ОНӨААТҮГ Хан-Уул Агро ОНӨААТҮГ
Шилдэг зам цэвэрлэгээний байгууллага	1-р байр	Охь мандал ХХК
Шилдэг орон сууцны контор	1-р байр, Тусгай байр	Хайспийд ХХК, Хүннү хотхон ХХК
Шилдэг сууц өмчлөгчдийн холбоо	2-р байр Тусгай байр	Ака-1 СӨХ Цэнгэлдэх өргөө СӨХ



ХАРИЛЦАН СУРАЛЦАХ АРГА ЗҮЙН САЙН ТУРШЛАГА ТОДОРХОЙЛОХ, ТУГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ, НУТАГШУУЛАХ НЬ" БОЛЗОЛТ УРАЛДААН


САЙН ТУРШЛАГА-1: Албан хаагчдын хүүхдийн өрөө

Төрийн албан хаагчид өглөө, оройд хүүхдээ цэцэрлэг, сургуульд зөөхөд гардаг хүндрэлийг багасах, ажлын бүтээмж үр дүнг дээшлүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бий болгох, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалах, төрийн албан хаагчдын ажил амьдралын тэнцвэрт байдлыг хадгалахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Хан-Уул дүүргийн 41 дүгээр цэцэрлэгийн дэргэд "Эко бүлэг" цэцэрлэгийг 2017 онд байгуулж үйл ажиллагааг явуулж байгаа бөгөөд 2022 онд Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан Иргэдэд үйлчлэх төв байранд "Хүүхдийн өрөө"-г тохижуулж, харьялал харгалзахгүй хамруулахаас гадна тус дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын хүүхдийг мөн хамруулах боломжтой байдлаар зохион байгуулсан.



Хүүхдийн өрөөнд өдөр тутам 15 хүүхэд байнгын үйлчлүүлдэг бөгөөд хүүхэд хичээлдээ явахаасаа өмнө болон хичээлээ тараад ээж, аавыгаа хүлээх хугацаандaa хүүхдийн өрөөнд хичээлээ хийх, амрах орчин бүрдүүлсэн. Тус ажил Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хэрэгжүүлэх “Сайн туршлага”-аар шалгарч, нийт төрийн байгууллагуудад нутагшуулахuriалга гаргасан.

“Эко бүлэг” цэцэрлэгт хамрагдсан байдал;



САЙН ТУРШЛАГА-2 Сайн туршлага нутагшуулсан хороод

“Харилцан суралцах арга зүйн сайн туршлага тодорхойлох, танилцуулах, нутагшуулах нь” болзолн уралдаанд оролцох төлөвлөгөөний биелэлтийг 82,7 хувтай хангуйж, дүүргээс 7 хорооны 8 сайн туршлагыг хамруулсан. Тус болзолн уралдааны сайн туршлага нутагшуулсан хороо төрөлд 24 дүгээр хороо **ТЭРГҮҮН БАЙР**, 3 дугаар хорооны “Ангилан ялгах сав байршуулсан нь” сайн туршлага **4-Р БАЙРАНД** тус тус шалгарсан.

“НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн 18 дугаар хороонд Улсын Бүртгэлийн “НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”-ийг шинээр нээлзээ.

Тус нэг цэгийн үйлчилгээ төв нээгдсэнээр Зайсангийн бүс буюу 11,15,17,18,19,22 дугаар хорооны 85 мянган иргэдэд төрийн үйлчилгээ ойртоож, иргэний болон эд хөрөнгийн, хуулийн зэрэг улсын бүртгэлийн бүх төрийн үйлчилгээг харьяалал харгалзахгүй авах боломжтой болсон.



ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ISO 9001:2015, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨГӨЛДӨРШЛИЙН ISO 23592:2021 СТАНДАРТ НЭВТРҮҮЛЛЭЭ.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвийн удирдлага дор Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015, Үйлчилгээний төгөлдөршилийн ISO 23592:2021 стандартыг 2023 оны 04 дүгээр сарын 01-нээс 07 дугаар сарын 01-ний хооронд дүүргийн 22, 23, 25 дугаар хороодод хэрэгжүүлж, "Монсертф" Тохирлын үнэлгээний байгууллагын баталгаажуулалтын зөвлөлийн хурлын 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн D-23/049 дүгээр тогтоолоор стандарт нэвтрүүлсэн анхдагч гэрчилгээ 22, 23, 25 дугаар хороо гардан авч, нэгдсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлэгч байгууллага болсон.



Цаашид бусад хороодод Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015, Үйлчилгээний төгөлдөршилийн ISO 23592:2021 стандартыг үе шаттайгаар нэвтрүүлнэ.

ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ

Ерөнхий боловсролын сургуулийн 11, 12 дугаар ангийн сурагчдын сургалтын чанарыг сайжруулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, суралцах үйл ажиллагааг дэмжих, 2022-2023 оны хичээлийн жилд элсэлтийн ерөнхий шалгалт өгөх сурагчдад дэмжлэг үзүүлэхэд зорилгоор Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит математик, физик, химийн хичээлийн олимпиадыг 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 15, 52, 75 дугаар сургуулиудад зохион байгуулсан. Олимпиадад дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 33 сургуулийн 513 сурагчдаас, амжилттай оролцож, бусдыгаа манлайлсан шилдэг 48 сурагчдад шагналаа гардуулсан.



ФОТО МЭДЭЭЛЛИЙН СЭТГҮҮЛ

Хан-Уул дүүрэгт 2021-2022 онд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн бүтээн байгуулалт, тохижилтын ажлын бүрэн багтаасан фото мэдээллийн сэтгүүлийн эхийг бэлтгэн иргэдэд мэдээ, мэдээллийг шуурхай хүргэсэн. Бүтээн байгуулалтын бүх мэдээлэл багтсан тус сэтгүүлд нийт **2000-3500** орчим зураг, **319** орчим мэдээлэл багтсан бөгөөд QR кодтой тус фото сэтгүүлийг цахим хэлбэрт хувирган дүүргийн **30 гаруй** мянган иргэдэд хүргэсэн.



УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан тэргүүтэй дүүргийн удирдлагууд 25 хорооны албан хаагч, хэсгийн ахлагч нартай 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр уулзалт зохион байгуулж, 2023 онд дүүрэгт хэрэгжсэн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт 2024 онд хэрэгжүүлэх зорилт арга хэмжээний талаар мэдээлэл хийж төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг талаар харилцан санал солилцсон. Уулзалтад нийт 257 албан хаагч оролцсон.



ХОРООДОД ЗӨВЛӨН ТУСЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Хан-Уул дүүргийн 21 хорооны ажилтан, албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, ёс зүй, дотоод ажлын эмх цэгц, мэргэшлийн ур чадварт ахиц гаргах зорилгоор Засаг даргын Тамгын газрын хэлтэс, албад 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн дүүргийн 21 хороодод зөвлөн туслах ажлыг Тамгын газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр баталсан удирдамжийн дагуу зохион байгуулсан.



Зөвлөн туслах ажлыг зохион байгуулснаар хорооны өдөр тутмын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж төрийн албаны стандартын хэрэгжилт хангагдана.

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

С.ЭНХБАЯР

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

З.БУЯНТ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГААНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ч.АРИУНЖАРГАЛ